Цахилгааны шугам	Шувууны анхааралд өртөнө	Шувуу эндэх	3	4	IV	Дизайны сайжруулалт	
			3	4	IV	БОЯБ мониторинг	

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгойн нүүрсний орд газар дахь ил уурхайн үйл ажиллагаанд байгаль орчны нийцлийг хангуулах гол зорилготой.

Төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорилт болгоно. Үүнд:

- ✓ ISO 14001 байгаль орчны удирдлагын тогтолцооны элементүүдийг хэрэгжүүлэх:
- ✓ Байгаль орчны аудит, БОННҮ-ний шаардлагуудыг биелүүлэх:
- ✓ Компанийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах:
- ✓ Гэрээт байгууллагуудын байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, түүний гүйцэтгэлд хяналт тавих, аргазүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах:
- ✓ Уурхайн үйл ажиллагааны талбайн хүрээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангуулахад анхаарч ажиллах:
- ✓ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн хэмжээнд байгаль орчны бодлого, дүрэм, журмыг хэрэгжилтийг хангах:
- ✓ Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглалтын байдалд хяналт тавьж төрийн болон хяналтын байгууллагуудад мэдээ хүргэх:
- ✓ БОМТ-нд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг тодорхойлох:
- ✓ ОХШХ-нд талуудын оролцоог хангах, ил тод нээлттэй байх зарчмыг баримтлах:

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.1.1	Тоос бууруулах бодисыг технологийн замд ашиглана.	10 км	Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогч “ТН түншлэл” 2024 онд 8 км замд тоос бууруулах ажил хийхээр төлөвлөснөөс 5 км замд ашигласан. Цанхийн баруун уурхайн гэрээт “КА майнинг” ХХК 8 км замд ашиглахаар “Эй Эм И Си Ти” ХХК-тай гэрээ байгуулсан. Бодисын захиалга хийгдсэн хүлээгдэж байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК 10 км замд тоос бууруулах ажилд 5.8 тэрбум төгрөг төсөвт суулгаж, захиалга хийгдээд байна.	50%
5.1.2	Уурхайн ашиглалтын замыг сайжруулах: материал, дэвсэлт хийх	10 км	Тоосжилтыг бууруулах зориулалтаар зам, талбайг услах уламжлалт аргыг хэрэглэж байгаа ба уурхай болон хөрсний овоолгын ачаалал ихтэй, тоосжилт ихээр үүсгэж буй зам талбай, уулзвар эргэлтийг тодорхойлж улаан шаварлаг материал болон хайрга, дайрга дэвсэх ажлыг өдөр бүр төлөвлөж гэрээт байгууллагуудаар хийж гүйцэтгүүлдэг. Цанхийн зүүн, баруун уурхайн технологийн замын тоосжилтын түвшинг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг Уулын хэлтэс гаргаж ажиллаж байна.	100%

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.1.3	Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн талбайд усалгааны машиныг тогтмол ажиллуулах	5-аас доошгүй	Уурхайн технологийн автозамаас үүсэж буй тоосжилтыг бууруулах зорилгоор өдөр бүр 10-аас багагүй тооны усны машин ажиллаж усалгаа хийгддэг ба энэ оны эхний 10-н сарын дараах байдлаар нийт 476,277 м^3 усыг зам усалгаанд ашигласан байна. Үүнээс 242,137 м^3 хур бороонд хуримтлагдсан ус, 77,872 м^3 уурхайн шүүрлийн ус, 12,647 м^3 цэвэршүүлсэн саарал ус, 143,621 м^3 гүний усыг авч ашигласан тооцоо байна.	100%
5.1.4	Уурхайн дотоод зам талбайд шороон зам дээгүүр зорчиж буй хөнгөн тэрэг болон уулын машин механизмуудад хурдны хязгаар тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийж хяналт тавих	Сард 3	Уурхайн замын хөдөлгөөнд оролцож буй техникүүдийн хурд хэмжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч байгууллагуудын Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн нар тогтмол 7 хоног бүр гэнэтийн хэмжилтийг хийдэг бөгөөд оны эхний 10 сарын байдлаар Цанхийн зүүн уурхайд 246 удаа, Цанхийн баруун уурхайд 1149 удаа, нийт 1395 удаа хурдны хэмжилт хийсэн байна.	100%
5.1.5	7.4км ачаа тээврийн сайжруулсан шороон замын засвар үйлчилгээ, арчилгааг батлагдсан хуваарийн дагуу хийж гүйцэтгэх, цаашид хатуу хучилттай болгох ажлыг санаачлан зохион байгуулах	7.4км	Цогтцэций-Даланзадгад чиглэлийн замаас Баруун нарангийн автозам хүртэлх 7.4 км автозамын арчилгааг гэрээт байгуулагуудын сар бүрийн төлөвлөгөөнд тусган тухай бүрт хийлгүүлэн ажилласан. 13.5 км автозамыг шинэ суурьшлын бүстэй холбох 2.9 км автозамын ажил хийгдэж байгаа бөгөөд энэ зам ашиглалтад орсны дараа бүх тээврийг тухайн замаар зорчуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	100%
5.1.6	Нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Тогтмол	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нүүрс ачилтын хэлтэст 4-н ээлжинд нийт 32 хучигч ээлжээр ажилладаг ба нүүрс тээврийн ачаатай машиныг хучих ажлыг хариуцан гүйцэтгэдэг тул хучилт хийлгээгүй машин уурхайн бүсээс гарах боломжгүй байдаг.	100%
5.1.7	Нүүрс ачилтын талбайд усалгаа хийх	Жилийн турш	Нүүрс ачилтын зам талбайд батлагдсан хуваарийн дагуу усалгааг өдөр бүр хийж байна. 2024 оны 10-р сарын байдлаар “КА майнинг” ХХК-ны бохир цэвэрлэх байгууламжид цэвэршүүлсэн саарал ус, “Энержи Ресурс” ХХК-ийн цэвэршүүлэх байгууламжаас цэвэршүүлсэн саарал ус, худаг №7 болон гадаргын усыг усалгаанд ашигласан. 2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 33,655 м3 усыг тоосжилт дарах зорилгоор ашигласан байна.	100%
5.1.8	Ашиглаж буй техник хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах	-	Уурхайн хөдөлгөөнт техникүүд болох экскаватор, өөрөө буулгагч, дугуйт ачигч, грейдэр, бульдозерууд болон хөнгөн тэргийг тус тус тээврийн хэрэгслийн техникийн үзлэг, оношилгоонд хамруулсан.	100%


№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.1.9	Нам даралтын зуухны яндангаар ялгарах хорт хийн хэмжилт хийх, хяналт тавих	2	“Ногоон титэм” ХХК-тай “Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ хийлгэх гэрээ” байгуулан 2024.05.26-ны өдөр Грийн центрийн уурын зуухын яндангаас ялгарах хийн /NO_2, CO_2, SO_2, CO, H_2S/ үзүүлэлтүүдийг 1 удаа шинжлүүлсэн. Мөн Multi Gas Detector гар багажийг ашиглан 5, 6, 10 саруудад CH_4, O_2, CO, H_2S үзүүлэлтийг хэмжсэн.	100%
5.1.10	Агаарын чанарын суурин станцны худалдан авалтыг хийж, БОАЖГ-т дүн мэдээг онлайнаар өгч байх	1	2024 оны Компанийн хөрөнгө оруулалтын төсөвт “Агаарын чанарын суурин станц”-ыг худалдан авах 228,525,413 төгрөгийг суулгасан. Уг төсвийн дагуу №230 дугаартай худалдан авалтын захиалгыг 2024 оны 04 сарын 11-нд худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулсан боловч оролцогч оролцоогүй шалтгаанаар амжилтгүй болсон. 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдөр захиалгыг дахин шинэчлэхээр үнийн санал авахад инфляцаас шалтгаалан төсөвт суулгасан үнийн дүнгээс 20%-аар өссөн. Иймд үнийн дүнд таарсан техникийн тодорхойлолтыг шинэчлэн 2024 оны 10 дугаар сарын 18-нд тендер зарлаж 2024 оны 11-р сарын 11-нд тендер нээсэн ба тендерт оролцсон 2 байгууллага шаардлага хангаагүй тул дахин тендер зарлахаар болсон.	50%

5.1.1 Тоос бууруулах технологийн туршилт хийх

2021-2023 онуудад тоосжилтыг бууруулах зорилгоор замын гадаргууг хайрга, дайргаар хучих, замын гадаргуугийн чийгийн агууламжийг нэмэгдүүлж усалгаа хийх мөн ус үл нэвтрүүлэх давхарга үүсгэх, хөрсийг барьцалдуулж нягтруулан бүрхүүл үүсгэх зэрэг аргуудаас тохиромжтой хувилбарыг сонгохоор 2-3 төрлийн тоос бууруулах бодисыг Цанхийн уурхайн хэмжээнд турших ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

2024 онд уг туршилтанд үндэслэж уурхайн нийт гадаргын замын хэмжээг гаргаж түүнд шаардагдах тоос бууруулах бодисын тооцоог гаргасан. Тооцоогоор уурхайн нийт гадаргын зам 43.4 км байгаа ба өмнөх туршилт хийгдсэн бодисуудаас “Эко сойл” ХХК-ийн нийлүүлдэг Лигно уусмал харьцангуй өндөр үр дүнтэй гэж үзсэн.

Тус төлөвлөгөөний дагуу 2024.05.31-2024.06.09-ний хооронд Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогч “ТН түншлэл” нийт 5 км технологийн замд 30 тн тоос бууруулах Дастлок плас тоос дарагч бүтээгдэхүүнийг ашиглан тоосжилт бууруулах ажлыг хийж гүйцэтгээд байна. Дастлок плас бодис нь лигнин, битум полимер эмульс, битум эмульс гэсэн байгальд хоргүй, хөрс барьцалдуулагч, тогтворжуулагч бодисуудаас бүрдэх ба замын нөхцөл байдалд тохируулан хоорондын харьцааг 3-н янзын концентрацаар хольж туршсан.



Зураг № 2. Уурхайн хэмжээнд тоос буурууллах бодис ашиглах гадаргын замын төлөвлөгөөний зураг



Зураг № 3. Замын суурийг сийрүүлэн хөрстэй хольж бодис цацах бэлтгэл ажил хийж буй байдал



Зураг № 4. Бодис хэрэглэхийн өмнөх зам чийгшүүлэх усалгаа болон бодисыг усанд найруулж буй байдал




Зураг № 5. Бодисыг замд холих, индүүдлэг хийж буй байдал.



Зураг № 6. Бодис дэвсэж нягтаршуулалт хийсэний дараах байдал

Цанхийн баруун уурхайн олборлогч “КА майнинг” ХХК нь “Эй Эм И Си Ти” ХХК-тай гэрээ байгуулан 8 км замд тоосжилт бууруулах бодис ашиглахаар захиалга хийгдсэн. Гэрээлэгч компани бодисыг Монгол улсад импортлон оруулж ирэх ажил хүлээгдэж байна.



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2024 оны 06-р сарын 12-ны одор Дүүрэг Улаанбаатар хот

	Гүйцэтгэгч тал		Захиалагч тал
Компанийн нэр	"ЭМ И СИ ТИ ЭС " ХХК	Компанийн нэр	"КЭЙ ЭЙ МАЙНИНГ" ХХК
Регистр	5577055	Регистр	6164269
Утас	88882198	Утас	9191/9953
Цахим хаяг	sales@mecn.mn	Цахим хаяг	Nomin.ya@ka-mining.mn
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, оюутны, Voli tower 1001 /6/	Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Жёлтый гүний гудамж А8 Си Си тауэр 7 давхар 701 тоот

Нэг. Ерөнхий нөхцөл

1.1. Нэг талаас **"ЭМ И СИ ТИ ЭС" ХХК**-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Мамаа овогтой Буяннэмэх /цаашид **"Гүйцэтгэгч тал"** гэх/ нөгөө талаас **"Кэй Эй Майнинг"** Удирдлагын зүтгэлтэн тушаасан **ХХК**-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Батхуяг овогтой Энхбаяр /цаашид **"Захиалагч тал"** гэх/ нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ /цаашид **"Гэрээ"** гэх/-г байгуулав.

1.2. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал **"Эрдэнэс Тавантолгой"** ХК-ийн тальсан нөөцлөлт, өсөлтийн дагуу /*хавсралт 1*/ заасан Тоосжилт бууруулах бодис ашиглах, түрэвч ажлыг гүйцэтгэж, **"Эрдэнэс Тавантолгой"** ХК-ийн Байгаль орчин хэсэг нь бодлогын газрын дүгнүүдэх ба Захиалагч талуудын ажлын төлбөр төлөх болон Гүйцэтгэгч талын гүйцэтгэх ажил үүрэгтэй холбоотой харилцаа зохицуулах, талуудын харилцан хүлээх эрх, үүрэг хариуцлагыг тогтоохад оршино.

1.3. Энэхүү гэрээнд заасан ажил үүргийг Гүйцэтгэгч тал захиалагчаас ажил эхлүүлэх захиалга өгснөөс хойш хуанлийн 45 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Хоёр. Төлбөр тооцоо

2.1. Гэрээний 1.2-т заасан Гэрээний үнийн дүн /*хавсралт 2*/-д заасан тогтоо болно.

2.2. Гэрээний нөлөөгүй холбоодуулан энэхүү гэрээ байгуулагдаж, талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдэг дарж батлагдсанаар Захиалагч захиалга өгсөн өдрөөс гэрээний урьдчилгаа төлбөр болох 80%-ийг, гэрээгээр хийдэх ажил дуусч ЭТТ ХК-н Байгаль орчин хэсэг нь бодлогын газрар дүгнүүлсэн баримтыг үндэслэн үлийн дүнгийн үлдэгдэл 20%-ийг шилжүүлнэ.

6.7. Энэхүү гэрээний хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.

6.8. Гэрээ Монгол хэлээр гурван хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалсан ба хүчин эгүйн хувь адил ижилхэн байна.

6.9. Хэрэв талуудын зохицуулж чадаагүй гарсан нийт мэтгэлцээнийг эцэслэн шийдвэрлэх эрхлэлт ба нийт мэтгэлцээ нөхцөлөөс шийдвэрлэх бүхэлдэй эрхэм Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН :

"ЭМ И СИ ТИ ЭС" ХХК	"КЭЙ ЭЙ МАЙНИНГ" ХХК-ИЙН
/Б.СОРОНЗОНБОЛД/	/Д.ЭНХБАЯР/

Зураг № 7. Тоос бууруулах бодис ашиглах гэрээ байгуулсан байдал

Тоос бууруулах бодис ашиглах төлөвлөгөөний хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК нь нийт 10 км автозамд Лигно уусмал бодисыг жилийн турш хэрэглэхэд шаардлагатай

судалгааг хийсэн бөгөөд 1 м^2 талбайд бодис ашиглах боломжит хугацаанд 7 литр бодис шаардлагатай судалгаа гарсан.


Иймд Компанийн 2024 оны үйл ажиллагааны төсөвт тоосжилт дарах бодис ашиглах зориулалтаар 5.8 тэрбум төгрөг төсөвлөсөн ба захиалгын хуудсыг боловсруулж худалдан авалтын албанд хүргүүлээд байна.

Хүснэгт № 8. Нэгж талбайд зарцуулах бодисыг тооцсон байдал

Долоо хоног	Шүрших давтамж	Усанд найруулах харьцаа	Нэгж талбайд зарцуулах хэмжээ /1л/м^2 цацах үед/	Зарцуулалт 1л/м^2	Хуримтлагдсан зарцуулалт Лигно л/м^2
I	Хоногт- 2 удаа	1:10	0.1 л/м^2	1.40	1.4
II	Хоногт- 2 удаа	1:15	0.06 л/м^2	0.84	2.24
III-V	Хоногт- -1 удаа	1:15	0.06 л/м^2	1.14	3.38
VI-X	7 Хоногт- 1 удаа	1:15	0.06 л/м^2	3.6	5.18
XI-XXXV	7 хоногт- 2 удаа	1:15	0.06 л/м^2	3.6	**6.98**

5.1.2 Уурхайн ашиглалтын замыг сайжруулах

Уулын ашиглалт болон төлөвлөлтийн нэгжтэй хамтран уурхайн технологийн зам талбай болон хөрсний овоолгын ачаалал ихтэй, тоосжилт ихээр үүсгэж буй зам талбай, уулзвар эргэлтийг тодорхойлж тоосжилтыг бууруулах зорилгоор зам талбайг чийглэх усалгааны уламжлалт аргыг хэрэглэж байгаагаас гадна замын арчилгааг тогтмол хийж улаан шаварлаг материал, хайрга, дайрга дэвсэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлдэг. Цанхийн зүүн, баруун уурхайн технологийн замын тоосжилтын түвшинг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг Уулын хэлтэс гаргаж ажиллаж байна. (Хавсралт №1)



Зураг № 8. Өдөр тутмын зам арчилгаа, дэвсэлт хийх төлөвөлгөөний зураг

Гэрээт байгууллагууд тухайн төлөвлөгөөний дагуу шаардлагатай хайрга дайрга, улаан шаварлаг материалыг татан авч өдөр шөнийн ээлжинд заагдсан талбайд дэвсэж, түйрэнг хусан замын арчилгааг хийж гүйцэтгэн KPI үнэлгээний тайланд тухайн сарын зам арчилгааны тайлан мэдээг тогтмол ирүүлж ажилладаг.



Зураг № 9. Зам засварын төлөвлөгөөний дагуу ажлыг гүйцэтгэсэн тайлан ирүүлсэн байдал



Зураг № 10. Хайрган материал дэвсэлтийн дараах зураг

Цанхийн баруун уурхайд Үндэсний оператор түншлэл, Үндэсний уурхайчин түншлэл, Овоот толгой ресурс ХХК тус тус үйл ажиллагаа явуулж байгаа ба усны машин-10ш, зам арчилгааны дугуйт түрэгч /грейдер/-13ш, дугуйт ачигч /лоадер/- 19ш тус тус ашиглаж байна.

Цанхийн зүүн уурхайд Ти Эн Түншлэл, Кэй Эй Майнинг ХХК олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа ба зам арчилгаанд усны машин-6ш, замын арчилгааны дугуйт түрэгч /грейдер/-6ш, дугуйт ачигч /лоадер/- 3ш тус тус ашиглаж байна. Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн өөрийн эзэмшлийн 2ш усны машин, 1ш дугуйт ачигч, 3ш дугуйт түрэгч зам арчилгаанд ажиллаж байна.

5.1.3 Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн талбайд усалгааны машиныг тогтмол ажиллуулах


Уурхайн технологийн автозамаас үүсэж буй тоосжилтыг бууруулах зорилгоор өдөр тутам 10-аас багагүй тооны усны машин ажиллаж усалгаа хийгддэг ба энэ оны эхний 10-н сарын байдлаар нийт 476,277 м^3 усыг зам усалгаанд ашигласан байна. Үүнээс 242,137 м^3 хур бороонд хуримтлагдсан ус, 77,872 м^3 уурхайн шүүрлийн ус, 12,647 м^3 цэвэршүүлсэн саарал ус, 143,621 м^3 гүний усыг авч ашигласан тооцоо байна.

Ашигласан усны хэрэглээг үндэслэн 2024 онд Өмнөговь аймгийн төрийн сангийн дансанд 79,126,410 төг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт № 9. 2024 оны усны хэрэглээ

Зориулалт	Зам усалгаа				Унд ахуй	Мод усалгаа	Нийт
Нийт	476,277				26,452	8,657	
Эх үүсвэр	Хур бороо	Шүүрэл	Худаг	Саарал ус	Худаг	Худаг	
I	-	1460	5281	-	2552		9,293
II	-	2705	8666	770	2214		14,355
III	13345	3185	21464	-	2237	393	40,624
IV	3558	11819	33186	2317	2584	1169	54,633
V	26281	6774	16085	440	3454	820	53,854
VI	16418	13524	20199	2640	2722	1350	56,853
VII	26912	11819	12584	640	3035	1471	56,461
VIII	40064	6774	6028	1720	2444	1308	58,338
IX	64188	13524	11076	2180	2813	1271	95,052
X	51371	6288	9052	1940	2397	875	71,923
Нийт	**242,137**	**77,872**	**143,621**	**12,647**	**26,452**	**8,657**	**511,386**


Зам усалгаанд ашигласан 476,277 м^3 уснаас Цанхийн баруун, зүүн уурхайн болон нүүрс ачилтын талбайн ус ашиглалтын байдлыг авч үзвэл Цанхийн зүүн уурхай нийт ашигласан усны 55%-ийг, Цанхийн баруун уурхай 33%-ийг Нүүрс ачилтын хэсэгт 12%-ийг тус ашигласан байна.



Диаграмм № 1. Зам усалгаанд ашигласан усны хэмжээ болон эх үүсвэр


5.1.4 Уулын машин механизмуудад хурдны хязгаар тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийж хяналт тавих

“Уурхайн замын хөдөлгөөний журам” (ЭТТ-СА-Ж17-ХАБ-Ж03-Х03) дугаар бүхий журмыг 2023 оны 06-р сарын 06-ны өдрийн Салбарын захирлын А/32 тоот тушаалаар шинэчлэн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уг журамд Технологийн зам (уурхайн ухаш, гадаргуу, овоолго)-д 40 км/цаг, налуу замд 20 км/цаг, ачилт болон буулгалтын талбайд 20 км/цаг, засвар болон зогсоолын гадна талбайд 10 км/цаг, засварын байр болон автожин дээр 5 км/цаг хурдтай байхаар зааж өгсөн.



Зураг № 11. Шинэчлэн батлуулсан уурхайн замын хөдөлгөөний журмын зураг


Уурхайн замын хөдөлгөөнд оролцож буй техникүүдийн хурд хэмжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч байгууллага болгон Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн нар тогтмол 7 хоног бүр гэнэтийн хэмжилтийг хийдэг бөгөөд оны эхний 10 сарын дараах байдлаар Цанхийн зүүн уурхайд 246 удаа, Цанхийн баруун уурхайд 1149 удаа, нийтдээ 1395 удаа хэмжилтийг хийсэн байна.



Зураг № 12. Хурд хэмжилтийн бүртгэлийн хуудасны зураг


5.1.5 7.4км ачаа тээврийн сайжруулсан шороон замын засвар үйлчилгээ, арчилгааг батлагдсан хуваарийн дагуу хийж гүйцэтгэх, цаашид хатуу хучилттай болгох ажлыг санаачлан зохион байгуулах

Цогтцэций-Даланзадгад чиглэлийн замаас Баруун нарангийн автозам хүртэлх 7.4 км автозамын арчилгааг гэрээт байгууллагуудын сар бүрийн төлөвлөгөөнд тусган тухай бүрт хийлгүүлэн ажилласан.



Зураг № 13. Гэрээт байгууллагуудын сарын төлөвлөгөөнд зам арчилгаа хийж гүйцэтгэх талаар тусгасан байдал

Мөн орон нутгийн хүсэлтээр зам арчилгааг нэмэлтээр хийх шаардлагатай тохиолдолд Салбарын захирал болон түүнийг орлож буй албан тушаалтнаар тухай бүр төлөвлөгөө батлуулан зам арчилгааг хийж гүйцэтгэсэн. Батлагдсан зам арчилгааны хуваарийн дагуу замыг засварлахаас гадна Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн Засаг даргын хүсэлтийн дагуу нүүрс тээврийн машинуудыг замын трассаас гарахгүй байхад анхаарах зорилгоор замын 2 талын хөвөөг өндөрлөх ажил мөн хийгдсэн.



БАТЛАВ.
БАЙГАЛЬ ОРЧИН УСНЫ БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
О.ГҮРРАГЧАА

НҮҮРС ТЭЭВРИЙН 7.4 КМ САЙЖРУУЛСАН ШОРООН ЗАМД АРЧИЛГАА ХИЙХ ХУВААРЬ

2024 оны 02 сарын 09 — Өмнөговь, Цогтцэций сум

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Зам арчилгаа, усалгаа хийх хуваарь	Санамж
1	"Ти Эн" түншлэл, "Үндэсний Оператор" түншлэл	02 сарын 16	Төлөвлөгөөт хугацаанд замын арчилгааг чанартай сайн хийж гүйцэтгэн зургаар баримтжуулж ажиллана.
2	"Үндэсний Уурхайчин" түншлэл, "Кэй Эй Майнинг" ХХК	02 сарын 29	

Боловсруулсан
Байгаль орчны мэргэжилтэн О.Үнэнхүү

БАТЛАВ.
ХӨДӨЛМӨРИЙН АЖУЛГҮЙ БАЙДАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА
Б.БАТСАЙХАН

Цогтцэций Шаргэзэгийн авто замаас Барууннаранлын замын зам арчилгааны хуваарь

2024 оны 09 сарын 11-ны өдөр — Өмнөговь, Цогтцэций сум

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Талбайн хуваарилалт	Зам арчилгаа, усалгаа хийх хуваарь	Санамж
1	Ти Эн түншлэл	A блок	09 сарын 14 09 сарын 21	Төлөвлөгөөт хугацаанд замын арчилгааг чанартай сайн хийж гүйцэтгэн тайлан боловсруулж баримтжуулж ажиллана.
2	Үндэсний оператор түншлэл	B блок		
3	Овоот толгой ресурсес ХХК	C блок		
4	Үндэсний уурхайчид түншлэл	D блок		
5	Кэй Эй Майнинг ХХК	E блок		
6	Үндэсний мэнэйлал түншлэл	F блок		

Хуваарилагдсан талбайн зам арчилгаа хийх байгаа замын хөвөө талаас 50м зайтай хог цэвэрлэгээ зохион байгуулж салаа замын хэлтэлга дэлэнг сэргээж засаж өндөрлөж ажиллах.

ХЯНАСАН:
АХЛАН ИНЖЕНЕР /БАЙГАЛЬ ОРЧНЫ/ Б.ОРГИЛ
БОЛОВСРУУЛСАН:
ИНЖЕНЕР /БАЙГАЛЬ ОРЧНЫ/ Б.ОНОН

Зураг № 14. Зам арчилгаа хийх тухай бүрийн батлагдсан хуваарь



Зураг № 15. Зам арчилгааны ажил хийж буй байдал.



Зураг № 16. Замын арчилгааг хийж дууссаны дараах байдал

7.4 км замыг хатуу хучилттай болгох ажлын хүрээнд Компанийн удирдлагууд болон Цагаан-овоо багийн засагтай даргатай зөвшилцсөн. Цогтцэций сумын төвийг шинэ суурьшлын бүстэй холбох 2.92 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг “Жинчингранд” ХХК гүйцэтгэж байгаа тул дахин хатуу хучилттай зам хийж, бэлчээрийн хуваагдал үүсгэхгүй байх зорилгоор тус замыг ашиглалтанд орохоор 7.4км замыг хааж, 2.9км хатуу хучилттай замаар зорчуулахаар шийдвэрлэсэн. Иймд бид тус замыг ашиглалтанд орох хүртэл 7.4км замын арчилгааг тогтмол хийж ажиллана.



Мөн 7.4 км замыг ашиглахаа больсны дараа нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төлөвлөж байна.

5.1.6 Нүүрс тээврийн машинуудын ачааг хучлагатай байлгах, хяналт тавих

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нүүрс ачилт, логистикийн хэлтэст 4-н ээлжинд нийт 32 хучигч ээлжээр ажилладаг ба нүүрс тээврийн ачаатай машиныг хучих ажлыг хариуцан гүйцэтгэдэг тул хучилт хийлгээгүй машин уурхайн бүсээс гарах боломжгүй байдаг.



Зураг № 17. Ачилтаас гарч буй тээврийн хэрэгсэлд хучлага хучиж буй байдал

5.1.7 Нүүрс ачилтын талбайд усалгаа хийх

Нүүрс ачилтын зам талбайд батлагдсан хуваарийн дагуу усалгааг өдөр бүр хийж байна. 2024 оны 10-р сарын байдлаар “КА майнинг” ХХК-ны бохир цэвэрлэх байгууламжид цэвэршүүлсэн саарал ус, “Энержи Ресурс” ХХК-ийн цэвэршүүлэх байгууламжаас цэвэршүүлсэн саарал ус, худаг №7 болон гадаргын уснаас нийт 33655 м3 усыг зам усалгаанд ашигласан.



Зураг № 18. Нүүрс ачилтын талбайд усалгаа хийж буй байдал

Хүснэгт № 10. Зам усалгаанд ашигласан усны хэмжээ

Ангилал	Сарууд										Нийт
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	
Худаг	417	1235	2280	1438	20	1100	320	-	-	-	**6810**
Шүүрэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	**0**
Гадарга	-	-	-	-	-	60	640	1100	700	40	**2540**
ER БУЦБ	-	-	-	-	400	420	380	-	-	-	**1200**
КА БУЦБ	2432	1240	3400	2460	3673	2340	2300	2080	2600	580	**23105**
НИЙТ	**2849**	**2475**	**5680**	**3898**	**4093**	**3920**	**3640**	**3180**	**3300**	**620**	**33655**


5.1.8 Ашиглаж буй техник хэрэгслүүдийг Автотээврийн хяналтын үзлэгт хамруулах

Уурхайн хөдөлгөөнт техникүүд болох экскаватор, өөрөө буулгагч, дугуйт ачигч, грейдэр, бульдозерууд болон хөнгөн тэргийг тус тус тээврийн хэрэгслийн техникийн үзлэг, оношилгоонд хамруулсан.

Хүснэгт № 11. Улсын үзлэгт оруулсан техникүүдийн тоо.

№	Уурхай	Компани	Хяналтын үзлэгт орсон техникийн тоо

			Уулын техник	Хүнд оврын техник	Хөнгөн тэрэг
1	ЦЗУ	ТТЖВ ХХК	87	11	43
2		Нормаунт ХХК	91	30	24
3		ЭТТ ХК			
4	ЦБУ	YOT	284	60	40
5		OTP ХХК	194	32	29



Зураг № 19. Техник хэрэгслүүдийг Автотээврийн улсын үзлэгт хамруулсан байдал

5.1.9 Нам даралтын зуухны яндангаар ялгарах хорт хийн хэмжилт хийх, хяналт тавих

Тайлант онд “Ногоон титэм” ХХК-тай гэрээ байгуулан “Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ”-г 2024.05.26-ны өдөр уурын зуухын яндангаас ялгарах хийн /NO2, CO2, SO2, CO, H2S/ үзүүлэлтүүдийн хэмжилтийг 1 удаа хийлгэсэн. Мөн Multi Gas Detector гар багажийг ашиглан 5, 6, 10 саруудад CH4, O2, CO, H2S үзүүлэлтийг шинэ хотхоны уурын зууханд хийсэн.



Зураг № 20. Нам даралтын зуухны яндангаар ялгарах хорт хийн хэмжилт хийж буй байдал


Хүснэгт № 12. Хэмжилтийн дүн шинжилгээ

Row Labels	CO	CO2	H2S	NO2	SO2	Формальдегид	CH2	O2
2024.03.02								
Ажилчдын хотхонд/TTJV/	0	1129048.2	0	31.55	0			
2024.03.21								
Амрах хотхон /KAM/				24	18			
2024.05.25								
Ажилчдын хотхон/TTJV/	0	1396387.92	0	41.36	169.3			
2024.05.26								
Шинэ хотхоны уурын зуух	0		0	87.58	127.6	0.76		
2024.06.11								
Амрах хотхон /KAM/				16	19			
2024.08.24								
Ажилчдын хотхон/TTJV/	0	1477822.2	0	29.75	34.3			
2024.09.13								
Амрах хотхон /KAM/				6	9			
2024.06.08								
Шинэ хотхоны уурын зуух	1		0	87.58	127.6			
202410.29								
Шинэ хотхоны уурын зуух	9		0				0	20.9

Монгол улсын стандарт MNS5919:2008 Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих аргатай шинжилгээний дүнг харьцуулж үзэхэд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гараагүй болно.

5.1.10 Агаарын чанарын суурин станцын худалдан авалтыг хийх

2024 оны төсөвт “Агаарын чанарын суурин станц” худалдан авалт хийхээр 228,525,413 төгрөгийг суулгасан. Уг төсвийн дагуу №230 дугаартай худалдан авалтын захиалгыг 2024 оны 04 дүгээр сарын 11-нд худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулсан боловч оролцогч оролцоогүй шалтгаанаар амжилтгүй болсон. 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдөр захиалгыг дахин шинэчлэхээр үнийн санал авахад инфляцаас шалтгаалан төсөвт суулгасан үнийн дүнгээс 20%-аар өссөн байсан. Иймд үнийн дүнд таарсан техникийн тодорхойлолтыг шинэчлэн 2024 оны 10 дугаар сарын 10-нд ХААГ-т хүргүүлсэн. 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр тендер зарлаж 2024 оны 11-р сарын 11-нд тендер нээсэн. Тендерт 2 байгууллага оролцсон боловч тендерийн баримт бичигт нийцэх байгууллага шалгараагүй тул дахин тендер зарлахаар болсон.



Зураг № 21. Тендер шалгаруулалт зарласан байдал

5.2 Гадаргын болон газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ


№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.2.1	Худагт бохирдол алдагдахаас сэргийлэх, холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавина.	Нийт худаг	Унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй худгуудын усны чанар, түвшингийн өөрчлөлт, ундарга зэргийг тогтмол хянах зорилгоор түвшингийн хэмжилтийг 7 хоногт 2 удаа, ундаргын тооцооллыг сард 1 удаа, усны шинжилгээг улиралд 1 удаа тус тус хийж гүйцэтгэн ажиллаж байна. Мөн хэмжилтийн үр дүнг боловсруулж, хагас жил болон жилийн эцсийн байдлаар ус ашиглалтын тайланг боловсруулж, Өмнөговь аймгийн БОАЖГ, ГӨДСГ, Усны газарт тус тус тогтмол тайлагнан ажиллаж байна	100%
5.2.2	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авах, ус ашиглах гэрээ байгуулах	1	**Цанхийн зүүн уурхайн 2024 оны ус ашиглах дүгнэлтийг 2024 оны 04 дүгэр сарын 02-ны өдрийн 01/373 дугаартай албан бичиг, Цанхийн баруун уурхайн 2024 оны ус ашиглах дүгнэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/372 дугаартай албан бичгээр тус тус гаргуулж авсан.** **“Галба Өөш Долоодын Говийн Сав газрын захиргаатай 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 2024/06, ЕТТ-2024/1120 дугаартай Ус ашиглах гэрээ байгуулсан**.	100%

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.2.3	Усны нөөц ашигласны төлбөр төлөх, ус ашиглуулах дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ашиглах	12	Худгаас ашигласан усны ашиглалт тус бүрээр үзвэл унд ахуйн усны хэрэглээ 14.5%, мод усалгаанд ашиглаж буй усны хэрэглээ 5.4%, зам усалгаанд ашиглаж буй усны хэрэглээ 80% байна. Нийт ашигласан усанд эзлэх гүний усны хэрэглээ 35.5%, шүүрлийн усны хэрэглээ 12.48%, гадаргын усны хэрэглээ 48.64%, дахин ашигласан буюу саарал усны хэрэглээ 3.38%-ийн гүйцэтгэлтэй байна.	100%
5.2.4	Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулан төлбөр төлөх	4	Хаягдал ус зайлуулах зөвшөөрлийг үндэслэн “Хаягдал усыг байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй байгуулах ус бохирдуулсны төлбөрийн гэрээ”-г 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Галба-Өөш, Долоодын Говийн сав газрын захиргаатай байгуулсан. Гэрээний дагуу улирал тутам цэвэрлэх байгууламжуудын оролт, гаралтын бохир уснаас дээж авч лабораторид шинжлүүлэн Усны газраар төлбөрийн тооцоог гаргуулан төлбөрийг тогтмол төлж байна.	100%
5.2.5	Зам усалгаанд гадаргын усыг түлхүү ашиглах, усны хэрэглээг багасгах	-	2023 оны байдлаар хур бороонь ус 146,859 м3, газрын доорх ус 392,141 м3 ашигласан бол 2024 оны эхний 10-н сарын дараах байдлаар хур бороонь ус 243,768 м3 буюу өмнөх онтой харьцуулахад 1.7 дахин их, газрын доорх ус 204,952 м3 буюу 0.5 дахин бага хэмжээний ус ашиглаж усны зохистой хэрэглээг хангах талаар анхаарч ажиллалаа. 2023 онд гадаргын болон газрын гүний усны харьцаа нь 0.37 байсан бол 2024 оны эхний 10 сарын дараах байдлаар 1.01 болж өссөн сайн үзүүлэлттэй гарсан.	100%
5.2.6	Хаягдал усыг зориулалтын зөвшөөрөлтэй газарт нийлүүлэх, стандарт шаардлагад нийцсэн цэвэршүүлсэн бохир усаар зам талбайн тоосжилт дарах, мод услахад ашиглах	Тодорхойлох боломжгүй	2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 16,932 м3 саарал усыг дахин ашигласан бөгөөд эдгээр усыг “Энержи ресурс” ХХК-ны цэвэрлэх байгууламж болон “КА майнинг” ХХК-ны цэвэрлэх байгууламжаас авч нүүрс ачилтын талбайн тоосжилт дарах усалгаанд ашигласан байна.	100%

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.2.7	Уурхайн газар доорхи усны нөөц, чанарт байнгын хяналт тавих	3	Унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй худгуудын усны чанар, түвшингийн өөрчлөлт, ундарга зэргийг тогтмол хянах зорилгоор түвшингийн хэмжилтийг 7 хоногт 2 удаа, ундаргын тооцооллыг сард 1 удаа, усны шинжилгээг улиралд 1 удаа тус тус хийж гүйцэтгэн ажиллаж байна. Мөн хэмжилтийн үр дүнг боловсруулж, хагас жил болон жилийн эцсийн байдлаар ус ашиглалтын тайланг боловсруулж, Өмнөговь аймгийн БОАЖГ, ГӨДГСГ, Усны газарт тус тус тогтмол тайлагнан ажиллаж байна.	100%
5.2.8	Булгийн эхийг сэргээх, хашиж хамгаалах /Мухар гашуу булаг/	1	Булгийн эхийг 32мм-ийн труба, 30 мм-ийн полоса төмөр ашиглан дунджаар 1.5 м өндөртэй, 140 м урттай хашаагаар хүн мал орохооргүй байдлаар байгальд ээлтэй аргаар бүхэлд нь хашсан. Хашааны урд хэсэгт хүн гарч орох хаалгыг хийсэн.	100%

5.2.1 Ашиглаж буй худгийн үйл ажиллагаанд тогтмол хяналт хийх

Салбар уурхайд 2023 онд унд ахуй үйлдвэрлэлийн зориулалтаар уурхай 25 худаг ашиглаж байсан. 2024 оны 2 сард 5 худаг уулын ахилтад өртсөн зэрэг шалтгаанаас улсын мэдээллийн сангаас хассан. Одоогоор улсын мэдээллийн сангаас хассан 3 худгийг мониторингийн чиглэлээр ашиглаж байна.



Зураг № 22. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн эзэмшлийн худгуудын байршлын зураг

Унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй худгуудын усны чанар,түвшингийн өөрчлөлт, ундарга зэргийг тогтмол хянах зорилгоор түвшингийн хэмжилтийг 7 хоногт 2 удаа, ундаргын тооцооллыг сард 1 удаа, усны шинжилгээг улиралд 1 удаа тус тус хийж гүйцэтгэн ажиллаж байна. Мөн хэмжилтийн үр дүнг боловсруулж, хагас жил болон жилийн эцсийн байдлаар ус ашиглалтын тайланг боловсруулж, Өмнөговь аймгийн БОАЖГ, ГӨДСГЗ, Усны газарт тус тус тогтмол тайлагнан ажиллаж байна. Энэ тайлангийн 6.2.7-р бүлэг болон 13.2 Усны хяналт шинжилгээний бүлгээс дэлгэрэнгүй тайлантай танилцах боломжтой.

5.2.2 Ус ашиглах дүгнэлт гаргуулж, ус ашиглах гэрээ байгуулах

Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/373 тоот албан бичгээр Цанхийн зүүн уурхайн 2024 оны ус ашиглуулах дүгнэлт, Цанхийн баруун уурхайн 2024 оны ус ашиглах дүгнэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/372 тоот албан бичгээр тус тус гаргуулсан.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР
Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn
2024.04.02 № 01/373
танай 2024.01.02-ны № 1/131 -т
"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК-Д

Танай байгууллагын 2024 оны 01/131, 01/132 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг судалж үзээд Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заасны дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт хэрэгжиж байгаа ашигт малтмалын MV-011943, MV-016883 MV-011955, MV-011953 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий "Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордын цанхийн болон Бортээг /өмнөд/ хэсгийн нүүрсний ордыг ашиглах төслийн 2024 оны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.


Хувийг: Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаанд

Хавсралт: 5... хуудастай.

Ирээдүй хойч үедээ усны нөөцөө үлдээхийн төлөө усаа хамгаалъя, хуримтлуулъя, хамтран ажиллая.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БАТБАЯР

16243C649



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР
Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn
2024.04.02 № 01/372
танай 2024.01.02-ны № 1/132 -т
"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК-Д

Танай байгууллагын 2024 оны 01/132 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг судалж үзээд Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заасны дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт хэрэгжиж байгаа ашигт малтмалын MV-016882, MV-016881 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий "Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордын цанхийн баруун хэсэг"-ийн нүүрсний ордыг ашиглах төслийн 2024 оны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг: Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаанд

Хавсралт: 5... хуудастай.


Ирээдүй хойч үедээ усны нөөцөө үлдээхийн төлөө усаа хамгаалъя, хуримтлуулъя, хамтран ажиллая.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БАТБАЯР

16243C653

Зураг № 23. Ус ашиглах дүгнэлт гаргуулсан албан бичиг

Тус Цанхийн баруун зүүн уурхайн ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн “Галба Өөш Долоодын Говийн Сав газрын захиргаатай 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 2024/06, ЕТТ-2024/1120 дугаартай Ус ашиглах гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



БАТЛАВ
ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
Б.ЯЛАЛТБАЯР

БАТЛАВ
ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ
Ж.ГАНБАТ

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Дугаар 2024/05 Сайншанд хот

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу, Монгол улсын Засгийн газрын харэгжүүлэгч агентлаг Усны газрын тэргэсан 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 41 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны дарын 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/31 дугаар тушаалыг тус тус үндэслэн:

Ус ашиглуулагч /цаашид "Захиргаа" гэх/-ийг төлөөлж Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны Усны баригдэ байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Жанчивдорж нөгөө талаас ус ашиглагч /цаашид "Ус ашиглагч" гэх/-ийг төлөөлж Өмнөговь аймаг Цогтцэций сумын нутагт байрлах "Эрдэнэс Тавантолгой" ХК

Усны эх үүсвэр	Шүүрэл	Гүний худаг	Гүний худаг	Гүний худаг	
Ашигласан төсөл	Уурхай	Уурхай	Уурхай	Уурхай /20 худгаас/	
2024.01	1,050,148.8	1,055,143.8		244,747.0	2,350,039.6
2024.02	1,945,652.4	1,731,466.8		212,331.5	3,889,450.7
2024.03	2,290,906.8	4,288,507.2	28,267.7	214,537.3	6,822,219.0
2024.04	8,501,170.3	6,630,562.8	84,083.8	247,815.9	15,463,632.9
2024.05	4,872,402.7	3,209,787.0	58,981.0	331,252.4	8,472,423.1
2024.06	9,727,542.7	4,035,760.2	97,102.8	261,050.7	14,121,456.4
2024.07	5,797,396.8	2,514,283.2	105,806.1	291,068.6	8,708,554.7
2024.08	1,172,426.4	1,204,394.4	94,081.8	234,389.4	2,705,292.0
2024.09	7,394,917.7	2,212,984.8	91,420.5	269,778.0	9,969,100.9
2024.10	4,522,832.6	1,808,589.6	62,937.0	229,881.9	6,624,241.1
2024.11					-
2024.12					-
Нийт	47,275,397.3	28,691,479.8	622,680.7	2,536,852.6	79,126,410.4

2024 оны ус ашиглалтын хэмжээг ЦБУ, ЦЗУ-н ус ашиглуулах дүгнэлтэд заасан хэмжээтэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт № 14. Ус ашиглалтын байдлыг ус ашиглах дүгнэлттэй харьцуулсан хэмжээ

Дүгнэлт	Шавхан зайлуулах ус, м^3	Зам талбайн тоосжилт дарах газрын доорх ус, м^3	Ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд газрын доорх ус, м^3	Ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд газрын доорх ус, м^3
ЦБУ-н ус ашиглуулах дүгнэлт	321,930.00	165,713.00	194,560.00	89,845.00
ЦЗУ-н ус ашиглуулах дүгнэлт	290,832.00	554,658.00	610,400.00	97,017.00
Ус ашиглуулах дүгнэлтэнд заасан нийлбэр хэмжээ	**612,762.00**	**720,372.00**	**804,960.00**	**186,862.00**
2024 оны 1-10 сарын ашиглалт	62,541.00	142,411.00	9,623.00	25,924.00
Ашиглалтын хувь	10%	20%	1%	14%

2024 оны хувьд ус ашиглалтын байдал ус ашиглах дүгнэлтэнд заагдсанаар дунджаар 11% ашиглалттай байгаа бөгөөд энэ нь уурхайн зам усалгаанд хур борооны усыг түлхүү ашиглаж байгаатай холбоотой юм.

Хүснэгт № 15. Ус ашиглалтын хэмжээ

Зориулалт	Зам усалгаа				Унд ахуй	Мод усалгаа	Нийт
Нийт	476,277				26,452	8,657	
Эх үүсвэр	Хур бороо	Шүүрэл	Худаг	Саарал ус	Худаг	Худаг	
I	-	1460	5281	-	2552		9,293
II	-	2705	8666	770	2214		14,355
III	13345	3185	21464	-	2237	393	40,624
IV	3558	11819	33186	2317	2584	1169	54,633
V	26281	6774	16085	440	3454	820	53,854
VI	16418	13524	20199	2640	2722	1350	56,853
VII	26912	11819	12584	640	3035	1471	56,461
VIII	40064	6774	6028	1720	2444	1308	58,338
IX	64188	13524	11076	2180	2813	1271	95,052
X	51371	6288	9052	1940	2397	875	71,923
Нийт	**242,137**	**77,872**	**143,621**	**12,647**	**26,452**	**8,657**	**511,386**






График № 1. Ус ашиглалтын мэдээлэл эх үүсвэрээр.

Ашигласан усны ашиглалт тус бүрээр үзвэл унд ахуйн усны хэрэглээ 5.17%, мод усалгаанд ашиглаж буй усны хэрэглээ 1.69%, зам усалгаанд ашиглаж буй усны хэрэглээ 93.13% байна.

Нийт ашигласан усанд эзлэх гүний усны хэрэглээ 34.9%, шүүрлийн усны хэрэглээ 15.23%, гадаргын усны хэрэглээ 47.35%, дахин ашигласан буюу саарал усны хэрэглээ 2.47%-ийн гүйцэтгэлтэй байна.

График № 2. Худаг ашиглалтын байдал.





5.2.4 Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулан төлбөр төлж барагдуулах.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль 2020 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Усны газрын дараах хаягдал усны дүгнэлтийг үндэслэн Галба-Өөш, Долоодын Говийн сав газрын захиргаанаас хаягдал ус зайлуулах зөвшөөрөл авсан. Үүнд:

- ✓ 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 12 тоот хаягдал усны дүгнэлтийг үндэслэн 2021 оны 01 дүгээр сарын 25-ний өдөр жилд 28428м^3 хаягдал усыг зайлуулах зөвшөөрөл;
- ✓ 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр 09 тоот хаягдал усны дүгнэлтийг үндэслэн 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 21960 м^3 хаягдал усыг зайлуулах зөвшөөрөл /сунгалт/
- ✓ 2021 оны 01 дүгээр сарын 06-ны 18 тоот хаягдал усны дүгнэлтийг үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 16250 м^3 хаягдал усыг зайлуулах зөвшөөрөл /сунгалт/
- ✓ 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 26 тоот хаягдал усны дүгнэлтийг үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 18547 м^3 хаягдал усыг зайлуулах зөвшөөрөл /сунгалт/

Хаягдал ус зайлуулах зөвшөөрлийг үндэслэн “Хаягдал усыг байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй байгуулах ус бохирдуулсны төлбөрийн гэрээ”-г 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Галба-Өөш, Долоодын Говийн сав газрын захиргаатай байгуулсан. Гэрээний дагуу улирал тутам цэвэрлэх байгууламжуудын оролт, гаралтын бохир уснаас дээж авч лабораторид шинжлүүлэн Усны газраас төлбөрийн тооцоог гаргуулан төлбөрийг тогтмол төлж байна.

2024 оны I, II, III-р улиралд нийт 21,227 м^3 ахуйн хэрэглээний усыг Цанхи хотхон, Эрдэнэс хотхон, уурхайн оффис, грийн центрийн цэвэрлэх байгууламжид нийлүүлсэн ба ус бохирдуулсны төлбөрт 1,592,025 төгрөг төлсөн байна.(Хавсралт №3)

Хүснэгт № 16. Цэвэрлэх байгууламжид нийлүүлсэн усны хэмжээ /м3/

Цэвэрлэх байгууламж	1-р улирал	2-р улирал	3-р улирал	Нийт
Цанхи хотхон	1,569.00	2,708.00	2,801.00	7,078.00
Уурхайн оффис	249.00	510.00	270.00	1,029.00
Грийн центр	4,459.00	4,264.00	4,397.00	13,120.00
НИЙТ	**6,277.00**	**7,482.00**	**4,397.00**	**21,227.00**

Хүснэгт № 17. Ус бохирдуулсны төлбөрийн тооцоолол

№	Улирал	Хаягдал усны дүгнэлтийн огноо, дугаар	Нийт ноогдуулсан төлбөр /төг/
1	I улирал	2024.04.24, 01/528	470,775.00
2	II улирал	2024.07.05 E-2407-000050	561,150.00
3	III улирал	2024.10.10 E-2410-000025	560,100.00
НИЙТ			**1,592,025.00**

5.2.5 Замын тоосжилт бууруулахад ашигласан усны хэмжээ

А6-20 Дунд хугацааны бизнес төлөвлөгөө болон ISO 14001 стандартын дагуу тодорхойлсон зорилт ёсоор өмнөх жилүүдийн уурхайн нүүрс олборлолт, хөрс хуулалтын хэмжээг ус ашиглалтанд харьцуулсан харьцааг бууруулах хуваарийг тодорхойлж гурван жилийн хугацаанд ашигласан гадаргын усыг газар доорх усанд харьцуулсан харьцааг 0.2 хүртэл өсгөнө.

Хүснэгт № 18. Уурхайн ус ашиглалтыг бууруулах шалгуур үзүүлэлт

Байгаль орчны нөлөөлөл	Шалгуур (нэгж)	n-1	n	n+1	n+2
1 – тоос бууруулахад ашиглах усны норм, n_d	(м^3/флит)^3	4.65	4.6	4.4	4.1
2 – Гадаргын ус болон ГДУ усны харьцаа	(м^3/ м^3)	0.15	0.15	0.18	0.2

Зам усалгаанд их хэмжээний ус ашиглагдаж байгаа ба энэ хэмжээг багасгах хамгийн оновчтой арга бол тоос бууруулах технологийг нэвтрүүлэх явдал юм.

Тоос бууруулахад ашигласан усны нормын хэмжээг тухайн жилийн уурхай дотор тоос бууруулахад ашигласан усны хэмжээг нэг өдөрт ажилласан автосамосвалуудын тооны өдрийн дундаж ба жилийн хоногийн үржвэрт хуваж гаргасан.

$$n_d = \frac{w_d}{365\ \Delta t}$$

2024 оны эхний 10-н сарын дараах байдлаар зам талбайн тоосжилт дарах усалгаанд гүний худгаас 143,621 м3, шүүрлийн ус 65726 м3, хур борооны тогтоол ус 243,768 м3, дахин ашигласан саарал ус 88,877 м3 тус тус авч ашигласан.

Тухайлбал 2023 оны байдлаар хур борооны ус 146,859 м3, газрын доорх ус 392,141 м3 ашигласан бол 2024 оны эхний 10-н сарын дараах байдлаар хур борооны ус 243,768м3 буюу өмнөх онтой харьцуулахад 60%-аар гадаргын ус ашиглалтыг нэмэгдүүлсэн. Мөн газрын доорхи усны хэрэглээг 178730 м3 ус ашиглаж өмнөх онтой харьцуулах 45%-аар багасгасан.

2023 онд гадаргын болон газрын гүний усны харьцаа нь 0.37 байсан бол 2024 оны эхний 10 сарын дараах байдлаар 1.01 болж өссөн сайн үзүүлэлттэй байна.

Тавантолгой ордын нүүрсний уурхайг гадаргын үерийн уснаас хамгаалах, түүнийг хуримтлуулах усан сан байгуулах ажлын хүрээнд Улаан нуур, Жирмийн булгийн 1,529,500 м3 эзэлхүүнтэй хөв цөөрөм байгуулсан. Хуримтлуулсан усаар уурхайн зам талбайн тоосжилт дарах усалгаанд ашиглаж байна.

Грийн центрийн оффис, амрах байрны урд болон баруун урдаас ирэх хур борооны 5.82 м3/м урсац бүхий гадаргын усыг хуримтлуулах, үерийн уснаас хамгаалах, хуримтлуулсан усаар орчны ногоон байгууламжийн усалгааг хангах зорилгоор 80х100 м хэмжээтэй хөв цөөрөм байгуулж ашиглалтад оруулсан.

n_d Annual total water used for road dust suppression to total number of hours operated by only dump trucks. For the sake of simplicity, other types fleet such as graders and dozers are excluded




Зураг № 25. Грийн центрийн урд талбайн хөв цөөрөм

5.2.6 Хаягдал усыг зориулалтын зөвшөөрөлтэй газарт нийлүүлэх, стандарт шаардлагад нийцсэн цэвэршүүлсэн бохир усаар зам талбайн тоосжилт дарах, мод услахад ашиглах

Уурхайн ажилчдын хотхон, захиргааны барилгын цэвэрлэж байгууламж болох “Грийн центр” цэвэрлэх байгууламжийн хувьд зүгшрүүлэх тохируулгын ажил хийгдэж байгаа бөгөөд одоогоор цэвэршүүлсэн саарал усыг улирал бүр лабораторид шинжүүлж стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж байна. Шинжилгээний хариуг MNS4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал усны ерөнхий шаардлага стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлттэй байгаа тул зам усалгаанд ашиглаагүй болно.

Мөн Цанхи хотхоны цэвэрлэх байгууламжинд 250 сая төгрөгийн нэмэлт сайжруулалт хийсэн ба одоогоор зүгшрүүлэх ажил хийгдэж байна. (ОХШХ бүлэг)



Зураг № 26. Саарал усыг шинжилгээнд хамруулсан байдал

2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 16,932 м3 саарал усыг дахин ашигласан бөгөөд эдгээр усыг “Энержи ресурс” ХХК-ны цэвэрлэх байгууламж болон “КА майнинг” ХХК-ны цэвэрлэх байгууламжаас авч нүүрс ачилтын талбайн тоосжилт дарах усалгаанд ашигласан байна.

5.2.7 Уурхайн газрын доорх усны нөөц, чанарт байнгын хяналт тавих

Унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй худгуудын усны чанар, түвшингийн өөрчлөлт, ундарга зэргийг тогтмол хянах зорилгоор түвшингийн хэмжилтийг 7 хоногт 2 удаа, ундаргын тооцооллыг сард 1 удаа, усны шинжилгээг улиралд 1 удаа тус тус хийж гүйцэтгэн ажиллаж байна. Мөн хэмжилтийн үр дүнг боловсруулж, хагас жил болон жилийн эцсийн байдлаар ус ашиглалтын тайланг боловсруулж, Өмнөговь аймгийн БОАЖГ, ГӨДГСГ, Усны газарт тус тус тогтмол тайлагнан ажиллаж байна. (ОХШХ бүлэг)



Зураг № 27. Ашиглалтын худуудын түвшний хэмжилт хийж буй байдал

Тавантолгой ордын хэмжээнд гидрогеологийн болон газрын доорх усны нөөц батлуулах хайгуул судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр компанийн үйл ажиллагааны төсөвт 4.2 тэрбум төгрөг суулгасан.

5.2.8 Булгийн эхийг сэргээх, хашиж хамгаалах

“Мухар гашууны хонхор булаг” нь Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд жилийн турш газрын гадаргад ундаргатай булаг юм.

Тус булгийн эхийг 2018 онд манай компанийн хөрөнгөөр хашиж хамгаалсан боловч байгаль цаг уурын нөхцөл байдал болон тухай газар зүйн тогтцоос хамааран шаварлаг хөрстэй байсан учир хашаа нь нурж унасан тул хуучирч унасан хашааг шинээр сольж, малын сэг зэм, орчны хогийг цэвэрлэн шинээр хашиж хамгаалсан.

Иймд булгийн эхийг 32мм-ийн труба, 30 мм-ийн полоса төмөр ашиглан дунджаар 1.5 м өндөртэй, 140 м урттай хашаагаар хүн мал орохооргүй байдлаар байгальд ээлтэй аргаар бүхэлд нь хашсан. Булгийн эхийг хашиж хамгаалсан актыг 2024 оны 10 дүгээр сарын 25-ны өдөр сум орон нутагт акт үйлдэж хүлээлгэн өгсөн. (Хавсралт №4)



Зураг № 28. Булгийн эхийг хашиж хамгаалсаны өмнөх ба дараах байдал /2024.09.29/


5.3 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.3.1	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимын мөрдөлтийг хангуулах, хяналт тавиж ажиллах	12	Цанхийн уурхайд нийтдээ 26 ш шимт хөрсний овоолго үүссэн байна. Шимт хөрсний овоолгууд дээр нийт 5247.8 мян.м3 шимт хөрс хадгалагдаж байна.	100%
5.3.2	Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст өвслөг ургамал тарих	>3 га	Цанхийн баруун уурхайн шимт хөрсний TSP-4.1.4-4.1.5 болон TSP-4.2.4-4.2.6 гэсэн овоолгуудад нутгийн ургамал болох таана, хөмүүл, олон наст хялганы үрээр биологийн нөхөн сэргээлт хийсэн.	100%
5.3.3	Тусгай зөвшөөрлийн талбай дээрх ААН-ийн судалгаа хийх, Сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай хамтран зөрчил арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх	1	Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа иргэн, аж ахуйн нэгж, объектын тооллогыг 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс 4 дүгээр сарын 4-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Нийт 446 иргэн, аж ахуйн нэгж, бусад объектуудыг бүртгэлжүүлсэн.	100%
5.3.4	Ахилтад өртөх талбайн шимт хөрсийг >0.3 метр зузаантай хуулж, стандартын дагуу шимт хөрсийг хадгалах	Тухай бүр	Цанхийн зүүн уурхайд нийт 39 зөвшөөрөл олгогдож 398,710 м2 газар хөндөгдсөн, Цанхийн баруун уурхайд нийт 20 зөвшөөрөл олгогдож 84,870 м2 газар хөндөгдсөн байна. Шимт хөрс хуулсан даруйд зохих овоолго руу зөөн байршуулдаг.	100%

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.3.5	Дүүрсэн шимт хөрсний овоолгуудыг стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг харгалзан үзэж акт үйлдэн хаах	Овоолгын дүүрэлтээс шалтгаална	Цанхийн зүүн уурхайд 19.1.7, 19.1.8, 19.2.6 дугаартай шимт хөрсний овоолгууд дүүрч тухайн овоолгуудыг хэлбэржүүлэн, акт үйлдэн хаах ажил хийгдсэн. Тус овоолгуудад нийт 122,257.86 м3 шимт хөрс хадгалагдаж байна.	100%
5.3.6	Уурхайн хэмжээнд шимт хөрсний судалгаа хийж зөөгдөөгүй үлдсэн шимт хөрсийг зохих овоолгод байршуулах	-	Шимт хөрс хуулах зөвшөөрлийн дагуу хуулагдсан талбайд байгын хяналт тавьж, шимт хөрсийг гүйцэт хуулан, зохих овоолгод байршуулан хадгалдаг.	100%

5.3.1 Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимын мөрдөлтийг хангуулах, хяналт тавиж ажиллах

Уурхайн ахилт, бүтээн байгуулалт, зам талбай, хөрсний овоолго хийгдэх талбайн шимт хөрсийг хуулж, стандартын дагуу овоолго үүсгэж, хадгалдаг ба Цанхийн уурхайд нийтдээ 26 ш шимт хөрсний овоолго үүссэн байна. Шимт хөрсний овоолгууд дээр нийт 5247.8 мян.м^3 шимт хөрс хадгалагдаж байна.



Цанхийн баруун уурхайн шимт хөрсний овоолго

Баруун уурхайд нийтдээ 8 шимт хөрсний овоолгод 1940.3 мян.м^3 хөрс хадгалагдаж байна.

Шимт хөрсний овоолго

Цанхийн зүүн уурхайн шимт хөрсний овоолго

Зүүн уурхайд нийтдээ 18 шимт хөрсний овоолгод 3307.5 мян.м^3 хөрс хадгалагдаж байна.

Шимт хөрсний овоолго


Зураг № 29. Шимт хөрсний овоолгуудын байршлын зураг

5.3.2 Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст өвслөг ургамал тарих

“Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт. MNS 5916:2008” стандартын дагуу 2 жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст өвслөг ургамал тарих ба шимт хөрсний овоолгыг

удаан хугацаагаар хадгалах тохиолдолд овоолгын гадна талаар салхины хамгаалалт хийж гадарга хэсгийг ургамалжуулахаар заасан байдаг.

Мөн эвдэрсэн газрыг ургамалжуулахад тухайн газрын ургамлан бүлгэмдлийн онцлогийг харгалзан зонхилогч ургамлуудын үрийг хольж тарих нь зүйтэй. Иймд шимт хөрсний TSP-4.1.4-4.1.5 болон TSP-4.2.4-4.2.6 гэсэн 5 овоолгод нутгийн ургамал болох таана, хөмүүл, олон наст хялганы үрээр ургамалжуулалт хийсэн.



Зураг № 30. Ургамалжуулалт хийсэн шимт хөрсний байршлын зураг



Зураг № 31. Нутгийн ургамлын үр түүж, хатааж буй байдал

Нутгийн унаган ургамал болох таана, хөмүүлний 146.5 кг үр түүж хатаасан. Мөн “Гобиголден сийдс” ХХК-иас 5 га талбайд тарих олон наст хялганы үр худалдан авч нийт 5 овоолгын тариалалтын ажлыг 10 дугаар сарын 01-ээс 10 дугаар сарын 04-ний өдрүүдэд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг № 32. Шимт хөрсний овоолгод тарилт хийж буй байдал

5.3.3 Тусгай зөвшөөрлийн талбай дээрх ААН-ийн судалгаа хийх, сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай хамтран зөрчил арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 сарын 21-ний өдрийн А/149 дугаартай тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах” журмын 6.1-т “Жил бүрийн гуравдугаар улиралд багтаан тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл хийнэ” гэж заасан байдаг.

Энэ журмын 6.1-д заагдсаны дагуу тусгай зөвшөөрлийн талбайд байгаа иргэн, аж ахуйн нэгж, объектын тооллогыг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс 04 дүгээр сарын 04-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.



Зураг № 33. Лицензийн талбай дээрх аж ахуйн нэгжийн судалгаа хийж буй байдал

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ний тусгай зөвшөөрлийн талбайд нийт 446 иргэн, аж ахуйн нэгж, бусад обьектууд байна. Үүнээс 196 иргэн, аж ахуй нэгж нь газар эзэмших зөвшөөрөлтэй, 128 иргэн, аж ахуй нэгж нь газар эзэмших ашиглах зөвшөөрөлгүй мөн 44 ширхэг худаг байна. “ЭТТ” ХК-ийн тусгай зөвшөөрлийн 68,471.43 га талбайгаас 2024 оны эхний улирлын байдлаар 76 нэгж талбарын 12092.18 га талбайд газар эзэмших эрхийн гэрчилгээ авсан байна.

Газраа чөлөөлсөн аж ахуй нэгж, байгууллага хувь иргэн нь “Хог хаягдлын тухай хуул”-ийн 10-р зүйлд заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүргээ зөрчсөн гэж үзэхээр байна. Тухайлбал: Тавантолгой тосгоноос нүүсэн айл өрхүүд нь чөлөөлсөн газраа их хэмжээний хог үлдээх, нураасан байшин барилгын балгасын үлдэгдлийг орхисон байдал түгээмэл байсан.



Зураг № 34. Нураасан байшин, барилгын үлдэгдэл хог

Энэ ажлын хүрээнд Салбарын Үйлдвэрлэл, техникийн газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн байгаль орчны мэргэжилтнүүд, орон нутаг хариуцсан мэргэжилтнүүд болон туслан гүйцэтгэгч компанийн байгаль орчны мэргэжилтнүүд хамтран нийт 30 хүний бүрэлдэхүүнтэй Цогтцэций сумын Цагаан-Овоо баг /тосгон/-ийн хэсэгт үйл ажиллагаа явуулж буй иргэн, айл өрхийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанаас үүссэн хур хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 18-24-ний өдөр хүртэл хийж гүйцэтгэснээр 1000 орчим тонн хаягдлыг заасан цэгт аваачиж, буулгаснаар энэ зөрчил арилсан.

5.3.4 Ахилтад өртөх талбайн шимт хөрсийг >0.3 метр зузаантай хуулж, стандартын дагуу шимт хөрсийг хадгалах

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь шимт хөрснөөс гадна шимэрхэг чулуулгийн тодорхой чанартай хэсгийг ашиглаж болохыг судлан тогтоож нөхөн сэргээлтэд ашиглахыг зорьж байна. Үүний дагуу уурхайн хэмжээнд Салбарын захирлын батласан ЭТТ-СА-Ж14-БО-Ж09-Х03 дугаартай “Өнгөн хөрстэй ажиллах журам”-ыг баримтлан ажиллаж байна. Энэхүү журамд заасны дагуу шимт хөрс хуулах ажил эхлэхээс өмнө холбогдох инженерүүдээс зөвшөөрөл авч баталгаажуулсны дараа шимт хөрс хуулах ажил хийгддэг.

Шимт хөрс хуулах үйл явцад “Газар хөндөх журам”-ын дагуу газар хөндөх зөвшөөрлийг мөн адил авна.

Тайлант онд Цанхийн зүүн уурхайд нийт 39 зөвшөөрөл олгогдож 398,710 м^2 газар хөндөгдсөн, Цанхийн баруун уурхайд нийт 20 зөвшөөрөл олгогдож 84,870 м^2 газар хөндөгдсөн байна. Шимт хөрс хуулсан даруйд төлөвлөгдсөн овоолго руу зөөн байршуулдаг.

Шимт хөрс хуулах, зөөх үйл явцад цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан үзэж салхи, шуургатай үед шимт хөрс салхинд их хэмжээгээр хийсэхээс сэргийлж тухайн ажлыг хэсэгчлэн зогсоох арга хэмжээг авдаг.




Зураг № 35. Шимт хөрсийг хуулж овоолгод байршуулахаар ачиж буй байдал

5.3.5 Дүүрсэн шимт хөрсний овоолгуудыг стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг харгалзан үзэж акт үйлдэн хаах

2024 онд Цанхийн зүүн уурхайд 19.1.7, 19.1.8, 19.2.6 дугаартай шимт хөрсний овоолгууд дүүрч хэлбэржүүлэн, акт үйлдэн хаах ажил хийгдсэн. Уг овоолгуудад нийт 122,257.86 м^3 шимт хөрс хадгалагдаж байна.

Хүснэгт № 19. Акт үйлдэж хаасан шимт хөрсний овоолгын хэмжээ

№	Уурхай	Овоолгын дугаар	Шимт хөрсний хэмжээ
1	Цанхийн зүүн уурхай	19.1.7	59,102.94
2	Цанхийн зүүн уурхай	19.1.8	33,263.97
3	Цанхийн зүүн уурхай	19.2.6	29,890.95
Нийт			**122,257.86**



Зураг № 36. Цанхийн зүүн уурхайд хаасан шимт хөрсний овоолгын акт

Цанхийн баруун уурхайн TSP 4.3.2 дугаар овоолго стандарт хэмжээнд хүрч дүүрсэн тул “Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт. MNS 5916:2008” стандартын дагуу хэлбэржүүлэлт хийж байна.

5.3.6 Уурхайн хэмжээнд шимт хөрсний судалгаа хийж зөөгдөөгүй үлдсэн шимт хөрсийг зохих овоолгод байршуулах

Шимт хөрс хуулах зөвшөөрлийн дагуу хуулагдсан талбайд байнгын хяналт тавьж, шимт хөрсийг гүйцэт хуулан, зохих овоолгод байршуулан хадгалдаг. Одоогоор уурхайн хэмжээнд зөөж байршуулаагүй шимт хөрс бүртгэгдээгүй байна.


5.4 Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.4.1	Зөвшөөрөлгүй газар хөндөхөөс сэргийлж, аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл олгох, хөндөгдсөн газрын бүртгэлийг мэдээллийн санд оруулах	Тухай бүр	Салбарын захирлын 2021.12.11-ний өдөр А/145 дугаар тушаалаар баталсан “Газар хөндөх журам”-ын дагуу газар хөндөх зөвшөөрөл олгосны үндсэн дээр газар шорооны ажлыг хийж гүйцэтгэдэг. Зөвшөөрөл олгосон тухай бүртгэл, хөтлөлт хийн, мэдээллийн сан үүсгэсэн.	100%
5.4.2	Тусгай зөвшөөрлийн талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын явуулж буй ААН судалгаа хийх	Улиралд 1 удаа	2024.03.14-ний өдөр А/300 дугаартай Өмнөговь аймгийн Засаг даргын захирамжаар НБҮ-ийн авто замын бүтээн байгуулалтад ашиглах ТТАМ ашиглах түр зөвшөөрөл авсан. Үүний дагуу 2024.05.03-ны өдөр Цогтцэций сумын Засаг даргатай ЭТТ-2024/1104 дугаартай ТТАМ ашиглуулах гэрээг байгуулан ажиллаж байна.	100%


5.4.1 Зөвшөөрөлгүй газар хөндөхөөс сэргийлж, аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл олгох, хөндөгдсөн газрын бүртгэлийг мэдээллийн санд оруулах

Салбарын захирлын 2021 оны 12 дугаар сарын11-ний өдөр А/145 дугаар тушаалаар батласан “Газар хөндөх журам”-ын дагуу холбогдох цахилгааны, сүлжээний, сантехникийн, хөдөлмөрийн аюулгүй байдлын, байгаль орчны инженерүүдээс газар хөндөх зөвшөөрөл олгосны үндсэн дээр газар шорооны ажлыг хийж гүйцэтгэдэг. Зөвшөөрөл олгосон тухай бүртгэл, хөтлөлт хийн, мэдээллийн сан үүсгэсэн.

2024 оны 11 сарын байдлаар 160 газар хөндөх зөвшөөрөл олгоод байна.




Зураг № 37. Газар хөндөх зөвшөөрлийн маягт.



Зураг № 38. Газар хөндөх журмын дагуу газар хөндөх зөвшөөрлийн бүртгэл үүсгэсэн байдал


5.4.2 Тусгай зөвшөөрлийн талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын явуулж буй ААН судалгаа хийх

2024.03.14-ний өдөр А/300 дугаартай Өмнөговь аймгийн Засаг даргын захирамжаар НБҮ-ийн 10 км урттай авто замын бүтээн байгуулалтад ашиглах ТТАМ ашиглах түр зөвшөөрөл авсан. ТТАМ ашиглахыг зөвшөөрсөн талбай нь Цогтцэций сумын Сийрст багийн нутагт байрлах ба 24 га талбайг хамарна.



Зураг № 39. ТТАМ ашиглах түр зөвшөөрөл болон талбайн байршлын зураг

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахын өмнө 2024.04.02-ны өдөр 2024/47 дугаартай албан бичгээр Өмнөговь аймгийн БОАЖГ-аас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулсан ба нөхцөл болзолтойгоор ашиглуулах боломжтой гэсний дагуу 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж Өмнөговь аймгийн БОАЖГ-аар хянуулан батлуулсан.



ӨМНӨГОВЬ АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН САЛБАРЫН ЗАХИРАЛ Л.ДОРЖСҮРЭН ТАНАА

Ерөнхий үнэлгээний дүгнэлт хүргүүлэх тухай

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт хэрэгжүүлэх "Баяжуулах үйлдвэрийн дотоод зам" төслийн барилт бичигт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3. түүний: хэрэгжүүлэх зорилт 2 дугаар зүйлийн 2.2 дэх хэсэгт тус тус үндэслэн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүгнэлтээр уг төслийн байгаль орчинд нөлөөлөх байдал нь онц урьшгатай бус сөрөг нөлөөллийг багасгах, арилгах боломжтой гэж үзэн төвөд нэмж тусгах арга хэмжээ болон зөвлөмж хэлбэл зохих шаардлага, биелүүлэх хугацаог заажээ.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хүндэт хэвээрэй.

ДАРГА Х. ОТГОНМӨНХ

462402184

БАТЛАВ:
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
/Х.ОТГОНМӨНХ/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМ ДАХЬ САЛБАРЫН ЗАХИРАЛ
/Л.ДОРЖСҮРЭН/

"НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨСЛИЙН ХОТХОНЫ АВТО ЗАМ БОЛОН ҮЙЛДВЭРИЙН ХҮНД ДААЦЫН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛД ШААРДЛАГАТАЙ ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙД 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Захирамжийн дугаар: А/300
Аж ахуй нэгжийн регистрийн дугаар: 5435528

ХЯНАСАН:
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ХУРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГА, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ОРГИЛМАА

ТАНИЛЦСАН:
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДАРГА Ө.НЯМАА

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ОРГИЛ

БОЛОВСРУУЛСАН:
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН БАЯЖУУЛАЛТЫН ИНЖЕНЕР Д.ЦЭНГЭЛЖАРГАЛ


"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН Д.ОТГОНСАЙХАН


2024 он

Зураг № 40. Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт болон 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Мөн 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Цогтцэций сумын Засаг даргатай ЭТТ-2024/1104 дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах гэрээг байгуулсан. Гэрээнд заасны дагуу сар бүр ашиглаж буй хайрганы карьерт хэмжилт хийж баталгаажуулсан.

2024 оны 09 сарын байдлаар 128,725.4м^3 хайрга олборлон ашигласан ба 199,524,370 төгрөгийг Цогтцэций сумын ЗДТГ-н дансанд төлсөн.





Зураг № 41. Сар бүр ашиглаж буй хайрганы карьерт хэмжилт хийж баталгаажуулсан актны зураг


5.5 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
5.5.1	Уурхайн ахилтанд өртөж болзошгүй ховор болон, нэн ховор ургамлын байршлыг тогтоож, мэдээллийн санд оруулах, өртөх тохиолдолд шилжүүлэн суулгах	6-8-р сарын хооронд	Шимт хөрс хуулах болон газар хөндөх зөвшөөрөл авах үед хөндөгдөх талбайд ховор ургамлын судалгааг хийж, бүртгэлжүүлж, шилжүүлэн суулгах арга хэмжээг төлөвлөж ажилладаг ба энэ онд хөндөгдөх талбайд ховор ургамал тохиолдоогүй болно.	100%
5.5.2	Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйлийн талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах	>500 ажилтан	Байгалийн ургамлын тухай хууль болон, тус оны БОМТ-ний дагуу уурхайн ахилт, тэлэлтэд өртөж болзошгүй ховор болон, нэн ховор ургамлын төрөл зүйлийн талаар мэдлэг олгох сургалтыг 500-аас доошгүй ажилтанд зохион байгуулахаар тусгасан бөгөөд, тус сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж ажилласан. Мөн гэрээт байгууллагын Байгаль орчны мэргэжилтэн нар сургалтыг орж нийт 1185 хүн хамрагдсан.	100%

5.5.1 Уурхайн ахилтад өртөх талбайн ховор болон нэн ховор ургамлыг нүүлгэн шилжүүлэх

Уурхайн ахилт хийхээр газар хөндөх зөвшөөрөл болон шимт хөрс хуулах зөвшөөрөл авах бүрт гэрээт байгууллагын Байгаль орчны мэргэжилтэн болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн байгаль орчны мэргэжилтэн нар ахилт хийх талбайд ховор ургамлын судалгааг хийж ховор, нэн ховор ургамал тохиолдох бүрд шилжүүлэн суулгах арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Шимт хөрс хуулах болон газар хөндөх зөвшөөрөл авах үед хөндөгдөх талбайд ховор ургамлын судалгааг хийж, бүртгэлжүүлж, шилжүүлэн суулгах арга хэмжээг төлөвлөгөж ажилладаг ба энэ онд хөндөгдөх талбайд шилжүүлэн суулгах шаардлагатай ховор ургамал бүртгэгдээгүй.



TTJVCO
Tavan Tolgoi Joint Venture Company

УУРХАЙН АХИЛТАНД ӨРТӨХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЗЛЭГИЙН ХУУДАС

Үзлэг хийсэн огноо: 2024.03.16
Байрлал: Цанхийн зүүн уурхай
Газар хөндөх шалтгаан: Хөрсний 3.1 дүгээр овоолгын замын шимт хөрс хуулах
Өртөх талбайн хэмжээ: 1.26 га

№	Байгаль орчны үзлэгийн төрөл	Шаардлагатай арга хэмжээ	
1	Ховор, нэн ховор ургамал ургаж байгаа эсэх	✕	Шилжүүлэн суулгалт хийх
		✕	Үрийн нөөц бүрдүүлж нөхөн сэргээлтэнд ашиглах
2	Шувуунд, хөхтөн амьтны үүр, амьдрах орчин байгаа эсэх	✕	Үржлийн бус цагаар газар хөндөлт хийх

TTJVCO
Tavan Tolgoi Joint Venture Company

3	Усны эх үүсвэр, булаг шанд байгаа эсэх	✕	Шинэ ус хангамжийн цэгүүд байгуулах
		✕	Усны гидрогеологийн үнэлгээ хийлгэх
4	Хур хог хаягдал, аюултай бодисын хаягдалтай эсэх	✕	Хог хаягдлыг зайлуулах
		✕	Бохирдсон хөрсийг тусад нь хүүлж авах
5	Соёлын өв байгаа эсэх	✓	Түүхэн талбайд эрх бүхий байгууллага археологи, палентлогийн судалгаа хийсэн эсэх
		✓	Соёлын өв, дурсгал илэрсэн тохиолдолд авран хамгаалах арга хэмжээг авах

Ахилтанд өртөх талбайд Улаанбударгана, Харлаг өмхий өвс, Цагаан лууль зэрэг ургамалууд тархан ургаж байна.

Улаан бударгана - Reaumuria soongorica (Pall.) | Харлаг өмхий өвс – Peganum nigellastrum
Цагаан лууль – Chenopodium album









Зураг № 42. Нэн ховор, ховордсон ургамлын бичиглэл

5.5.2 Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйлийн талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах

Байгалийн ургамлын тухай хууль болон, тус оны БОМТ-ний дагуу уурхайн ахилт, тэлэлтэд өртөж болзошгүй ховор болон, нэн ховор ургамлын төрөл зүйлийн талаар мэдлэг олгох сургалтыг 500-аас доошгүй ажилтанд зохион байгуулахаар тусгасан бөгөөд, тус сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж ажилласан.

Зураг № 43. Нэн ховор болон ховор ургамлын талаар мэдлэг, ойлголт өгөх сургалт орж буй байдал

5.6 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
5.6.1	Тус бүс нутагт өвөлжилт, хаваржилт хүндэрч, зэрлэг амьтдын идэш тэжээл ховордох тохиолдол гардаг тул зэрлэг амьтдад өвс, мөс тавих ажлыг зохион байгуулах	>300 боодол	Цанхийн уурхайн гэрээт туслан гүйцэтгэгч байгууллагуудыг хамруулан төлөвлөгөө гаргаж батлуулах хамтран хэрэгжүүлсэн. Цогцэций сумын Сийрст багийн “Хангинах”-ын хад, Билгэх багийн “Унаган Хайрхан”-нд тус тус нийтдээ 8 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд нийт 525 боодол өвс тараан байршуулсан.	100%
5.6.2	Шувууны өртөлтийг багасгах зорилгоор өндөр хүчдэлийн шугамаар хяналт хийх, шаардлагатай тохиолдолд нэмж шувуу үргээгч байршуулах	50 км	Цанхийн баруун уурхайн гэрээт “КА майнинг” ХХК 49.3 км агаарын шугамд, “Үндэсний оператор түншлэл” 6 км, “Овоот толгой ресурс” ХХК 15.3 км, “Спейшл майнинг сервис” ХХК 6.2 км, Цанхийн зүүн уурхайн олборлогч “ТН Түншлэл” 12.3 км агаарын шугамд шувуу өртөлтийн судалгааг хийж гүйцэтгэсэн.	100%
5.6.3	“Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудад хулгайн ангаас сэргийлэх хууль эрхзүйн сургалтыг орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах	1000 хүн	Хулгайн антай тэмцэх сургалтыг гэрээт компанийн Байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран 4 ээлжинд давхардсан тоогоор нийт 1148 ажилтуудад зохион байгуулсан.	100%
5.6.4	Хулгайн ан, байгаль орчны гэмт хэргийг бууруулахад орон нутгийн байгаль хамгаалагч нартай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх	-	Орон нутгийн байгаль хамгаалагч нартай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Байгаль хамгаалагч нарын эргүүл хийх түлш шатахуун болон бусад зүйлсэд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг гэрээт байгууллагуудтай хамтран шийдвэрлэж ажилласан.	100%

5.6.1 Биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр “Биотехникийн арга хэмжээ”-ний төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Цогцэций сумын Засаг даргын тамгын газраас ирүүлсэн биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу, төлөвлөгөөнд тусгагдсан газарт тус арга хэмжээг хэрэгжүүлсэн. Цогцэций сумын Сийрст багийн “Хангинахын хад”, Билгэх багийн “Унаган Хайрхан” зэрэг зэрлэг амьтад ихээр идээшилдэг байршлуудад биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Биотехникийн арга хэмжээг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гэрээт туслан гүйцэтгэгч байгууллагууд болох “Моннис Майнинг” ХХК, “Хишиг-Арвин Индустриал” ХХК, “Таван Толгой Оператор” түншлэл, “Ти Эн” Түншлэлийн ажилчдыг хамруулан гүйцэтгэсэн. Нийт 525 боодол өвсийг тараах байршуулсан. (Хавсралт №5)

Унаган Хайрхан: Цогтцэций сумын 9 гайхамшгийн нэг бөгөөд тус газарт 4 удаагийн арга хэмжээгээр 225 боодол өвс тараан байршуулах ажлыг зохион байгуулж ажилласан.




Зураг № 44. Унаган хайрханд биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлж буй байдал

Хангинахын Хад: Цогтцэций сумын Сийрст багийн нутагт орших тус уул нь байгалийн өвөрмөц тогтоц бүхий, олон янзын зэрлэг ан амьтан, жигүүртэн шувуудтай нутаг юм. Тус газарт 4 удаагийн арга хэмжээгээр 300 боодол өвсийг тараан байршуулах ажлыг зохион байгуулж ажилласан. Биотехникийн арга хэмжээгээр нийтдээ 525 боодол өвсийг тарааж байршуулсан.




Зураг № 45. Хангинахын хаданд биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэн өвс тараан байрлуулж буй байдал

5.6.2 Шувууны өртөлтийг багасгах арга хэмжээ

Дэлхийн байгаль хамгаалах сангийн судлаачид нүүдлийн болон махчин шувуудын тоо толгой цөөрч байгааг өөрсдийн гаргасан тайландаа тусгасан байдаг бөгөөд гол асуудал нь цахилгаанд цохиулах, цахилгаан дамжуулах байгууламж мөргөх зэрэг шалтгаанаас үүдэлтэй байдаг. Цахилгааны агаарын шугамын дагуу шувуудын эндэгдэл гарч буй эсэхэд судалгаа явуулж, гарах үр дүнд тулгуурлаж цаашид авах арга хэмжээг тодорхойлох шаардлагатай байна.

Хүснэгт № 20. Шувуу өртөлтийн судалгаа хийж гүйцэтгэхээр хувиарласан хуваарь

№	ЦДАШ-ын байрзүйн чиглэл	Гэрээт байгууллагууд	Хэмжээ, км	
1	Цанхи хотхоноос уурхай хүртэлх цахилгааны агаарын шугам	“Үндэсний Оператор” түншлэл	6	
2	Цанхийн зүүн уурхайн цахилгааны агаарын шугам	“Спейшл майнинг сервис” ХХК	6.2	
3	Цанхийн зүүн болон баруун уурхайн цахилгааны шугам	“Овоо толгой ресурс” ХХК	15.3	
4	Загийн усны хоолойн цахилгааны шугам	Ти Эн түншлэл	0-12.3 км хүртэл	61.6
5		“Үндэсний Уурхайчид” түншлэл-12.3 км “Кэй Эй Майнинг” ХХК-12.3 км “Кэй эй рентал сервис” ХХК баруун-12.3 км	12.3-61.6 км	

		“Кэй эй рентал сервис” ХХК зүүн-12.3 км		
Нийт			**89.1км**	

Цанхийн зүүн уурхайн судалгааг 2024 оны 1, 8 дугаар сард 2 удаа Цанхи хотхоноос уурхай хүртэлх цахилгааны агаарын шугам, Цанхийн зүүн уурхайн цахилгааны агаарын шугам, Цанхийн зүүн болон баруун уурхайн цахилгааны шугам, Загийн усны хоолойн цахилгааны шугам гэсэн маршрутын дагуу нийт 89.1км урт замд хийж гүйцэтгэсэн.

Ажиглалт судалгааг гэрээт компанийн байгаль орчны мэргэжилтнүүдийн хамт гүйцэтгэсэн ба газарзүйн байрлал тогтоогч GPS, дуран, зургийн аппарат, ЦДАШ-ын байрзүйн зураг багаж хэрэгсэл, материалыг ашигласан. Судалгааг гүйцэтгэхдээ агаарын шугамын дагуу автомашинаар бага хурдтайгаар болон явганаар цахилгааны шугам болон төмөр бетон тулгуурын орчимд шувууны сэг зэм, өд байгаа эсэхэд ажиглалт хийсэн.

Судалгаагаар цахилгааны дамжуулах агаарын шугам болон тулгуур анкеруудын доор үхсэн шувуудын сэг зэм болон өд тараагүй.



Зураг № 46. ЦДАШ-нд үзлэг шалгалт хийж буй байдал

Цанхийн баруун уурхайн шувуу өртөлтийн судалгааг 2024 оны 7 сараас 10-р сарын хооронд гэрээт компани тус бүр хуваарьлагдсан цахилгаан дамжуулах агаарын шугамын трассын дагуу хийж гүйцэтгэсэн.

Судалгаагаар цахилгааны дамжуулах агаарын шугам болон тулгуур анкеруудын доор үхсэн шувуудын сэг зэм болон өд тараагүй.



Зураг № 47. ЦБУ-н ЦДАШ дагуу шувуу өртөлтийн судалгаа хийж буй байдал

5.6.3 Хулгайн ангаас сэргийлэх сургалт зохион байгуулах

Цанхийн уурхайн гэрээт байгууллагуудад “Хулгайн антай тэмцэх, хулгайн ангаас урьдчилан сэргийлэх” сургалтыг ИТА, операторуудад 2024 оны 02 сараас 04 сарын хооронд 4 ээлжийн ажилтнуудыг хамруулан давхардсан тоогоор нийт 1148 ажилтнуудад зохион байгуулж ажилласан. Сургалтаар говийн бүсэд нутагладаг Монгол улсын улаан номонд бүргэгдсэн ховор болон нэн ховор амьтан ургамал болох хулан адуу, хар сүүлт, хавтгай, бөхөн, тахь, мазаалай, цагаан гоёо, улаан гоёо зэрэг амьтан ургамлыг хайрлан хамгаалах, хулгайгаар агнасан тохиолдолд хүлээх хуулийн хариуцлага, хулгайн анг мэдээлэх зэрэг өргөн агуулгын хүрээнд сургалтыг зохион байгуулсан.



Зураг № 48. Хулгайн антай тэмцэх сургалт зохион байгуулж буй байдал





Зураг № 49. Сургалт явуулсан бүртгэлийн хуудас

5.6.4 Хулгайн ан, байгаль орчны гэмт хэргийг бууруулахад орон нутгийн байгаль хамгаалагч нартай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх

2024 оны 03-р сарын 23 Дэлхийн усны өдрийг тохиолдуулан зохион байгуулсан уулзалт хэлэлцүүлгийн үеэр Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас Орон нутгийн байгаль хамгаалагч нартай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Байгаль хамгаалагч нарын эргүүл хийх түлш шатахуун болон бусад зүйлсэд шаардлагатай 5,800,0000 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж өгөх талаар мэдэгдсэн. Үүний дагуу тус санхүүжилтыг гэрээт байгууллагуудтай хамтран нийт 5,800,000 төгрөгийг Өмнөговь аймгийн Байгаль орчны хамгаалах сангийн дансанд төвлөрүүлсэн байна. Мөн 2024 оны 12 сарын 06-ны өдөр 11,500,000 төгрөгийг Өмнөговь аймгийн байгаль орчныг хамгаалах сангийн 100110051407 тоот дансанд нэмэлтээр төвлөрүүлсэн.

Хүснэгт № 21. Байгаль хамгаалах санд мөнгөн хандив шилжүүлсэн байдал.

№	Компани	Мөнгөн дүн	Шүлжүүлсэн данс	Баримт
1	Кэй эй майнинг ХХК, Үндэсний уурхайчин түншлэл	1,658,000₮	100110051407	 Худалдаа Хөгжлийн Банк Огноо: 2024.03.24 19:30:01 Шилжүүлгийн мэдээлэл Журналын №: 151583222 Системийн огноо: 2024.03.24 Нэр: ДОРЖЖАНЦАН ОТГОНСАЙХАН Илгээгч Дансны дугаар: 443601941 Нэр ДОРЖЖАНЦАН ОТГОНСАЙХАН Дүн 1,658,000.00 MNT Ханш 1.00 / нэг сая зургаан зуун таван нэгэн мянган төгрөг / Хүлээн авагч Банкны дугаар: 90 Дансны дугаар 100110051407 Банкны нэр Төрийн сан Нэр Өм.Бүрчинг хамгаалах сан 1,658,000.00 MNT 1.00 Гүйлгээний утга: ЕВ -ЭТТ- Кэй Эй майнинг ХХК Танд баярлалаа
2	Кэй эй рентал сервис ХХК	829,000₮	100110051407	 Худалдаа Хөгжлийн Банк Огноо: 2024.03.24 19:27:54 Шилжүүлгийн мэдээлэл Журналын №: 151582935 Системийн огноо: 2024.03.24 Нэр: ДОРЖЖАНЦАН ОТГОНСАЙХАН Илгээгч Дансны дугаар: 443601941 Нэр ДОРЖЖАНЦАН ОТГОНСАЙХАН Дүн 829,000.00 MNT Ханш 1.00 / найман зуун хорин есөн мянган төгрөг / Хүлээн авагч Банкны дугаар: 90 Дансны дугаар 100110051407 Банкны нэр Төрийн сан Нэр Өм.Бүрчинг хамгаалах сан 829,000.00 MNT 1.00 Гүйлгээний утга: ЕВ -ЭТТ- Кэй Эй Рентал сервис ХХК Танд баярлалаа
3	Эрдэс майнинг оператор ХХК	450,000₮	100110051407	 ГОЛОМТ БАНК Шахим гүйлгээний баримт
4	Нормаунт ХХК	415,000₮	100110051407	 ГОЛОМТ БАНК Шахим гүйлгээний баримт
5	Ти Жи Ви Си Өү ХХК	415,000₮	100110051407	 ГОЛОМТ БАНК Шахим гүйлгээний баримт

№	Компани	Мөнгөн дүн	Шүлжүүлсэн данс	Баримт
6	Овоот толгой ресурсес ХХК	830,000₮	100110051407	 Шилжүүлгийн мэдэгдэл/Transaction report
7	“Эрдэнэс Тавантолгой ” ХК	11,500,000 ₮	100110051407	


6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

6.1 Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
6.1.1	Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.	>3	Тайлант онд 2 сар болон 11 сард нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулан Салбарын удирдлагуудаар батлуулж хэрэгжүүлэн ажилласан. Тус төлөвлөгөөний дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-н мод үржүүлгийн 10 га талбайн зүүн талын 2.3 га талбай шороон зам болон нүүрс тээврийн 7.4км шороон замын хажуугаар Ханбогд сумын Цагаанхад чиглэлд зорчиж буй нүүрс тээврийн хэрэгслүүдийн гаргасан маршрутын бус замын 0.88га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж нийт 3.18 га талбайд нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн.	80%

6.1.1 Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх

2024 оны 02-р сард Нөхөн сэргээлт, ногоон байгууламж, агропаркийн 2024 оны төлөвлөгөө, 2024 оны 11 сард Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулж Салбарын удирдлагуудаар батлуулан хэрэгжүүлэн ажилласан.


БАТЛАВ
"ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ" ХК-ИЙН
САЛБАРЫН ЗАХИРАЛ Л.ДОРЖСҮРЭН

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЕТТ

НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ,
АГРОПАРКИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

	Нэр:	Гарын үсэг:	Албан тушаал
Танилцсан:	Б.Батсайхан		ХАБЭО гарын дарга
	О.Гүррагчаа		БОУБ халтайн дарга
Хянасан:	Б.Орнил		Байгаль орчны ахлах мэргэжилтэн
	Ц.Буянжаргал		Байгаль орчны ахлах мэргэжилтэн
Боловсруулсан:	Т.Нацаг		Байгаль орчны мэргэжилтэн
	Н.Борхүү		Байгаль орчны мэргэжилтэн
	О.Ууганцэц		Байгаль орчны мэргэжилтэн
	Ц.Болормаадаг		Байгаль орчны мэргэжилтэн

Өвөлжөө, Цогтцэций
2024 он


ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЕТТ

НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ,
АГРОПАРКИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

	Нэр:	Гарын үсэг:	Албан тушаал
Танилцсан:	Б.Батсайхан		Гарын дарга (Хадгалмор онуутуй байгаль орчны)
	М.Ануудэй		Халтайн дарга (Байгаль орчин уулы бодлогын)
Хянасан:	Б.Орнил		Ахлах инженер (Байгаль орчны)
	Ц.Буянжаргал		Ахлах инженер (Байгаль орчны)
Тайлан гаргасан:	Т.Нацаг		Инженер (Байгаль орчны)
	Н.Борхүү		Инженер (Байгаль орчны)
	О.Ууганцэц		Инженер (Байгаль орчны)
	Ц.Болормаадаг		Инженер (Байгаль орчны)

2024 он

Зураг № 50.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, тайлан.


ЗАХИРАЛ /ЛАВАРЛАСАН/ Л.ДОРЖСҮРЭН

НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. УНДЭСЛЭЛ

2. ХУГАЦАА: 2024 оны 11-р сарын 15-наас 2024 оны 12 сарын 15-ны өдөрлөнө

3. ХАМРАХ ХҮРЭЭ:

- Мод үржүүлэгийн 10 га талбайн зүүн талын хэсгээр овоолго хаягдал үлдэх хэсэг
- Товарлах 7.4 км замын хэсэг
- Тэй Эй Тумалтайн ШИК хэлбэл өрөх хэсгээр хаягдал үлдэх хэсэг

4. ШААРДЛАГАТАЙ ТЕХНИК: Автомобиль, дугуй эмээ

5. ХИЙХ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ:

6. ТАЛБАЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ:

ХЯНАСАН
АХЛАХ ИНЖЕНЕР/БАЙГАЛЬ ОРЧНЫ/ Б.ОРНИЛ

БОЛОВСРУУЛСАН
ИНЖЕНЕР/БАЙГАЛЬ ОРЧНЫ/ О.УУГАНЦЭЦ

БАТЛАВ
ГАЗРЫН ДАРГА
/ЙӨНДӨРТӨЛ ТЕХНИЙ/ Х.ДАВААХҮҮ

ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. УНДЭСЛЭЛ

2. ХУГАЦАА:

3. ХАМРАХ ХҮРЭЭ:

4. ШААРДЛАГАТАЙ ТЕХНИК:

5. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ:

6. ТАЛБАЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ:


ХЯНАСАН:
Гарын дарга
/Байгаль орчин, уулын бодлогын/ М.Ануудэй

БОЛОВСРУУЛСАН:
Инженер-Байгаль орчны/ Т.Нацаг

Зураг № 51. Техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө

2024 оны 09 сард нүүрс тээврийн 7.4км шороон замын хажуугаар Ханбогд сумын Цагаанхад чиглэлд зорчиж буй нүүрс тээврийн хэрэгслүүдийн гаргасан маршрутын бус 4м өргөнтэй, 2.2км урттай шороон замын 0.88га талбайд, 11 сард “Эрдэнэс Тавантолгой” ХК-н мод үржүүлгийн 10 га талбайн зүүн талын 10м өргөнтэй, 2.3км урттай шороон замын 2.3 га талбайд гэрээт компаниудтай хамтран техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэн тайлан боловсруулсан. (Хавсралт№ 26)

Мөн 2023 онд хийж гүйцэтгэсэн 5.2га талбайн техникийн нөхөн сэргээлтийг хүлээлгэн өгөх хүсэлтийг Цогтцэций сумын ЗДТГ-т хүргүүлсэн.



Зураг № 52. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил



Зураг № 53. Автомашины нөлөөгөөр дагтаршсан замыг сийрүүлэн ургамал ургах нөхцлийг хангасан байдал

Тайлант онд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвийг шинэ суурьшлын бүстэй холбох 2.92 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК нь өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн “Жинчин гранд” ХХК-аар хийлгэж байна. Уг замыг ашиглалтад орсны дараа тухайн бүсэд зорчиж байсан шороон замуудад техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж сум орон нутагт хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

6.2 Биологийн нөхөн сэргээлтийн бэлтгэл үе шат

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
6.2.1	Үрийн нөөц бүрдүүлэх	10 кг	Говийн бүсэд дасан зохицох модлог ургамлын үр, олон наст зүлэг, цэцгийн мандлын үр түүж бэлтгэх, худалдан авах ажлыг авч хэрэгжүүлсэн.	100%
6.2.2	Модлог ургамлын мөчир бэлтгэх	>5000	Гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу үрийн нөөц бүрдүүлэх, үр түүх ажлыг дүйцүүлэх байдлаар нийт 6000 ш улиас, сухайны бэлтгэсэн модлог мөчрийг мэргэжлийн байгууллагаас нийлүүлэх ажлыг Хаврын улирлын тарилтын үед авсан.	100%

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
6.2.3	Хоолны хаягдлаар компост бордоо бэлтгэх, бордоог нөхөн сэргээлтэд ашиглах	Тухайн жилд гарах хаягдлын хэмжээгээр	Хоол хүнсний хаягдалд өндөгний хальс, өндөгний савлагааны цаасан сав буюу сетка, төрөл бүрийн агшаасан будааны үлдэгдэл, төрөл бүрийн жимс болон ногооны хальс, төрөл бүрийн түүхий будаа болон гоймон, гурилын хатсан үлдэгдэл, үйрмэг зэрэг бүтээгдэхүүний хаягдлыг жижиглэн хэрчиж холиод, хар шороо, бууц, үртэс зэргийг үечлэн давхарлан хийж, услан чийглэж бэлтгэн ялзруулан исгэх аргаар боловсруулсан. Бордоог 1 тн-ын хэмжээтэй 2 ш саванд бэлтгэсэн бөгөөд мод үржүүлгийн 10 га талбайн хамгаалалтын зурвасаар тарьсан модыг бордсон.	100%

6.2.1 Үрийн нөөц бүрдүүлэх

Говийн бүсэд дасан зохицох модлог ургамлын үр, олон наст зүлэг, цэцгийн мандлын үр түүж бэлтгэх, худалдан авах ажлыг авч хэрэгжүүлсэн.

Хүснэгт № 22. Үрийн нөөц бүрдүүлсэн байдал

№	Модны нэр, төрөл	Тоо,кг	Үр түүсэн, худалдаж авсан газар	Тайлбар
Модлог ургамлын үр				
1	Хайлаас /*Ulmus pumila/*	40	Өмнөговь аймаг, Даланзадгад сум, Баяндалай сум	6-р сарын эхний долоо хоногт таримал 30 настай хайлаас модноос үрийг түүж бэлтгэсэн.
2	Жигд */Elaeagnus moorcroftii/*	50	Таримал ургамал ХХК	Дундговь аймаг
3	Заг */Haloxylon ammodendron Merge/*	30		
4	Бүйлс */Amygdalus mongolica/*	50		
5	Гүйлс /*Armeniaca sibirica/*	50		
6	Харгана /Caragana spinos/	20		
7	Агч */Acer palmatum/*	30		
Олон наст зүлэг, цэцгийн үр				
8	Олон наст зүлэгний үр	2000	Таримал ургамал ХХК	
9	Чихэр өвс */Glycyrrhizae glabra/*	40		
10	Гүргэм */Crocus sativus/*	40		
11	Мандалын цэцэгний үр	200 уут		

Байгалийн ургамлын үрийн нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд 10 кг-аас багагүй нутгийн ургамлын үрийг түүж хадгална. Говийн нөхцөлд ургахад тохиромжтой нутгийн бэлчээрийн олон наст ургамал болон мод, сөөгний үрийг 2024 онд үрслүүлж цаашид тарьж ургуулан биологийн нөхөн сэргээлтийн ажилд ашиглахаар ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд “ЭТТ” ХК-ийн Байгаль орчин, усны бодлогын хэлтсийн мэргэжилтнүүд 2024 оны 5-р сарын 19-ний өдөр Өмнөговь аймгийн Даланзадгад болон Баяндалай сумаас 40 кг орчим Хайлаасны үрийг түүсэн.



Зураг № 54. Хайлаас модны үр түүж бэлтгэж буй байдал

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Сая тонн -Сая мод” хөтөлбөрийн дагуу говийн бүс нутгийн цөлжилтийг бууруулах, хуурайшилтыг багасгах, агро ойн аж ахуйг нэмэгдүүлэх, уул уурхайн нөлөөлөлд өртөж, эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх чиглэлийг зорилго болгон ажиллаж байна. Эрдэнэс Агропаркын 10 га мод үржүүлгийн ил талбай болон хүлэмжинд модны үр, модлог мөчрөөр үржүүлэх, 2-3 настай далд үндэсний системтэй модны суулгацыг нөхөн сэргээлт, ойжуулалтанд шилжүүлэх ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж байна.

6.2.2 Модлог ургамлын мөчир бэлтгэх

Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт байрлах 0.45 га эх модны талбайд ургасан таримал Сухай 70ш, Улиас 40ш модыг тайрах, танах ажлыг ургамлын тайван байдалд орсон үед буюу 2024 оны 2 сард зохион байгуулсан.



Зураг № 55. Модыг танаж бэлтгэсэн байдал

Гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу үрийн нөөц бүрдүүлэх, үр түүх ажлыг дүйцүүлэх байдлаар нийт 6000 ш улиас, сухайны бэлтгэсэн модлог мөчрийг мэргэжлийн байгууллагаас нийлүүлэх ажлыг хаврын тарилтын үед авсан.



Зураг № 56. Модлог ургамлын мөчрөөр ил талбайд үржүүлэг хийж буй байдал

Мөн мод үржүүлгийн талбайн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 2023 оны худалдан авалтын төлөвлөгөөний дагуу стандартын шаардлага хангасан сухайн мөчир нийлүүлэх, 20-25 см урттайгаар тайрч бэлтгэсэн модлог мөчрийг 10,000 ш хүлээн авч чийгтэй хөрсөнд түр хадгалсан.

Тарилтанд бэлтгэх: Мод үржүүлгийн 10 га талбайд 50:25м харьцаатай ил талбайд хөрсийг хагалж, хар шороо, сажа хөрсийг хольж хөрс сийрүүлэгч култиватороор боловсруулж 16 далан /хамар/ үүсгэсэн. Модлог мөчрийн тарилтын өмнө өсөлт, ногоон масс идэвхжүүлэгч бодисыг 15%-ийн процентын уусмалаар устай найруулж, 48 цаг усанд дэвтээсэн. Хөрс боловсруулалтын ажил дууссаны дараа дуслын усалгааны системийг угсарч, шороон далан бүрд хөрсний плёнк хучлагаар мөчир тарих хэсгийг хучсан.



Зураг № 57. Тарилт хийх үе болон ургасан байдал

Тус талбайн дуслын усалгаагаар 12 цаг усалж 10000ш мөчрийн тарилтыг 2024 оны 05 сарын 27-ний өдөр хийсэн. Тарилтын дараах усалгааг өдөр бүр хийж, усаар дамжуулан нийлмэл бордоог хийж ургалтыг нэмэгдүүлсэн. Сухай мөчрийн өндрийн өсөлт 60-80см, амьдралтын хувь 86%-ийн ургалттай байна.



Зураг № 58. Мөчрөөр ургуулсан ил талбайн зураг

6.2.3 Хоолны хаягдлаар компост бордоо бэлтгэх, бордоог нөхөн сэргээлтэд ашиглах

Ажилчдын хотхоны гал тогооноос гарч буй хүнсний хаягдал/хүнсний ногооны хальс, өндөгний сетик/ ашиглан хуванцар 1 тоннын багтаамжтай 2 ширхэг саванд хийж, усалж ялзруулсан ба био компост бордоог мод үржүүлгийн талбайн хамгаалалтын зурвасаар тарьсан модонд хийсэн.

Хоол хүнсний хаягдалд өндөгний хальс, өндөгний савлагааны цаасан сав буюу сетка, төрөл бүрийн агшаасан будааны үлдэгдэл, төрөл бүрийн жимс болон ногооны хальс, төрөл бүрийн түүхий будаа болон гоймон, гурилын хатсан үлдэгдэл, үйрмэг зэрэг бүтээгдэхүүний хаягдлыг жижиглэн хэрчиж холиод, хар шороо, бууц, үртэс зэргийг үечлэн давхарлан хийж, услан чийглэж бэлтгэн ялзруулан исгэх аргаар боловсруулсан. Бордоог 1 тн-ын хэмжээтэй 2 ш саванд бэлтгэсэн бөгөөд мод үржүүлгийн 10 г талбайн хамгаалалтын зурвасаар тарьсан модыг бордсон.



Зураг № 59. Хоолны хаягдлаар биокомпост хийж буй байдал

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Эх монголын байгаль” ХХК-тай “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Эх монголын байгаль” ХХК (цаашид гүйцэтгэгч гэх) шалгарч, 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр ЭТТ-2023/1476 тоот гэрээг байгуулан 1 жилийн хугацаанд хамтран ажилласан ба дараах байдлаар төлөвлөгөөг хэрэгжүүлээд байна.


№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
7.1	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дунд болон урт хугацааны төлөвлөгөө гаргах, талбайг нэмэгдүүлж шинэчлэн гаргах	-	“Эх Монголын байгаль” ХХК нь “Биологийн олон янз байдлыг хамгаалах урт хугацааны төлөвлөгөө, шаардагдах эдийн засгийн тооцооллыг хийж 2024.11.18-ны өдөр Захиалагч талд ирүүлээд байна.	100%
7.2	2023 оны ДХТ-г бүрэн хэрэгжүүлж дуусгах	1ш	2023-2024 онд Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгааллын чиглэлээр хийгдсэн ажлыг 2024 оны 11 дүгэр сарын 27-ны өдөр Цогтцэций сумын Засаг даргийн тамгын газрын мэргэжилтнүүд болон малчин иргэдэд танилцуулсан. 2024 оны 12 сарын 01-ны байдлаар төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж дуусгасан.	100%
7.3	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хамтарсан багийг орон нутагтай хамтран ажиллуулах, дэмжлэг үзүүлэх	-	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хамтарсан багийг дэмжиж, хулгайн антай тэмцэх зорилгоор төрийн сангийн 100110051407 тоот ӨМ БОрчныг хамгаалах сангийн дансанд холбогдох төлбөрийн дэмжлэгийг үзүүлж хамтран ажилласан.	100%
7.4	2024 оны дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	2024 оны 07-р сард 2024 оны Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажилласан.	100%
7.5	Бэлчээр хашиж ургамлын нөмөргийг сайжруулах	2 га	“Эрдэнэс Тавантолгой” ХК нь биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах ажлын Бэлчээрийн нөхцөлийг сайжруулах багц ажлын хүрээнд уурхайн нөхөн сэргээлтийн зориулалтаар тарих олон наст ургамлын үрийн нөөц бэлтгэх үр үржүүлгийн ажил эхлүүлэх туршилт, бэлчээрийг шар ба хөх бууцтай олон наст ургамлын үрээр хачирлан тарьж сайжруулах, говийн нөхцөлд малын тэжээл бэлтгэх зориулалтаар нэг наст ургамлуудыг тарьж турших ажлуудыг төлөвлөн гүйцэтгэж байна.	100%

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
7.6	Бэлчээрийг сайжруулах ажлын хүрээнд худаг гаргах, Хулгайн ангийн мэдээллийг хүлээж авах 24 цагийн утсыг ажиллуулах, экологийн цагдаад мэдээллэх	-	Бэлчээрийг сайжруулах чиглэлээр 1 худгийг мэргэжлийн байгууллагаар гаргасан. Мөн байгаль орчны гомдол санал авах шуурхай дугаарыг 2023 оноос эхлэн ажиллуулж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар хулгайн антай холбоотой дуудлага мэдээлэл ирүүлээгүй байна. Байгаль орчны мэдээллийн утас нь компанийн мэдээллийн дугаар болох 7505-5555 дугаараар холбогдож 104 дугаарт холбосноор шууд Салбарын Байгаль орчин, усны бодлогын хэлтэстэй холбогдох тохиргоотой болгосон. Мөн Салбарын Онцгой байдлын нэгжийн шуурхай утсыг давхар ашигладаг бөгөөд Онцгой байдлын нэгж нь 24/7 тогтмол утсаар мэдээллийг авч ажилладаг	100%

7.1 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дунд болон урт хугацааны төлөвлөгөө гаргах

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд бэлчээр усжуулалтын зориулалттай худгийн байршлыг сонгохдоо Цогтцэций сумын Засаг даргын тамгын газар болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн байгаль орчны мэргэжилтнүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр сонгосон. Сонгосон талбай нь Цогтцэций сумын төвөөс зүүн хойд зүгт 29.0 км зайд Билгэх багийн нутаг дэвсгэр Төгрөгийн худаг орчим байрлана.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах зөвлөх үйлчилгээний гэрээг “Эх Монголын Байгаль” ХХК-тай 2023 оны 11-р сарын 28-ны өдөр байгуулан ажиллаж байна. Гэрээний ажлын даалгаврын 14-р зүйлд “Биологийн олон янз байдлыг хамгаалах урт хугацааны төлөвлөгөө, шаардагдах эдийн засгийн тооцооллын тайлан хийж, захиалагч талд 2024 оны 11-р сарын 18-ны өдөр ирүүлсэн. Дүйцүүлэн хамгаалах талбайг НБҮ, ЗУХ-н үйл ажиллагаатай уялдуулан нэмэгдүүлж төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан.


ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ "ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН УУРХАЙН БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН 2025-2034 ТӨЛӨВЛӨГӨӨ

ГҮЙЦЭТГЭСЭН: "ЭХМОНГОЛЫН БАЙГАЛЬ" ХХК

УЛААНБААТАР 2024

ГАРЧИГ

ГАРЧИГ 2
УДИРТГАЛ 3
НЭГ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗАРДАЛ 4
1.1. Амьтны олон янз байдлыг сайжруулах зорилтууд 4
1.2. УРГАМЛЫН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ ЗОРИЛТ, ТӨЛӨВЛӨГӨӨ 7
1.3. ОЙН ЗУРВАС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ 11
1.4. НИЙТ ЗАРДАЛ 12

Гүйцэтгэсэн: "Эхмонголын байгаль" ХХК 2

Зураг № 60. Урт хугацааны төлөвлөгөө

7.2 2023 онд оны ДХТ-г бүрэн хэрэгжүүлж, дуусгах.

2023 оны 11 сарын 28-ны өдөр Эхмонголын байгаль ХХК-тай байгуулсан ЭТТ-2023/1476 дугаартай “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах зөвлөх үйлчилгээний гэрээ”- ний дагуу дараах чиглэлээр дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Уст цэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах чиглэлээр
- Бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлээр
- Зэрлэг амьтны мониторинг хийх, биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх
- Ойн зурвас байгуулах чиглэлээр хийгдсэн ажил гэсэн-н чиглэлээр хийж гүйцэтгэсэн.


Дээрх гэрээний дагуу жилийн хугацаанд гүйцэтгэгч компанитай хамтран Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын тайланг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр гүйцэтгэгч компанийн зөвлөхүүд (П.Ариунсүрэн, Б.Сайнзаяа, Т.Алтансүх) Цогтцэций сумын байгаль хамгаалагч Энхнартай хамтран малчин иргэд, багийн засаг дарга нар болон ЗДТГ-ын мэргэжилтнүүдэд танилцуулж, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Захиалагчийг төлөөлж байгаль орчин усны бодлогын хэлтсийн байгаль орчны ахлах инженер Б.Оргил, байгаль орчны инженер Д.Отгонсайхан нар оролцов.



Зураг № 61. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлыг танилцуулж буй байдал

Мөн ирсэн зочидод “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дүйцүүлэн хамгаалах талбайн биологийн олон янз байдлын зурагт лавлах номыг тараан өгсөн. Тус номыг нийт 300 ширхэгийг хэвлүүлсэн бөгөөд тус гарын авлагаар дамжуулан биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж буй талбайн амьтан, ургамлын олон янз байдлыг олон нийтэд танилцуулахаар төлөвлөж байна. 2023 оны 12 сараас 2024 оны 12 сарын 1-ны байдлаар нэгдсэн тайланг гэрээний дагуу амжилттай хэрэгжүүлэн ажилласан.



Зураг № 62. Зурагт лавлах.




7.3 Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хамтарсан багийг орон нутагтай хамтран ажиллуулах, дэмжлэг үзүүлэх

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хамтарсан багийг дэмжиж, хулгайн антай тэмцэх зорилгоор төрийн сангийн 100110051407 тоот Өмнөговь аймгийн Байгаль орчныг хамгаалах сангийн дансанд холбогдох төлбөрийн дэмжлэгийг үзүүлж хамтран ажилласан.

Нийт 5,800,000 төгрөгийг Өмнөговь аймгийн Байгаль орчны хамгаалах сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт № 23. Байгаль хамгаалах санд мөнгөн хандив шилжүүлсэн байдал.

№	Компани	Мөнгөн дүн	Шүлжүүлсэн данс	Баримт
1	Кэй эй майнинг ХХК, Үндэсний уурхайчин түншлэл	1,658,000₮	100110051407	
2	Кэй эй рентал сервис ХХК	829,000₮	100110051407	

3	Эрдэс майнинг оператор ХХК	450,000₮	100110051407	
4	Нормаунт ХХК	415,000₮	100110051407	
5	Ти Жи Ви Си Өү ХХК	415,000₮	100110051407	
6	Овоот толгой ресурсес ХХК	830,000₮	100110051407	

7.4 2024 оны дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллах

2024 оны 07-р сард 2024 оны Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөг батлуулсан. 2024 оны 08 сарын 26-ны өдрийн “Ийрт Плас” ХХК-тай байгуулсан ЭТТ-2024/1397 дугаартай “Нүүрс баяжуулах үйлдвэрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу нүүрс баяжуулах үйлдвэр, загийн усны хоолойн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний чиглэлээр 4-н ажлыг тусгаж хэрэгжилтийг гаргаж ажилласан.

БАТЛАВ: САЛБАРЫН ХАББОГ-ЫН ДАРГА
Б.БАТСАЙХАН

2024 ОНД ХИЙХ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.07.14


№	Дүйцүүлэн хамгаалах ажлын чиглэл	Тоо хэмжээ	Байршил	Хугацаа
1	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах байршилд суурь судалгааг хийх	-	НБҮ, ЗУХ	Жилийн хугацаанд
2	Дүйцүүлэн хамгаалах талбайд амьтны судалгаа хийх	-	НБҮ, ЗУХ	
3	Хөнжлийн нуруунд амьтдын нүүдлийн транс тогтоох, камержуулах	3 камер	НБҮ, ЗУХ	
4	Булгийн эхийг хашиж хамгаалах	2 булаг	НБҮ, ЗУХ	


ХЯНАСАН:
БОУБХ-Н ДАРГА М.АНУДАРЬ

БОЛОВСРУУЛСАН:
БОУБХ-Н АХЛАХ ИНЖЕНЕР Ц.БҮРЭНЖАРГАЛ

Зураг № 63. 2024 онд хийх дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө

Судалгааны талбай нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрт буюу 1-р багийн нутаг дэвсгэрт Улаанбаатар хотоос 540 км, аймгийн төв Даланзадгад хотоос зүүн зүгт 90 км, Цогтцэций сумын төвөөс зүүн хойш зүгт 65 км хүртэл зайд эхлэлийн цэг байрлана.





Арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Гүйцэтгэлийн мэдээлэл
Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах байршилд суурь судалгааг хийх /Хөнжлийн нуруунд амьтдын нүүдлийн тогтоох, камержуулах/	НБҮ ЗУХ	3 камер	Хөдөлгөөн мэдрэгч бүхий автомат камерыг захиалагч талтай зөвшилцсөний үндсэнд Хангинахын аманд 2 ш, Тугийн цохио орчимд 1 ширхгийг байрлуулсан бөгөөд камерын бичлэгийг цаг тухайд нь авч боловсруулан амьтны судалгааг хийж байна.
Булгийн эхийг хашиж хамгаалах	НБҮ ЗУХ	2 булаг	Цогтцэций сумаас зүүн урд зүгт 35 км орчим зайд Будагтын хяр хэмээх газар булгийн эхийг хашиж хамгаалав. 2 дах булгийн эхийг хашиж хамгаалах материалыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн орон

			нутгийн салбарын байгаль орчны хэлтэст хүлээлгэн өгөв.

7.4.1. Биологийн олон янз байдлын суурь судалгаа

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Ухаа худгийн бүлэг ордоос нүүрс олборлох, улсын хилийн боомт хүртэлх нүүрс тээврийн үйл ажиллагаанаас биологийн төрөл зүйлд, ялангуяа туруутан амьтад, тэдний амьдрах орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Сүүлийн жилүүдэд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэнтэй холбоотойгоор Тавантолгойн ордоос Гашуунсухайт хилийн боомт чиглэлийн авто болон төмөр зам, Зүүнбаян чиглэлд төмөр зам ашиглалтад бүрэн орсон, Ханги мандал хилийн боомт чиглэлд авто замын барилгын ажил идэвхтэй явагдаж байгаа бол Зүүн цагаан дэлийн чиглэлд мөн авто болон төмөр зам барихаар төлөвлөж байна. Эдгээр дэд бүтцээс гадна Цогтцэций сумаас Улаанбаатар, Даланзадгад чиглэлд улсын чанартай авто замууд ашиглалтад орсноос гадна орон нутгийн чанартай шороо, сайжруулсан замуудыг дурдаж болно. Эдгээр уурхайн олборлох үйл ажиллагааны нөлөөллөөс гадна шугаман дэд бүтцийн нөлөөлөл нь туруутан амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөнд саад учруулах, амьдрах орчны хуваагдал, доройтол бий болох нөхцөл үүсээд байна.

Монгол оронд өнөөдрийн байдлаар 140 зүйлийн хөхтөн амьтан бүртгэгдээд (Батсайхан,нар 2022) байгаа бол өмнөд говийн тойрогт 33 зүйл (Банников, 1954), харин Тавантолгойн ордын орчимд 22 зүйл хөхтөн амьтад бүртгэгдээд байна. Үүний дотор аргаль хонь, янгир ямаа, хар сүүлт зээр, цагаан зээр, хулан адуу зэргийг дурдаж болно.

Хөхтөн амьтны хээрийн судалгааны бүртгэл

Хээрийн судалгааны арга зүй

Хээрийн судалгааг Цогтцэций сум, Хангинахын ам, Тугийн цохио чиглэлд 2024 оны 09 сарын 16-17-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ. Ингэхдээ туруутан амьтад тохиолдох боломжтой газруудад харууц цэг сонгох, мөн шугаман замналын аргаар автомашинаар болон явганаар явж ажиглалт, бүртгэл хийсэн болно. Мэрэгч амьтдын судалгаанд Sharman зайтайгаар 400 метр талбайд байрлуулж өгөөшинд самрын тос, будаа зэргийг ашиглалаа.

Хээрийн судалгааны бүртгэл


Хээрийн судалгаагаар Хангинахын ам орчимд 2 аргаль хонь, 6 янгир ямаа, 60 гаруй цагаан зээрийн сүрэг бүртгэгдсэн бол Тугийн цохио орчимд мөн 11 тооны янгир ямааг бүртгэж баримтжууллаа. Бусад хөхтөн амьтдаас бор туулай, монгол чичүүл, улбар шанаа зурам, үнэг, хярс зэрэг амьтдыг бүртгэж баримтжуулсан болно (Хүснэгт 1, зураг 1).

Хүснэгт № 24. Хөхтөн амьтны зүйлийн жагсаалт, хамгааллын статус, тоо толгой, тархалт

№	Зүйлийн нэр	Улаан дансны үнэлгээ	Бүс нутгийн үнэлгээ	Тоо толгой, байршил
1	Аргаль хонь	ХБ	УБ	Хангинахын ам, түүнээс урагш Бичигт хад хүртэл тархана, тоо толгой 10 орчим
2	Янгир ямаа	АӨ	ХБ	Хангинахын ам, Тугийн цохио орчимд, тоо толгой 60 орчим
3	Цагаан зээр	УБ	АӨ	Цогтцэций сумаас Хангинахын ам чиглэлд цөөн таарсан бол

				Хангинахын ам орчимд 60 гаруй амьтантай сүрэг
4	Үнэг	АӨ	ХБ	Хангинах
5	Хярс	АӨ	ХБ	Хангинах, Тугийн цохио
6	Бор туулай	АӨ	АӨ	Тугийн цохио орчимд 1 бодгаль
7	Улбар шанаа зурам	АӨ	АӨ	Цогтцэций сумаас Хангинахын ам явах зам дагуу
8	Монгол чичүүл	АӨ	АӨ	Хангинахын ам орчимд зөөлөн хөрстэй, сайр дагуу
9	Сибирь алаг даага	АӨ	АӨ	Эдгээр зүйлүүд нь өвөл ичээлдэг бөгөөд дүйцүүлэн хамгаалах талбайн зөөлөн хөрстэй, сайрууд, хөндий, уулын хээрт түгээмэл тохиолдоно.
10	Говийн алагдаага	АӨ	АӨ	
11	Савагдаахай	АӨ	АӨ	
12	Элсний зусаг	АӨ	АӨ	

Товчилсон үгийн тайлбар: АӨ-Анхааралд өртөхөөргүй, ХБ-Ховордож болзошгүй, УБ-Устаж болзошгүй



Зураг № 64. Хээрийн судалгаа хийсэн замнал болон автомат камерын байршил.



Зураг № 65. Суурь судалгааны үеэр бүртгэгдсэн амьтны зургаас.





Зураг № 66. Судалгааны зориулалтаар байрлуулсан камеруудын дуранд бичигдсэн зургийг дараах зургуудаар түүвэрлэн үзүүлэв.

Шувуудын бүртгэл

Хээрийн судалгаагаар багт хамаарах 30 зүйлийн шувуудыг бүртгэсэн бөгөөд түүний Судалгааны талбайд бүртгэгдсэн зүйлүүдээс 17 буюу 56 хувь нь суурин, 13 буюу 43 хувь нь нүүдлийн зүйл байна.

Хүснэгт № 25. Шувуудын зүйлийн жагсаалт болон оршин амьдрах хэлбэр

№	Зүйлийн Монгол нэр	Зүйлийн шинжлэх ухааны нэр	Цогтцэций сумын төв орчим	Хангинахын ам орчим	Оршин амьдрах статус
GALLIFORMES-ТАХИА					
1	Эрээн хавирга хахилаг	*Alectoris chukar*			Суурин
ACCIPITRIFORMES-ХАРЦАГА					
2	Нөмрөг тас	*Aegypius monachus*			Суурин
3	Саарал хулд	*Circus cyaneus*			Нүүдлийн
4	Ооч ёл	*Gypaetus barbatus*			Суурин
5	Шилийн сар	*Buteo hemilasius*			Суурин
PASSERIFORMES-БОР ШУВУУ					
6	Хон хэрээ	*Corvus corax*			Суурин
7	Хар хэрээ	*Corvus corone*			Суурин
8	Алаг шаазгай	*Pica pica*			Суурин
9	Алагтуу хэрээ	*Coloeus dauuricus*			Нүүдлийн
10	Дэрсний жиргэмэл	*Alaudala cheleensis*			Суурин
11	Монгол болжмор	*Melanocorypha mongolica*			Суурин
12	Эвэрт болжмор	*Eremophila alpestris*			Суурин
13	Науманны хөөндэй	*Turdus naumanni*			Нүүдлийн
14	Хар гүеэт хөөндэй	*Turdus atrogularis*			Нүүдлийн
15	Жирхэн дууч шувуу	*Phylloscopus proregulus*			Нүүдлийн
16	Хөх зоот гургалдай	*Tarsiger cyanurus*			Нүүдлийн
17	Дагуур галсүүлт	*Phoenicurus auroreus*			Нүүдлийн
18	Тагийн хайруулдай	*Prunella collaris*			Суурин
19	Шарга хайруулдай	*Prunella fulvescens*			Суурин
20	Хадны бор шувуу	*Petronia petronia*			Суурин
21	Хээрийн бор шувуу	*Passer montanus*			Суурин
22	Харзны шийхнүүхэй	*Anthus spinoletta*			Нүүдлийн
23	Дуулгат бужирга	*Fringilla coelebs*			Нүүдлийн
24	Бор цэгцүүхэй	*Linaria flavirostris*			Нүүдлийн

№	Зүйлийн Монгол нэр	Зүйлийн шинжлэх ухааны нэр	Цогтцэций сумын төв орчим	Хангинахын ам орчим	Оршин амьдрах статус
25	Годлевскийн хөмрөг	*Emberiza godlewskii*			Суурин
26	Хар шанаат хөмрөг	*Emberiza rustica*			Нүүдлийн
27	Талын үнсэн дунхай	*Lanius pallidirostris*			Нүүдлийн
28	Бөөвөлжин өвөөлж	*Upupa epops*			Нүүдлийн
PTEROCLIFORMES-НОГТРУУ					
29	Монгол ногтруу	*Syrrhaptes paradoxus*			Суурин
COLUMBIFORMES-ТАГТАА					
30	Хадны тагтаа	*Columba rupestris*			Суурин

Тайлбар: Цэнхэр өнгөөр бүртгэгдсэн газрыг тоймлов.

Мөлхөгчдийн бүртгэл

Хээрийн судалгаагаар Хангинахын уул, түүний орчимд 3 зүйлийн гүрвэл (цоохор хонин гүрвэл, монгол гүрвэл, говийн гүрвэл) бүртгэгдсэн байна. Үүнээс цоохор хонин гүрвэл тоо толгойн хувьд хамгийн элбэг, бүхий л амьдрах орчинд тохиолдох бол, монгол гүрвэл зөвхөн бэсрэг уулсын хад, асгатай газарт цөөн, говийн гүрвэл уулын хээр, жалга, судаг дагуу цөөн тохиолдоно.

Энэ бүс нутагт 2 зүйл могой (рашааны болон бамбай хоншоорт) түгээмэл тохиолдох бөгөөд эдгээр мөлхөгчид нь бүс нутгийн болоод Олон улсын хэмжээнд анхааралд өртөхөөргүй гэж үнэлэгдсэн, хэвийн зүйл юм.

7.4.2. Булгийн эхийг хашиж хамгаалах ажил

Цогтцэций сумаас зүүн урд зүгт 35 км орчим зайд Будагтын хяр хэмээх газар булгийн эхийг хашиж хамгаалсан. 2 дах булгийн эхийг хашиж хамгаалах материалыг Эрдэнэс Тавантолгойн орон нутгийн салбарын байгаль орчны хэлтэст хүлээлгэн өгөв.





7.5 Бэлчээр хашиж, ургамлын нөмрөгийг сайжруулах

Цөлөрхөг хээрийн бүсэд уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэс Тавантолгой” ХК нь биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах ажлын Бэлчээрийн нөхцөлийг сайжруулах багц ажлын хүрээнд уурхайн нөхөн сэргээлтийн зориулалтаар тарих олон наст ургамлын үрийн нөөц бэлтгэх үр үржүүлгийн ажил эхлүүлэх туршилт, бэлчээрийг шар ба хөх буюцтай олон наст ургамлын үрээр хачирлан тарьж сайжруулах, говийн нөхцөлд малын тэжээл бэлтгэх зориулалтаар нэг наст ургамлуудыг тарьж турших ажлуудыг төлөвлөн гүйцэтгэж байна.

Бэлчээр тэжээлийн зориулалтаар олон ба нэг наст ургамал тарих туршилт судалгааны ажлыг цөлөрхөг хээрийн бүсэд усалгаатай ба усалгаагүй нөхцөлд гүйцэтгэх зорилготой дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Бэлчээрийн олон наст ургамлын үр үржүүлэг хийх зориулалтаар үетэн буурцагтан олон наст ургамлын 3 зүйл ургамлын үрээр туршилт судалгаа хийх;
- Тэжээлийн зориулалтаар нэг наст судан өвсний 3 сорт, хошуу будаа, булган сүүл гэсэн 5 зүйл ургамлын үр тарьж турших;
- Туршилт судалгааны талбайн хайлаасыг шуудуугаар тарьж салхины хамгаалалт хийж, агро ойжуулалтын аргаар тусгаарлах зэрэг болно.

2024 оны 5 дугаар сарын 25-аас 5 дугаар сарын 31-ийг дуустал бэлчээр сайжруулах, цаашид тэжээл үйлдвэрлэлийн зориулалтаар олон ба нэг наст үетэн, буурцагтан ургамлын үрээр тарих туршилт судалгааны ажлыг агро ойжуулалтын аргатай хослуулан гүйцэтгэсэн.



Зураг № 67. Судалгааны талбайн зураг

Судалгаанд хамрагдсан ургамлуудыг усалгаатай ба усалгаагүй болон шар ба хөх буцаар бордсон нөхцөлд 3 давталтаар тариалсан ба талбайд дэвсгийг сугалааны (тохиолдлын) аргаар байрлуулсан. Малын хөлөөр болон машины зам гарган доройтуулсан халцгай газар ихтэй бэлчээрийг үетэн, буурцагтан ургамлаар нөхөн сэргээхийн тулд хүрз жоотуу болон хөрс хагалах багаж ашиглан 20-30 см эргүүлэн хагалж, чулуу хогийг цэвэрлэж, тэгшлэн бэлтгэсний дараа дэвсэгт хуваан тарьсан.



Зураг № 68. Олон наст ургамал тарихаар бэлтгэж буй байдал



Зураг № 69. Олон наст ургамал тарьж, услаж буй байдал

7.6 Нэмэлтээр хийгдсэн ажил

7.6.1. Бэлчээр усжуулах худаг гаргах

Гадаргын геофизикийн хэмжилтийн тайлал, геологийн тогтоц, гадаргын хэв шинжид тулгуурлан хэмжилт хийсэн цэгт худгийн өрөмдлөгийн ажлыг явуулав. Өрөмдлөгийг БНСУ-д үйлдвэрлэгдсэн multi 30 маркийн суурь өрөм, XHP1076 маркийн 20 барын хүчин чадал бүхий хийн компрессороор 90.0м хүртэл гүнд өрөмдсөн. Өрөмдлөгийг 0.0-90.0м гүнд 160 мм-ийн диаметрээр өрөмдөж 159мм ган төмрөн шүүр яндангийн цувааг суулгасан.

Өрөмдлөгийн үед 20.0-21.0м гүнд эхний уст үе, 60.0-62.0м гүнд хоёр дахь уст үеийг нэвтэрч, өрөмдлөгийн дараа цахилгаан насосоор 24.0 цагийн турш шавхалтыг хийхэд 1.2 л/с ундаргад 10.0м бууралт үзүүлсэн болно.

Гүний худгийн барилга нь контейнероор баригдсан, төмөр листэн хаалга, худгийн зориулалт бүхий хаяг өнгө үзэмж сайтай. Худагт 1.5кв бүхий БНХАУ-д үйлдвэрлэсэн 220В-ын цахилгаан ус өргүүр, 32мм голчтой хуванцар материалтай ус өргөх хоолой, 5.0кв-ын 220В-ын бензин хөдөлгүүртэй цахилгаан үүсгүүртэй.



Зураг № 70. Бэлчээр усжуулах худаг өрөмдөж гаргасан байдал

7.6.2. Байгаль орчны гомдол санал авах

Байгаль орчны гомдол санал авах шуурхай дугаарыг 2023 оноос эхлэн ажиллуулж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар хулгайн антай холбоотой дуудлага мэдээлэл ирүүлээгүй байна.

Байгаль орчны мэдээллийн утас нь компанийн мэдээллийн дугаар болох 7505-5555 дугаараар холбогдож 104 дугаарт холбосноор шууд Салбарын Байгаль орчин, усны бодлогын хэлтэстэй холбогдох тохиргоотой болгосон. Мөн Салбарын Онцгой байдлын

нэгжийн шуурхай утсыг давхар ашигладаг бөгөөд Онцгой байдлын нэгж нь 24/7 тогтмол утсаар мэдээллийг авч ажилладаг.





Зураг № 71. Дуудлага хүлээн авах утсыг техникүүдэд байрлуулсан байдал

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
9.1	Цагаан овоо багийн иргэдтэй гэрээ байгуулах, нөхөн олговор олгох	40 иргэн	Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/318 дугаар тушаалаар батлагдсан Цагаан-Овоо багийн (Хөрөнгийн үнэлгээнээс хоцорсон гэх хүсэлт ирүүлсэн 42 иргэн аж ахуй нэгжийн хүсэлтийг харгалзан нэмэлтээр хөрөнгийн үнэлгээг хийлгэн тогтоосон.) иргэдэд нөхөн олговрыг олгохоор тайлант онд төлөвлөн ажилласан. Үүнээс 1 иргэн гэрээ байгуулаагүй үлдсэн иргэд хөрөнгийн үнэлгээг хүлээн зөвшөөрч гэрээ байгуулан 692,448,700 төгрөгийн нөхөн олговроо авсан нь тайлант онд төлөвлөсөн нөхөн олговор олгох ажлын гүйцэтгэл хангагдсан болно.	100%

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/501 дүгээр тушаалаар “Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх асуудлын хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн өөрийн тусгай зөвшөөрлийн талбай болон уурхайн нөлөөллийн бүсийн айл өрхүүдэд нөхөн олговор олгох ажлыг зохион байгуулах” ажлын хэсэг байгуулагдсан.

2024 оны байдлаар Цагаан-Овоо багийн 267 иргэн, аж ахуй нэгж хөрөнгийн үнэлгээнд хамрагдаад байна. Үүнд 2023 онд “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК-р хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн хөрөнгийн үнэлгээнээс хоцорсон гэх хүсэлт ирүүлсэн 42 иргэн аж ахуй нэгж багтаж байгаа болно. Тайлант онд 40 иргэнд нөхөн олговор олгохоор төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд үнэлгээг хүлээн зөвшөөрсөн 41 иргэнд нөхөн олговор олгох гэрээний дагуу 692.4 сая төгрөгийн олговор олгогдож төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллалаа.

- Нийт нөхөн олговор олгох – 267 иргэн
- Гэрээ байгуулсан – 251 иргэн
- Гэрээ байгуулаагүй – 16 иргэн байна.

2024 оны 11 сарын 20-ны өдрийн байдлаар Цагаан-Овоо багийн иргэдэд нүүлгэн шилжүүлэлтийн зориулалтаар нийт 7 тэр бум 341 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
9.1	Цогтцэций суманд Монголын шагайн харвааны холбооны Салбар зөвлөлийг байгуулах	-	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн салбарын захирлын 2024 оны 08 дугаар сарын 12-ний өдрийн Дугаар 03/233 тоот “Монголын Шагайн Харвааны” холбоонд хүргүүлсэн гишүүнээр элсэх тухай утга бүхий албан тоотын дагуу, холбооны гишүүнээр элсэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.	100%
9.2	Газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл мэдээлэх	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээгээр	Одоогийн байдлаар түүх, соёлын өвийн холбогдолтой элдэв зүйлс тохиолдоогүй байна.	100%

9.1 Цогтцэций суманд Монголын шагайн харвааны холбооны Салбар зөвлөлийг байгуулах

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн салбарын захирлын 2024 оны 08 дугаар сарын 12-ний өдрийн Дугаар 03/233 тоот “Монголын Шагайн Харвааны” холбоонд хүргүүлсэн гишүүнээр элсэх тухай утга бүхий албан тоотын дагуу, холбооны гишүүнээр элсэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.

“Монголын Шагайн харвааны холбоо” /МШХХ/ нь 1987 онд байгуулагдсан бөгөөд 1998 онд Хууль зүйн яаманд албан ёсоор бүртгүүлж гэрчилгээгээ авсан ашгийн бус ТББ юм.

Жил бүр уламжлал болгон явуулдаг спорт наадам “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “ЭТТ Бага олимп 2024” арга хэмжээ энэ жил 10 дугаар сарын 12-ны өдөр “Буянт Ухаа” спорт цогцолборт болсон. Тус арга хэмжээний нээлтийн үеэр “Монголын Шагайн Харвааны” холбооны салбар зөвлөлийг “Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Шагайн харвааны холбооны үйл ажиллагааг тус байгууллагад төлөөлөн явуулах эрхийг баталгаажуулсан гэрчилгээг “Эрдэнэсийн Аргай” салбар зөвлөлд гардуулан өгсөн юм.

Тус байгууллагын Ерөнхийлөгчийн 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн Дугаар 0355 Гэрчилгээ бүхий Шагайн Холбооны үйл ажиллагааг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д төлөөлөн явуулах эрхийг ийнхүү баталгаажуулав.




Зураг № 72. Монголын шагайн харвааны салбар зөвлөлийн гэрчилгээг гардан авч буй байдал

9.2 Газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл мэдээлэх

Газрын хэвлий ашиглах явцад түүх, соёлын өвтэй холбоотой зүйлс тохиолдвол “Эрдэнэс Тавантолгой” ХК-ын Салбарын Байгаль орчин, усны бодлогын хэлтсийн мэргэжилтэнүүдэд мэдээлэх талаар бүх төрлийн сургалтаар ажилтнуудад мэдээлдэг ба одоогийн байдлаар түүх, соёлын өвийн холбогдолтой зүйлс тохиолдол гараагүй байна.


10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

10.1 Нүүрс устөрөгч, химийн бодис хяналтгүйгээр асгарах

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
10.1.1	ХАЛМ-ийг химийн бодис ашигладаг ажлын байруудад байрлуулах, сургалт зохион байгуулах.	>500 хүнд	“Химийн хортой, аюултай бодисын хэрэглээ”, “Хаягдал зай хураагуур” гэсэн сэдвээр 2 удаагийн сургалт хийж, давхардсан тоогоор нийт 852 ажилтан сургалтад хамруулсан. Мөн Химийн хортой, аюултай нүүрс-устөрөгчийн бодис материал ашиглагдах буюу ХАЛМ-г бүрэн буюу 100% бүрдүүлж зохих газруудад байршуулсан.	100%
10.1.2	Асгаралтыг бүртгэлжүүлж тусгай бэлдсэн талбайд бохирдсон хөрсийг байршуулах	Тодорхойлох боломжгүй	2022 оны 01-р сараас эхлэн дундын шэйр файл үүсгэж асгаралтын тохиолдол бүрийг бүртгэлжүүлэх ажил хийгдэж байна. Цанхийн баруун, зүүн уурхайд бохирдсон хөрс саармагжуулах талбайтай бөгөөд хөрсний бохирдол үүсэхээс сэргийлсэн геомембран хийцлэлтэй. Тус талбайд байршуулсан бохирдсон хөрсийг саармагжуулах арга хэмжээг авч, хөрсний дээжийг лабораторид шинжлүүлсэн.	100%

10.1.1 ХАЛМ-ийг химийн бодис ашигладаг ажлын байруудад байрлуулах, сургалт зохион байгуулах

Химийн хортой, аюултай нүүрсустөрөгчийн бодис материалыг хадгалах, тээвэрлэх, ашиглах хууль болон дотоод журмыг боловсруулан мөрдөж ажилчдад химийн хортой, аюултай бодис материалын мэдээллийг сургалт зааварчилгаагаар явуулж байна.







Зураг № 73. ХАЛМ-ыг шаардлагатай байршлуудад байршуулсан байдал

Химийн хортой, аюултай нүүрс-устөрөгчийн бодис материал ашиглагдах талбайд химийн бодисийн хор аюулын лавлах мэдээлэл буюу ХАЛМ-г бүрэн гүйцэт бүрдүүлж өөрийн компанийн ХАЛМ-ийн загварт орчуулан /ХАЛМ/ шаардлагатай газруудад байрлуулсан.

Тайлант онд “Химийн хортой, аюултай бодисын хэрэглээ”, “Хаягдал зай хураагуур” гэсэн сэдвээр 2 удаагийн сургалт хийж, давхардсан тоогоор нийт 1057 ажилтан сургалтад хамрагдсан байна.



Зураг № 74. Сургалт орж буй үйл явцын зураг

10.1.2 Асгаралтыг бүртгэлжүүлж тусгай бэлдсэн талбайд бохирдсон хөрсийг байршуулах

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь уурхайн олборлолтын үйл ажиллагааны дийлэнхийг гэрээт байгууллагуудаар хийж гүйцэтгүүлдэг бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаанд тогтмол хяналт шалгалт хийж ажилладаг. 2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 69 асгаралтын тохиолдол бүртгэгдсэн байна. Гэрээт компани тус бүр дээр гарсан асгаралтын бүртгэлийг

сайжруулах зорилгоор 2022 оны 01-р сараас эхлэн дундын шэйр файл үүсгэж асгаралтын тохиолдол бүрийг бүртгэлжүүлэх ажил хийгдэж байна. Ингэснээр гэрээт компаниудын байгаль орчны асуудал хариуцсан ажилтнууд онлайнаар бүртгэлийг нэгэн зэрэг хөтлөх боломжийг бүрдүүлсэн.

Салбарын захирлын баталсан “Асгаралтын журам”-ын дагуу асгаралт болсон даруйд тухайн асгаралт анх илрүүлсэн ажилтан өөрийн удирдах ажилтан эсвэл байгаль орчны мэргэжилнүүдэд мэдээлж байна. Үүний дагуу гэрээт компаниудын байгаль орчны мэргэжилтэн талбай дээр үзлэг хийж, урьдчилсан мэдэгдлийг холбогдох хэлтэс, нэгжүүдэд хүргүүлэн ажилладаг. Асгаралтын хэмжээ, цар хүрээг тогтоож, хариу арга хэмжээг авч тайлан боловсруулж байна. Мөн гэрээт компаниудад бохирдсон хөрс саармагжуулах талбай байгуулах шаардлагыг тавьж геомембранаар дэвсэлт хийсэн талбайд тос маслоор бохирдсон хөрсийг хуримтлуулж байна.

Нийт асгаралтын тохиолдлыг судалж үзэхэд техник ажиллаж байх үед гидрийн шланг задарсан, дамжуулах хоолой задарсан, жийргэвч сэтэрсэн, радиатор цоорсон гэх мэт шалтгааны улмаас асгаралт үүссэн байна.





Зураг № 75. Асгаралтаар бохирдсон хөрсийг цуглуулан авч буй байдал




Зураг № 76. Бохирдсон хөрсийг цуглуулан ачиж бохирдсон хөрсний талбайд буулгаж буй байдал

Асгаралтыг хязгаарлах, удирдах зорилгоор “ЭТТ” ХК болон гэрээт компаниуд асгаралтын иж бүрдэл болон шингээгч материалуудын захиалга, худалдан авалтыг хийж шаардлагатай газруудад буюу засварын шоп, шатахуун түгээх станцын талбайд бэлэн байдалд байлгах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.



Зураг № 77. Эрсдэл бүхий газруудад асгарлтын иж бүрдлийг байрлуулсан байдал

Цанхийн зүүн уурхай: ЦЗУ-д асгаралтын нийт 46 удаагийн тохиолдлоор 7746.0 литр шингэн асгарч 84.83 м3 бохирдсон хөрсийг саармагжуулах талбайд байрлуулсан. Цанхийн зүүн уурхайд байрлах бохирдсон хөрс саармагжуулах талбайд 800 орчим м3 нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон хөрс цуглуулаад байгаа ба тэдгээрийг хөдөлгөж, эргүүлж, агааржуулах зэрэг байдлаар саармагжуулах арга ажиллагааг явуулж байна. Одоогийн байдлаар 6, 7, 8, 9, 10 сард дээж авч нефтийн бохирдлын шинжилгээ хийлгэсэн байгаа ба 10 дугаар сард дээж шинжлүүлэн үр дүнгийн тайланг боловсруулна.



Зураг № 78. Хөрс сийрүүлэн хөдөлгөж агааржуулах, чийгшүүлэх ажлын явцын зураг

Саармагжуулах ажлын үр дүнг тодорхойлох зорилгоор сар бүр дээж аван хөрсний нефтийн бохирдол тодорхойлох шинжилгээнд явуулж байгаа болно.



"НОГООН ТИТЭМ" ХХК
Хан Уул дүүрэг, 3-р хороо,
Сан-Конструкшн ХХК байр 222 тоот
Утас: 70005432

Лабораторийн сорилтын тайлан

Акт/ын дугаар	240830
Сорилтын төрөл	Хөрс
Захиалагчийн мэдээлэл:	Нормаунт ХХК
Түүвэр дээжийн мэдээлэл:	"Нормаунт" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу Өмнөговь аймаг, Цогтцэций сумэнд байрлах Эрдэнэс таван толгой Цэвэрлэх уурхай орчим хөрсний сорьц цуглуулсан.
Түүвэр дээжийн тоо:	3
Сорьц цуглуулсан арга:	MNS 3298:1990
Сорьц цуглуулсан хүн:	Б. Энхцэцэг, Ч.Дэлгэрмаа

Түүвэр дээж цуглуулсан огноо	Лабораторид хүлээн авсан огноо	Сорилт эхэлсэн огноо	Сорилт дууссан огноо	Хэвлэсэн огноо
8/24/2024	8/25/2024	8/26/2024	9/9/2024	9/12/2024

Сорилтын дүн

Түүвэр дээжийн дугаар	Тодорхойлох үзүүлэлт	Сорилтын арга/н стандарт	Сорилтын дүн, хэмжих нэгж	Байршил
12218	Нефтийн бүтээгдэхүүний бохирдол (*)	ISO 16703:2004	109.69 мг/кг	Бохирдсон хөрс саармагжуулах талбай /6-р сар/
12219	Нефтийн бүтээгдэхүүний бохирдол (*)	ISO 16703:2004	98.57 мг/кг	Бохирдсон хөрс саармагжуулах талбай /7-р сар/
12220	Нефтийн бүтээгдэхүүний бохирдол (*)	ISO 16703:2004	94.08 мг/кг	Бохирдсон хөрс саармагжуулах талбай /8-р сар/

Лавлагаа мэдээлэл: Зөвшөөрөгдөх дээд хэмжээ

MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Газрын төсөл бүтээгдэхүүн	Хүнцэл агууламж	2 г/кг
		Хортой агууламж	8 г/кг

ГҮЙЦЭТГЭСЭН: ХИМИЧ: /Ч.ДЭЛГЭРМАА/
ХЯНАСАН: ЧАНАРЫН МЕНЕЖЕР: /Б.ЭНХЦЭЦЭГ/
БАТАЛСАН: ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР: /Б.АЛТАНГАДАС/

Энэхүү сорилтын дүн нь сорилт хийсэн түхайн сорьцонд хамаарах бөгөөд зөвхөн эх хувь хүчинтэй. Сорьц

1/2

Зураг № 79. Бохирдсон хөрс саармагжуулах талбайн шинжилгээний үр дүн

Цанхийн баруун уурхай: ЦБУ-д асгаралтын нийт 11 удаагийн тохиолдлоор 664.0 литр шингэн асгарч 112.94 м3 бохирдсон хөрсийг саармагжуулах талбайд байрлуулсан. Бортээг дэх бохирдолтой хөрс саармагжуулах талбайд 20 тн бууцыг Лоадер 812, Хово 54 техникээр тээвэрлэн буулгаж саармагжуулах ажлыг зохион байгуулсан.

Саруул	Хүнд метал, мг/кг					
	Ni /Никель	Cd /Кадми	Pb /Хар тугалга	Cu /Зэс	Zn /Цайр	Cr /Хром
3-р сар	24.2	ND	35.8	20.5	70.5	47.9
4-р сар /Саармагжуулсан/	28.23	ND	16.08	43.81	148.81	ND
4-р сар /Саармагжуулаагүй/	27.6	ND	18.88	46.08	192.26	ND
7-р сар /Саармагжуулсан/	14.44	ND	36.31	31.37	86.38	ND
8-р сар	21.01	ND	32.32	33.44	67.41	ND
9-р сар	13.49	ND	0.31	2.49	63.41	ND
Хүлцэх агууламж MNS 5850:	150	3	100	100	300	150
Хортой агууламж MNS 5850:2019	1000	10	500	500	600	400

Зураг № 80. Бохирдолтой хөрсний шинжилгээний дүн

10.2 Байгалийн аюул, гамшигт нөхцөл байдал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
10.2.1	Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Уурхайн хэмжээнд	Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 02-р сарын 09-ний өдөр, Уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024 оны 01-р сард тус тус холбогдох байгууллагуудаар батлуулсан.	100%

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
10.2.2	Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг нийт ажилтнуудад танилцуулах	Уурхайн хэмжээнд	Засгийн газрын 339-р тогтоолын дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Салбарын хэмжээнд дуут дохиогоор ажиллах дадлага сургууль зохион байгуулж 316 ажилтан хамрагдсан. Мөн гэрээт байгууллага тус бүр ажилчдаа хамруулан төслийн талбайд ажиллаж буй 800-с дээш ажилтанд дадлага сургуулилт зохион байгуулсан.	100%
10.2.3	Үерийн эрсдэл бүхий цэгүүдэд байгуулсан ус зайлуулах суваг шуудууг сэргээх	Уурхай, хотхоны хэмжээнд	Үерийн эрсдэл бүхий байршлуудад хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулан далан суваг шуудуу шинээр хийх, өмнө байсан шуудууг сэргээн засварлах ажлыг хийсэн.	100%

10.2.1 Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулах

“Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 8-р зүйлийн 8.1-д заасны дагуу уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 02-р сарын 09-ны өдөр Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, ахмад Б.Дэнзэнгээр хянуулан Өмнөговь аймгийн Онцгой байдлын газраар батлуулсан.

“Уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулан Улаанбаатар хотын Налайх дүүрэгт орших Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Уул уурхайн аврах 09-р ангийн даргын захирагч хурандаа Д.Гантулгаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



Зураг № 81. Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон аваар устгах төлөвлөгөөг батлуулсан байдал

10.2.2 Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг нийт ажилтнуудад танилцуулах

2024 онд батлагдсан гамшгаас хамгаалах төлөвлөгөө, уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөгөөр 2024 оны 7-р дугаар сард салбарын нийт 700 ажилтанд сургалт орсон. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөнд орсон сайн дурын бүлгэмийн


гишүүдийг үүрэг чиглэлээр хангаж дасгал сургуулилтыг А, Б, В ээлжийн сайн дурын бүлгэмийн 51 гишүүдийг хамруулан сургалт зааварчилгаа өгсөн.



Зураг № 82. Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөө, аваар устгах төлөвлөгөөг практик дадлага хийж танилцуулж буй байдал

10.2.3 Үерийн эрсдэл бүхий цэгүүдэд байгуулсан ус зайлуулах суваг шуудууг сэргээх

Үерийн эрсдэл бүхий байршлуудад хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулан далан суваг шуудуу шинээр хийх, өмнө байсан шуудууг сэргээн засварлах ажлыг хийсэн.



Зураг № 83. Үерийн уснаас хамгаалах шороон далангийн төлөвлөгөөний зураг


2024 он нь олон жилийн дунджаас ахиу хэмжээний бороотой жил байсан бөгөөд уурхайн хувьд үерийн эрсдэлгүй давсан.

10.3 Гал түймрийн аюул, эрсдэл

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
10.3.1	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм журам боловсруулж түүнийг дагаж мөрдөх.	Уурхайн хэмжээнд	“Галын аюулгүй байдлын журам”-ыг боловсруулан 2021 оны 11-р сарын 12-ны өдрийн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь Салбарын захирлын А/98 тоот тушаалаар батлуулан мөрдлөг болгон ажиллаж байна.	100%
10.3.2	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалын заасан самбар галын аюул болж болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байрлуулах, хяналт тавих.	Уурхайн хэмжээнд	Галын аюулгүй байдлын үзлэгийн хуваарийн дагуу гал унтраагуур, дохиоллын үзлэг 25 удаа хийж даралт унасан буюу шинээр гал унтраагуур 2-9 кг-ийн 135 ширхгийг байрлуулж галын аюулгүй байдлыг ханган ажилласан.	100%
10.3.3	Шатахуун түгээх станцын талбайд ил гал гаргахыг хориглосон, анхааруулсан тэмдэг, санамж байрлуулах, үерээс хамгаалсан суваг, шуудууг татах, сэргээх	ШТС-ын талбай	Уурхайд байрлах ШТС-уудад ил гал гаргахыг хориглосон, анхааруулсан тэмдэг, санамж байрлуулах, үерээс хамгаалсан суваг, шуудууг татах, сэргээх ажил бүрэн хийгдсэн.	100%

10.3.1 Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм журам боловсруулж түүнийг дагаж мөрдөх

“Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Гамшгаас хамгаалах тухай хууль”, Гал түймрийн болон гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм, Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийг үндэслэл болгон “Галын аюулгүй байдлын журам”-ыг боловсруулан 2021 оны 11-р сарын 12-ны өдрийн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ний Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь Салбарын захирлын А/98 тоот тушаалаар батлуулсан.



Зураг № 84. "Галын аюулгүй байдлын журам"-ыг баталсан Салбарын захирлын тушаал болон журам

Улс орон даяар Гамшгийн аюулын зарлан мэдээлэх дуут дохио шалгах Засгийн газрын 339-р тогтоолын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Салбарын хэмжээнд дуут дохиогоор ажиллах дадлага сургуулилт зохион байгуулж 316 ажилтан хамрагдсан.

Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд бэлэн байдлын цүнх болон хорт утаанаас хамгаалах багийг танилцуулж үзлэг зохион байгуулсан. Гэрээт байгууллага тус бүр ажилчдаа хамруулан төслийн талбайд ажиллаж буй 800-с дээш ажилтанд дадлага сургуулилт зохион байгуулсан.

10.3.2 Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалын заасан самбар галын аюул болж болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байрлуулах, хяналт тавих

Галын аюулгүй байдлын үзлэгийн хуваарийн дагуу гал унтраагуур, дохиоллын үзлэг 25 удаа хийж даралт унасан буюу шинээр гал унтраагуур 2-9 кг-ийн 135 ширхгийг байрлуулж галын аюулгүй байдлыг ханган ажилласан.

Үндсэн болон гэрээт компаниудын онцгой байдлын хэсгүүдийн бэлтгэл, бэлэн байдлыг шалгах, гал түймэр, гамшиг ослын үед ажиллах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх богино хугацаанд хүний амь нас, байгууллагын өмч хөрөнгийг авран хамгаалах хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор салбарын захирлын баталсан удирдамж, 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гал унтраах, аврах ажиллагааны дадлага сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 03 ний өдрийн 13 цаг 30 минутаас 14 цаг 00 минутын хооронд уурхайн шинэ паркийн талбайд экскаватор 9200 №002 дээр зохион байгуулсан. Сургалтад Онцгой байдлын хэсгийн 14 ажилтан, яаралтай тусламжийн нэгжийн 6 ажилтан, 9 техник хэрэгсэлтэйгээр оролцсон.



Зураг № 85. Авран хамгаалах дадлага сургалт хийж буй байдал

Салбарын нийт ажилтны гал унтраах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, практик туршлага олгож, болзошгүй галын аюулын үед цаг хугацаа алдалгүй түргэн шуурхай ажиллах, гал унтраагуурыг зөв ашиглах арга барилд суралцуулах зорилгоор 2024 онд 4 ээлж тус бүрээр зохион байгуулсан бөгөөд нийт 648 ажилтан хамрагдсан.

10.3.3 Шатахуун түгээх станцын талбайд ил гал гаргахыг хориглосон, анхааруулсан тэмдэг, санамж байрлуулах, үерээс хамгаалсан суваг шуудуу татах, сэргээх

Уурхайд байрлах зөөврийн ШТС-ыг хамгаалсан үерийн суваг шуудууг сэргээн засварлах, ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэх, ажлын байрны үзлэг хийж зөрчил дутагдлыг арилгах, тэмдэг тэмдэглэгээг сэргээх ажлуудыг тогтмол хийж байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК: Зөөврийн шатахуун түгээх станц 2 ширхгийг ашигладаг бөгөөд Шатах тослох материал нийлүүлэх гэрээт байгууллагаар “Шунхлай” ХХК ажилладаг.



Зураг № 86. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн ШТС-д хийгдсэн анхааруулах тэмдэг

“ТН Түншлэл”: Зөөврийн 2 ширхэг ШТС ашигладаг бөгөөд Уурхайн ШТС-1, ШТС-2 болон хог хаягдал ангилан ялгах байгууламжийн гадна талаар хамгаалалтын далан байгуулсан.



Зураг № 87. "ТН Түншлэл"-ийн ШТС-үүдэд ил гал гаргахыг хориглосон болон анхааруулсан тэмдэг байрлуулсан байдал

“Үндэсний Уурхайчин Түншлэл” ХХК: Зөөврийн 2 ширхэг ШТС-ийг ашигладаг бөгөөд шатах тослох материал нийлүүлэгчээр “Шунхлай” ХХК ажилладаг.



Зураг № 88. "Хишиг Арвин Индустриал" ХХК-ны ШТС-үүдэд анхааруулах тэмдэг байрлуулсан байдал

“Үндэсний Оператор Түншлэл”-ийн бүрэлдэхүүний 5 компаниуд зөөврийн 2 ширхэг ШТС-ийг ашигладаг бөгөөд компани бүр шатахуун нийлүүлдэг өөр өөрийн байгууллагуудтай гэрээ байгуулан ажилладаг.



Зураг № 89. "ТТОТ"-ийн ШТС-үүдэд анхааруулах самбар байршуулсан байдал


10.4 Байгаль орчинд учруулж болзошгүй эрсдэл

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
10.4.1	Хөрсний нуралтаас урьдчилан сэргийлэхийн тулд ил уурхайн хөрс хуулалт, шатлал, ухалт, тэсэлгээ зэрэг ажлуудыг гүйцэтгэхдээ холбогдох горимыг чанад мөрдөж ажиллах	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд	Салбарын захирлын баталсан журам, зааврууд ыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	100%

10.4.1 Хөрсний нуралтаас урьдчилан сэргийлэхийн тулд ил уурхайн хөрс хуулалт, шатлал, ухалт, тэсэлгээ зэрэг ажлуудыг гүйцэтгэхдээ холбогдох горимыг чанад мөрдөж ажиллах

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ыг Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь Салбарын захирлын 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн А/106 дугаартай “Уурхайн геотехникийн ажил гүйцэтгэх журам” батлах тухай тушаалаар батлагдсан журмыг уурхайн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.

Цанхийн уурхайн хэмжээнд геотехникийн эрсдэл бүхий 2 байршил байдаг ба тэдгээрийг уурхайн Геотехникийн инженерүүд 24/7 хоногоор байнгын хяналтандаа байлгаж ажилладаг.



Зураг № 90. Салбарын захирлын батлсан тушаал, журам

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

11.1 Аюултай хог хаягдал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
11.1.1	Хаягдал тосны байгууламжийг стандартын дагуу байгуулах	3	ЦЗУ, ЦБУ-н гэрээт байгууллагууд нь хаягдал тосны байгууламжийн суурийг бетонон, хамгаалах хөмсөгтэй байгуулсан ба засвар үйлчилгээг тухай бүр хийдэг. “ЭТТ” ХК-ийн хувьд аюултай хог хаягдал түр хадгалах цэгийн бетонон суурийн ажлыг гүйцэтгүүлэхээр тендер зарлаад байна.	100%
11.1.2	Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй ААН-д шилжүүлэх.	>5 удаа	Аюултай болон овор ихтэй хог хаягдлыг шилжүүлэх, тээвэрлүүлэх гэрээг Цэцүүх трейд, Түмэн эгшиг ХХК-уудтай байгуулсан ба гэрээний дагуу дагалдах хуудсаар аюултай хог хаягдлыг нийлүүлдэг.	100%
11.1.3	Гэрээт байгууллагуудын аюултай хог хаягдлын талбайн стандартыг хангуулахад хяналт тавих	3 цэг	Цанхийн зүүн уурхайд 1 ш, баруун уурхайд 2 ш аюултай хог хаягдал түр хадгалах байгууламжтай бөгөөд ажлын байрны үзлэгээр зөрчлийг илрүүлж, хариу арга хэмжээ авч ажилладаг.	100%

11.1.1 Хог хаягдлын нэгдсэн төвийн зураг төслийн ТЭЗҮ гаргуулахад шаардлагатай бичиг баримтын бүрдэл хангах

Цанхийн зүүн, баруун уурхайн хаягдал тосны байгууламжийн хэвийн ажиллагааг хангаж шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээг тогтмол хийж байна.



Зураг № 91. Хаягдал тосны талбайн бетонон суурийг сайжруулсан байдал

Мөн техникийн үйлчилгээнээс гарах ашигласан тос, тосолгооны бүтээгдэхүүнийг цутгалт хийсэн тусгай тэмдэг тэмдэглэгээ бүхий талбайд нөөцийн саванд хадгалж байна.



Зураг № 92. Хаягдал тосыг хадгалж буй байдал

Цанхийн баруун уурхайн гэрээт компани “КА Майнинг” ХХК нь уурхайн өдөр тутмын үйл ажиллагаанаас гарсан хаягдал тосыг 2 ш ёмкость, илүүдэл тос тосох сав бүхий байгууламжид хадгалж байна. Тус байгууламжийн нөөцийн сав тус бүр 20 тн багтаамжтай ба хөрсөнд үл шингэх байдлаар шалыг бүрэн бетондохоос гадна шалны гадаргаас дээш 30 см өндөр бетонон цутгалттай байгаа нь хөрсний бохирдол үүсэхээс сэргийлдэг.



Зураг № 93. Цанхийн баруун уурхайн Хаягдал тосны байгууламж


Аюултай хаягдлыг өөр хоорондоо урвалд орохгүйгээр хадгалах тусгаарлалт, агааржуулалттай, нарны шууд тусгалаас хамгаалах, хөрснөөс бүрэн тусгаарласан ангилан ялгах байгууламжид түр хадгалж байна. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх хэмжээнд хүрсэн тохиолдолд гэрээний дагуу “Цэцүүх Трейд” ХХК-д нийлүүлэн ажиллаж байна. Хаягдал

дугуйны хувьд хаягдал дугуйг цуглуулан, тээрэмдэж түүхий эд бэлтгэдэг тусгай зөвшөөрөл бүхий “Эко Окто хүрд” ХХК-д нийлүүлж байна.



Зураг № 94. Засварын талбайн бохирдсон хөрс түүр хадгалах цэг

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь уурхайн засварын шопын барилга угсралтын ажлыг шинээр байгуулж байна. Мөн аюултай хог хаягдал түр хадгалах цэгийн бетонон суурийн ажлыг гүйцэтгүүлэх, бохирдсон хөрс саармагжуулах талбай байгуулахаар 2024 оны төсөвт 185 сая төгрөгийг тусгаж батлуулсан ба үнэлгээний хороо байгуулагдаж, тендер шалгаруулах шатанд явж байна.



Зураг № 95. Аюултай хог хаягдлын цэгийн бетонон суурь цутгалт болон бохирдсон хөрс саармагжуулах талбай байгуулах ажлын даалгавар

11.1.2 Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй ААН-д шилжүүлэх

“Эрдэнэс Тавантолгой” ХК: Хог хаягдлын тухай хуулийн дагуу Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 314 дугаартай албан бичгээр аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгэгдэж Y-000753 дугаар авсан.

Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалыг үндэслэн Цанхийн уурхайн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

“Цэцүйх трейд” ХХК-тай 2023 оны 08-р сарын 03-ны өдөр “Аюултай болон овор ихтэй хог хаягдлыг нийлүүлэх, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулан аюултай хог хаягдлыг нийлүүлж байна.



Зураг № 96. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх гэрээ

2024 оны төсөвт аюултай болон овор ихтэй хог хаягдлыг шилжүүлэх, тээвэрлүүлэхээр 80.2 сая төгрөг тусгаж, тендер зарласан ба “Түмэн эгшиг” ХХК шалгарч гэрээ байгуулах шатандаа явж байна.




Зураг № 97. Аюултай болон овор ихтэй хог хаягдал шилжүүлэх, тээвэрлэх ажлын даалгавар

2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр 8870 кг аюултай хог хаягдлыг дагалдах бичгээр баталгаажуулан, акт үйлдэж нийлүүлсэн.

Хүснэгт № 26. Аюултай хог хаягдал нийлүүлсэн хэмжээ

№	Огноо	Аюултай хог хаягдлын төрөл	Хэмжээ	Нийлүүлсэн АНН
1	2024.04.18	Хуванцар канистр	1000 кг	“Цэцүүх трейд” ХХК
		Төмөр торх	1360 кг	
		Тостой картон цаас	1000 кг	
		Хамгаалалтын хувцас	1000 кг	
		Тосны шүүр	1000 кг	
		Тос, тосолгооны материалаар бохирдсон агаар шүүгч	1610 кг	
		Бохирдсон арчих материал	1900 кг	
Хаягдал тос нийлүүлсэн бүртгэл				

2	2024.03.10	Ашигласан тос	30 тн	“Дэвжих боломж өргөө” ХХК
3	2024.07.21	Ашигласан тос	30 тн	
4	2024.10.27	Ашигласан тос	33.7 тн	“Об ойл” ХХК



АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

№0000728



2023 ОНЫ АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛСЭН ГЭРЭЭ ДУГНЭСЭН АКТ

Зураг № 98. Аюултай хог хаягдал нийлүүлсэн дагалдах хуудас, акт

Мөн уурхайн хэмжээнд “Яаралтай тусламжийн нэгж”-ээс гарч байгаа эмнэлгийн гаралтай хог хаягдлыг Цогтцэций сумын сум дундын эмнэлэгтэй “Эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах, аюулгүй болгох тухай” гэрээ байгуулан ажилладаг бөгөөд 21 кг хог хаягдал нийлүүлсэн.

“КА Майнинг” ХХК нь Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 230 дугаартай албан бичгээр “ХАИ” ХХК нь аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгэгдэж Y-001153 дугаар авсан.

Гэрээний дагуу 11 ш IBC танк, 4500 кг тосны шүүрийг “Цэцүүх Трейд” ХХК-д, 948 ш хаягдал дугуйг “Эко Окто хүрд” ХХК-д, 146.2 тн хаягдал тосыг “Об Ойл Индастриал” ХХК-д буюу тусгай зөвшөөрөл бүхий ААН-д нийлүүлсэн.



ӨМНӨГОВЬ АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ХИШИГ АРВИН ИНДУСТРИАЛ ХХК-Д

Танай компанийг Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9.а-д заасны дагуу аюултай хог хаягдлын үүсгэгчээр бүртгэж, бүртгэлийн Ү-001153 дугаар олгов.

Хог хаягдлын тухай хуулийн 22, 23 дугаар зүйлийг мөрдөж ажиллахыг анхааруулж байна.

ДАРГА Б.ПҮРЭВТУЛГА



БАТЛАВ
"ЦЭЦҮҮХ ТРЕЙД" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
/Н.БИЛГҮҮН/

БАТЛАВ
"КЭЙ ЭЙ РЕНТАЛ СЕРВИС" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
/Н. ЭРДЭНЭ-ОЧИР/

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 03 сарын 22-ны өдөр № Ш-23/040 Улаанбаатар хот

Нэг талаас **Цэцүүх трейд ХХК** /цаашид "Хүлээн авагч" гэх/ төлөөлж Үйлдвэрийн дарга албан тушаалтай Б.Дарамбазар, Нөгөө талаас "Кэй Эй Рентал Сервис" ХХК-ийг /цаашид "Үүсгэгч" гэх/ төлөөлж Эрдэлийн үлирлагын газрын ерөнхий менежер албан тушаалтай Ядамсүрэн овогтой Нууц бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Зөвлөлийн газрын ***2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал*** болон Байгаль орчны аюулгүй байдлатай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зүйлээ

1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнтэс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.

1.2. Энэ гэрээгээр зөвхөн зохицуулагдаагүй бусад харилцаанг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 2-т тусгах ба талууд гэрээний хүчинтэй хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүрээр дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Аюултай хог хаягдалд тавигдах шаардлага

2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэглэгээтэй байна.

2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар хэмийн болонг хадгалж байсан тухай нэр шошготой байна.

2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүрээр үүсэхээ болон хүрэлцэхгүйдсэн хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.

2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ ***БОАЖСайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг*** бүрдүүлж огно.

2.5. Аюултай хог хаягдлын *сонгуулах сонгуулах онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис (тухайбайх шинжээ нарын гэх мэт) -г тохойн болсон шинж чанарт тохирсон үүсмэлаар цэнгэрсэн байна.* Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

Хүлээж авсан: Хүлээж авсан:

Хуудас 2/10

Зураг № 99. Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ, Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар


ЦБУ-н “Кей эй майнинг” ХХК нь аюултай хог хаягдлыг тусгай талбайд ангилан ялгаж хадгалан 2024 онд дараах төрлийн аюултай хог хаягдлыг гэрээний дагуу нийлүүлсэн байна.

Хүснэгт № 27. "КА Майнинг" ХХК-ны аюултай хог хаягдал нийлүүлсэн хэмжээ

№	Огноо	Аюултай хог хаягдлын төрөл	Хэмжээ	Нийлүүлсэн АНН
1	2024.01-03 сар	Агаар шүүгч	163 ш	“Цэцүүх трейд” ХХК
		Тосны шүүр	462 ш	
		Поошиг	340 ш	
		Аккумлятор	-	
		Дугуй	8 ш	
		Арчих материал	2024 кг	
2	2024.04-06 сар	Агаар шүүгч	205 ш	
		Тосны шүүр	262 ш	
		Поошиг	209 ш	
		Аккумлятор	8 ш	
		Дугуй	106 ш	
		Арчих материал	1071 кг	
3	2024.07-09 сар	Агаар шүүгч	206 ш	
		Тосны шүүр	199 ш	
		Поошиг	217 ш	
		Аккумлятор	4 ш	
		Дугуй	51 ш	
		Арчих материал	1440 кг	
Хаягдал тос нийлүүлсэн бүртгэл				
4	2024.01-03 сар	Ашигласан тос	72981 л	
5	2024.04-06 сар	Ашигласан тос	46956 л	
6	2024.07-09 сар	Ашигласан тос	43891 л	


2024.02.13-ны өдөр Өмнөговь аймгийн Сум дундын эмнэлэгтэй “Эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах, аюулгүй болгох” тухай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Уг гэрээний дагуу эмнэлгийн хог хаягдлыг шингэн нэвчдэггүй бат бөх шар өнгийн, “Био аюултай” тэмдэглэгээ бүхий уутанд байрлуулан,

халдвартай болон хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг аюулгүйн хайрцагны ¾ түвшнээс хэтрүүлэлгүй байдлаар нийлүүлдэг. 10-р сарын байдлаар нийт 18.16 кг хог хаягдал нийлүүлсэн байна.



Зураг № 100. Эмнэлгийн хог хаягдлын гэрээ

“Овоот толгой ресурс” ХХК нь “Түмэн Эгшиг” ХХК-тай 2024 оны 03-р сарын 15-ны өдөр “Аюултай болон овор ихтэй хог хаягдлыг нийлүүлэх, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулан аюултай хог хаягдлыг нийлүүлж байна. 2024 оны 05 дугаар сарын 26-ны өдөр 6360 кг аюултай хог хаягдлыг дагалдах бичгээр баталгаажуулан, акт үйлдэж нийлүүлсэн.



Зураг № 101. Аюултай хог хаягдлын гэрээ

Хүснэгт № 28. Аюултай хог хаягдал нийлүүлсэн хэмжээ

№	Огноо	Аюултай хог хаягдлын төрөл	Хэмжээ	Нийлүүлсэн АНН
1	2024.05.26	Хуванцар канистр	800 кг	“Түмэн Эгшиг” ХХК
		Төмөр торх	1210 кг	
		Тостой картон цаас	750 кг	
		Тосны шүүр	1000 кг	

		Тос, тосолгооны материалаар бохирдсон агаар шүүгч	1200 кг	
		Бохирдсон арчих материал	1400 кг	
Хаягдал тос нийлүүлсэн бүртгэл				
2	2024.04.15	Ашигласан тос	25 тн	“Түмэн Эгшиг ХХК ” ХХК
3	2024.07.20	Ашигласан тос	30 тн	
4	2024.09.13	Ашигласан тос	30 тн	

Цогтцэций сумын сум дундын эмнэлэгтэй “Эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах, аюулгүй болгох тухай” гэрээ байгуулан ажилладаг бөгөөд 25 кг хог хаягдал нийлүүлсэн.

“Үндэсний оператор түншлэл” нь Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 314 дугаартай албан бичгээр аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгэгдэж Y-000753 дугаар авсан. “Түмэн эгшиг” ХХК-тай 2024 оны 01-р сарын 10-ны өдөр “Аюултай болон овор ихтэй хог хаягдлыг нийлүүлэх, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулан аюултай хог хаягдлыг нийлүүлж байна. 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр 4150 кг аюултай хог хаягдлыг дагалдах бичгээр баталгаажуулан, акт үйлдэж нийлүүлсэн. Гэрээний дагуу аюултай хог хаягдлын 2024 оны 02 улирлын нийлүүлэлтийн ажлыг 2024 оны 07 сарын 18-ны өдөр зохион байгуулсан.

Хүснэгт № 29. Аюултай хог хаягдал нийлүүлсэн хэмжээ

№	Огноо	Аюултай хог хаягдлын төрөл	Хэмжээ	Нийлүүлсэн АНН
1	2024.01.18	Хуванцар канистр	2103 кг	“Цэцүүх трейд” ХХК
		Төмөр торх	3000 кг	
		Тостой картон цаас	- кг	
		Хамгаалалтын хувцас	500 кг	
		Тосны шүүр	6007 кг	
		Тос, тосолгооны материалаар бохирдсон агаар шүүгч	1159 кг	
		Бохирдсон арчих материал	- кг	
Хаягдал тос нийлүүлсэн бүртгэл				
2	2024.05.15	Ашигласан тос	10.5 тн	“Түмэн Эгшиг” ХХК
3	2024.08.17	Ашигласан тос	7 тн	“ОБ ойл” ХХК
4	2024.09.30	Ашигласан тос	15 тн	

Цогтцэций сумын сум дундын эмнэлэгтэй 2023 оны 10-р сарын 27 ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатай “Эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах, аюулгүй болгох тухай” гэрээ байгуулан ажилладаг бөгөөд 16.6 кг хог хаягдал нийлүүлсэн.


“Үндэсний манлайлал түншлэл” нь Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2019 оны 11-р сарын 19-ний өдрийн 314 дугаартай албан бичгээр аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгэгдэж “Максгүүр транс” ХХК нь Y-001974, “Хавцайт их Хайрхан” ХХК нь Y-001977 тус тусдаа дугаар авсан.

2024 оны 8 дүгээр сараас хойш 10 дүгээр сар хүртэлх хугацаанд хаягдал тосыг дагалдах бичгээр баталгаажуулан, акт үйлдэж нийлүүлсэн.

Хүснэгт № 30. Аюултай хог хаягдал нийлүүлсэн хэмжээ

№	Огноо	Аюултай хог хаягдлын төрөл	Хэмжээ /тн, литр/	Нийлүүлсэн АНН
1.	2024.08.19	Ашигласан тос	1 тн 600 л	“Ханбогд Вейст менежмент центр” ХХК
2.	2024.10.05	Ашигласан тос	5 тн	
3.	2024.10.17	Ашигласан тос	2 тн 300 л	
№	**Огноо**	**Аюултай хог хаягдлын төрөл**	**Хэмжээ /тн/**	**Нийлүүлсэн АНН**
1.	2024.09.11	Тосоор бохирдсон гялгар уут	1.5	“Ханбогд Вейст менежмент центр” ХХК
		Хамгаалалтын хувцас		

		Бохирдсон арчих материал		
2.	2024.09.23	Бохирдсон тосны шүүр	1	
		Бохирдсон арчих материал		
		Тосны сав, тостой картон цаас		
3.	2024.10.12	Тостой картон цаас	1	


ХОГ ХАЯГДЛЫН ЖУРАМ

ГЭРЭЭГЭЭР ХАЯГДАЛ ТОС НИЙЛҮҮЛСЭН БҮРТГЭЛ

Огноо: 2024.10.5 Бүртгэлийн дугаар: Y-001974-3

Гэрээгээр хаягдал тос авсан байгууллагын нэр: "Ханбогд Вейст менежмент центр ХХК

Утасны дугаар: 9910 1414 Тос авсан ажилтны нэр: Одгэрэл

Хаягдал тос нийлүүлэх ажилд байцаан ажилчид:

"Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн ажилтан:

"Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн ажилтан:

Гэрээт байгууллагын төлөөлөл: "Цэцүүх трейд" ХХК Ням Гантөгтох

Гэрээт байгууллагын төлөөлөл: "Ханбогд Вейст менежмент центр" ХХК Одгэрэл

Олгосон тосны хэмжээ: 5. тн 0. литр

Хаягдал тос нийлүүлэх явцад асгаралт гарсан эсэх: Тийм ☐ Үгүй ☒

Асгаралтын хэмжээ: 0 тн 0 литр

Асгаралтын үед авсан арга хэмжээ: асгарсан газрыг

Асгаралт гарсан байдал	Асгаралтыг хязгаарласан байдал
Асгарсан газрыг	-

Баталгаажуулалт:


Зөвшөөрсөн: ЗМХ-ийн дарга: Ц.Одгэрэл

Хүлээлгэн өгсөн: Байгаль орчны мэргэжилтэн: М.Гантөгтох Гарын үсэг:

Хүлээн авсан: Гэрээт компанийн ажилтан: "Ханбогд Вейст менежмент центр" Э.Одгэрэл Гарын үсэг:

ЭТТ-СА-Ж12-БО-Ж08-Х03

Хуудас 12/18


АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

Дагалдах бичгийн дугаар: 41/01

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл

Бүртгэлийн дугаар: Y

Мина гүүр

2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгөгч:

Олог нэр (дарсан үсгэр бичих) Монэнмэн Гарын үсэг (тамга) он сар өдөр 2024.08.10

3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:

1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: 53-6871УВ Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:

Тээвэрлэгч ак аюй нэгжийн нэр: "Ханбогд Вейст Менежмент Центр" ХХК

2/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:

Тээвэрлэгч ак аюй нэгжийн нэр:

4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:

№	Аюултай хог хаягдлын нэр	Аюултай шинжээ	Савлагаа нь	Савны дугаар	Савны тоо/ш	Хэмжээ	Нягт(кг/л)	Аюултай хог хаягдлын код					
1	Хаягдал техникийн тос					6200	2	1	3	0	2	0	3 *

5. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:

Аюулгүй хүрээлэн тохиолдлоо гүйцэдгүй, харилцаа өгөө. Аюулгүй хүрээлэн тохиолдлоо их хэмжээний усыг уулгана.

Нөдгүү өрөөн тохиолдлоо нүд улаан, нишгэн хөлө их хэмжээний усыг уулгана.

Хөдөлмөр эмгэнэлийн хэрэгслээ ашиглаж хэрэглэнэ.

6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч:

1/ Олог нэр (дарсан үсгэр бичих) Б. Отгонбат Гарын үсэг (тамга) он сар өдөр 2024.08.18

2/ Олог нэр (дарсан үсгэр бичих) Гарын үсэг (тамга) он сар өдөр

7. Ул хэлэлцэл:

8. Аюултай хог хаягдал хүлээн авагчийн мэдээлэл:

Ак аюй нэгжийн нэр: "Хай Бо Ойл" ХК Бүртгэлийн дугаар:

Аюултай хог хаягдал хүлээн авсан:

Олог нэр (дарсан үсгэр бичих) Гарын үсэг (тамга) он сар өдөр 2024.08.18

Зураг № 102. Хаягдал тос нийлүүлсэн бүртгэл, дагалдах бичиг

“Ти Эн Түншлэл” нь Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1, 2 дүгээр хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалыг үндэслэн “Ханбогд Вейст менежмент центр” ХХК, “Цэцүүх трейд” ХХК-тай Аюултай хог хаягдал шилжүүлэх болон Аюултай хог хаягдал тээвэрлэлтийн гэрээг байгуулан хаягдал сав, баглаа боодлыг нийлүүлж байна.

Тус байгууллагуудад гэрээнд заасны дагуу хаягдал аккумлятор, химийн хуванцар IBC танк буюу 1 тн-ы хуванцар цагаан сав, химийн бодисын хаягдал хуванцар сав, канистр, хувин болон засвар үйлчилгээнээс үүсдэг тосоор бохирдсон арчих материал, хувцас хэрэгслийг шилжүүлж ажиллаж байна. 2024 онд 558000 литр техникийн хаягдал тос, 71860 кг аюултай хог хаягдал, 400 ш хаягдал поошиг нийлүүлсэн байна.

Хүснэгт № 31. "Ти Эн Түншлэл"-ийн хаягдал тос нийлүүлсэн хэмжээ

№	Огноо	Тээвэрлүүлсэн хог хаягдлын нэр	Хэмжих нэгж	Тээвэрлүүлсэн хэмжээ	Тээврийн хэрэгслийн дугаар
1	2024.01.07	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
2	2024.02.08	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
3	2024.02.16	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
4	2024.02.24	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
5	2024.03.07	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР

6	2024.03.11	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
7	2024.03.22	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
8	2024.04.04	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
9	2024.04.30	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
10	2024.05.19	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
11	2024.06.13	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
12	2024.06.22	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
13	2024.07.05	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
14	2024.07.20	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
15	2024.08.01	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
16	2024.08.15	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
17	2024.09.04	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
18	2024.10.04	Техникийн хаягдал тос	литр	31000	79-19 УБР
Нийт				**558.000**	

Хүснэгт № 32. "Ти Эн Түншлэл"-ийн хаягдал поошиг нийлүүлсэн хэмжээ

№	Огноо	Тээвэрлүүлсэн хог хаягдлын нэр	Хэмжих нэгж	Тээвэрлүүлсэн хэмжээ	Тээврийн хэрэгслийн дугаар
1	2024.09.21	Хаягдал поошиг	ш	200	72-06 УНЭ
2	2024.10.17	Хаягдал поошиг	ш	200	72-06 УНЭ

Хүснэгт № 33. "Ти Эн Түншлэл"-ийн аюултай хог хаягдал нийлүүлсэн хэмжээ

№	Огноо	Тээвэрлүүлсэн хог хаягдлын нэр	Хэмжих нэгж	Тээвэрлүүлсэн хэмжээ	Тээврийн хэрэгслийн дугаар
1	2024.08.05	IBC танк	ширхэг	41	58-79У АЧ ДГС
		Хаягдал тосны шүүр	кг	2351	
		Арчих материал	кг	-	
		Нийт жин	**кг**	**25560**	
2	2024.08.06	IBC танк	ширхэг	44	03-48 БЧ ДГС
		Хаягдал тосны шүүр	кг	23320	
		Арчих материал	кг	-	
		Нийт жин	**кг**	**25520**	
3	2024.09.25	IBC танк	ширхэг	40	66-10 ДГС
		Хаягдал тосны шүүр	кг	15580	
		Шланг	кг	3200	
		Нийт жин	**кг**	**20780**	
Нийт				**71860**	

Мөн хог хаягдлыг дахин ашиглах ажлын хүрээнд тос тосолгооны материалын төмөр торхыг цэвэрлэж саармагжуулан хогийн сав болгох зэргээр ашиглаж байна.

Эмнэлгээс үүсдэг хэрэглэгдсэн тариур, тариурын зүү, дуслын систем, хэрэгсэл, бохирдсон боолт, биеийн хэсэг, оношилгооны дээж, цус, химийн бодис, эм, эмнэлгийн багаж, цацраг идэвхт материалыг багтаана. Эдгээр хог хаягдлыг Цогтцэций сумын сум дундын эмнэлэгт хог хаягдал устгах гэрээний дагуу нийлүүлж устгуулж ажиллав. 2024 онд нийт 7.6 кг эмнэлгийн аюултай хог хаягдал нийлүүлээд байна.

Сар	№	Он сар өдөр	Эзлэх	Ариутгалд өгсөн		Хог хаягдал		Тайлбар	Хүлээлгэн өгсөн Эмчийн нэр
				Багаж, хэрэгсэл	Ховон, бишт	Халдвартай хог хаягдал	Аюултай хог хаягдал		
1	2	2024.01.17	В	10 ширхэг багаж бүшаав авсан	+	1 4кг		Хотоос ирсэн хог шар уутанд хийж СДЭ т хүргэсэн.	М.Парамгэрэл
2	3	2024.02.14	Г	15 багаж 3 бөөр таваг					Ө.Парамбат
3	4	2024.03.29	Б	10 ширхэг багаж			1кг	Аюултай хог хаягдал хайрцагтай нь хүргэж өгсөн.	Г.Гансүвд
4	5	2024.04.29	Б				1кг	Аюултай хог хаягдал хайрцагтай нь хүргэж өгсөн.	Г.Гансүвд
5	6	5/22/2024	Б	10 ширхэг багаж, хэрэгсэл	+				Г.Гансүвд
5	7	5/22/2024	Б				1кг	Аюултай хог хаягдал хайрцагтай нь хүргэж өгсөн	Г.Гансүвд
5	8	5/24/2024	Б			1 6кг		Халдвартай хог хаягдал зориулалтын шар уутанд дахархлаж хийж хүргэсэн.	Г.Гансүвд
6	9	6/11/2024	А	12 ширхэг багаж, хэрэгсэл			0 6кг	Аюултай хог хаягдал хайрцагтай нь хүргэж өгсөн.	Г.Мөнхбат
7	10	7/20/2024	Б			5 6кг	1кг	Халдвартай хог хаягдал зориулалтын шар уутанд дахархлаж хийж хүргэсэн.	Г.Гансүвд
8	11	8/16/2024	Б			10 1кг	1кг	Халдвартай хог хаягдал зориулалтын шар уутанд дахархлаж хийж хүргэсэн.	Г.Гансүвд
9	12	9/16/2024	Б			10 кг	1кг	Халдвартай хог хаягдал зориулалтын шар уутанд дахархлаж хийж хүргэсэн.	Г.Гансүвд
10	13	10/4/2024	Б			3.5 кг	1кг	Халдвартай хог хаягдал зориулалтын шар уутанд дахархлаж хийж хүргэсэн.	Г.Гансүвд

Зураг № 103. Сумын ЭМТ-ийн ариутгалын тасагт хүлээлгэн өгсөн эмнэлгийн хог хаягдал



БАТЛАВ:
"ЦЭЦҮҮХ ТРЕЙД" ХХК
-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.БИЛГҮҮН

БАТЛАВ:
"ТИ ТИ ЖИЙ СИ ӨҮ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ВАН ЧАНГ ЧИН

АЮУЛТАЙ ХОГ, ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ГЭРЭЭ

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр № 10 -24/ш/ Улаанбаатар хот

ЭНЭХҮҮ АЮУЛТАЙ ХОГ, ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ТАВДУГААР НЭМЭЛТ ГЭРЭЭГ (цаашид "Нэмэлт гэрээ" гэх)-г

Нэг талаас Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, 5564964 тоот регистрийн дугаартай, Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Их Монгол Улсын гудамж, Монинс Баянхонг 6-р давхар хаягт байрлах, "Ти Ти Жи Би Си Өү" ХХК (цаашид **"Түшөрүүлэгч"** гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ван Чанг Чин;

Нөгөө талаас Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, 2066321 тоот регистрийн дугаартай, Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр хаягт байрлах "Цэцүүх Трейд" ХХК (цаашид **"Түшөрлэгч"** гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Нямжил оюутгэй Билгүүн, (түс бүрт нь **"Тал"**, хамтад нь **"Талууд"** гэх);


Талууд 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Ш-19/54 тоот "Аюултай хог, хаягдал шилжүүлэх гэрээ" (цаашид "Үндсэн гэрээ" гэх)-д нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор байгуулав.

1. ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ

1.1 Үндсэн гэрээний 1.4 дэх хэсэгт заасан гэрээний хугацаа 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 2024 оны дугаар 12 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаагаар сунгав.

2. БУСАД

2.1 Нэмэлт гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж батлагдсанаар хүчин төгөлдөр болно.
2.2 Нэмэлт гэрээг хууль зүйн хувь адил хүчин чадал бүхий 2 хувь үйлдэж бичсэд Талууд тус бүр нэг хувийг хадгална.
2.3 Нэмэлт гэрээний дагуу нэмэлт, өөрчлөлт оруулсан Үндсэн гэрээний бусад заалт хүчин төгөлдөр хэвээр байна.



БАТЛАВ:
ӨМНӨГОВЬ АЙМАГИЙН ЦОГТЦЭГИЙ СУМЫН
СУМ ДУНДЫН ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЭМЧ
Б.АМАРТҮВШИН

БАТЛАВ:
"ТИ ТИ ЖИЙ СИ ӨҮ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ВАН ЧАНГ ЧИН

ЭМНЭЛГИЙН АЮУЛТАЙ БОЛОН ЭРСДЭЛТЭЙ ХОГ ХАЯГДЛЫГ ТЭЭВЭРЛЭХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ, УСТГАХ, АЮУЛГҮЙ БОЛГОХ ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ГЭРЭЭ

2024 оны 3 дугаар сарын 5-ны өдөр № Улаанбаатар хот

Нэг талаас Өмнөговь аймгийн Цогтцэгий сумын сум дундын эмнэлэг /цаашид "Түшүүлэгч" гэх/, түүнийг төлөөлж Ерөнхий эмч Б.Амартүвшин;

Нөгөө талаас "Ти Ти Жи Би Си Өү" ХХК/РД:5564864/ /цаашид "Харилцагч" гэх/, түүнийг төлөөлж ХАБЭАБО-ны хэлтсийн менежер Б.Чагдарбал, нар /цаашид хамтад нь "Талууд" гэх/;

Монгол Улсын Иргэний хууль, Аюулгүй болон Үйлчлэгчийн хог хаягдлын тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/505 тоот тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах журам" болон бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон харилцан тохиролцож тогтуулах хоорондоо 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан "Эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлэх, хадгалах, халдваргүйжүүлэх, устгах, аюулгүй болгох гэрээ" /цаашид "Үндсэн гэрээ" гэх/-д үг гэрээний 4.3-т заасныг удирдлага болгон дараах нэмэлт гэрээ "Нэмэлт гэрээ"-г байгуулахаар харилцан тохиролцов.

Нэг. ГЭРЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТ

1.1 Үндсэн гэрээний 4 дүгээр зүйлийн 4.2 дах заалтыг дараах байдлаар өөрчлөв.

"4.2. Гэрээний хүчинтэй хугацаа нь 2025 оны 03 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл нэг жилийн хугацаатай байна."

1.2 Үндсэн гэрээний 4 дүгээр зүйлийн 4.3 дах заалтыг дараах байдлаар өөрчлөв.

"4.3. Энэхүү гэрээний 4.2-т заасан хугацаа дуусахаар болохоо Талуудын аль аль нь цаашид үргэлжлүүлэн сунгахгүй тухай саналаа гаргагүй тохиолдолд дээрх нэг жилийн хугацаагаар сунгагдана."

Хоёр. БУСАД

2.1. Энэхүү Нэмэлт гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсанаар хүчин төгөлдөр болно.
2.2. Энэхүү Нэмэлт гэрээнд тусгагдаагүй бусад харилцаа нь Үндсэн гэрээнд заасны дагуу зохицуулагдана.

Зураг № 104. "Ти Эн Түншлэл"-ийн Аюултай хог хаягдал шилжүүлэх, тээвэрлэх гэрээ, баримт

Үүнээс гадна хаягдал батарейг энгийн хог хаягдалтай хольж хаяхаас сэргийлэн оффисын ажилтнуудын хэрэглээнээс гарах ашигласан батарей цуглуулах савыг оффист байрлуулан хаягдал батарейг цуглуулж байна.




Зураг № 105. Хаягдал батарей цуглуулж буй байдал

11.1.3 Гэрээт байгууллагуудын аюултай хог хаягдлын талбайн стандартыг хангуулахад хяналт тавих

Цанхийн баруун, зүүн уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил гүйцэтгэх гэрээт компаниуд болох Ти Эн түншлэл, Үндэсний уурхайчин түншлэл болон Тавантолгой оператор түншлэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй техникүүдийн үйлчилгээнээс гарах хог хаягдал нь уурхайн нийт аюултай хог хаягдлын зонхилох хувийг эзэлдэг.

2024 онд гэрээт байгууллагуудын аюултай хог хаягдлын цэгт хяналт тавих хуваарийг боловсруулж Салбарын захирлаар батлуулан, тогтмол хяналт тавьж ажиллаж байна.



БАТЛАВ.
САЛБАРЫН ЗАХИРАЛ Ц.ДӨРЖСҮРЭН

Гэрээт байгууллагуудын аюултай хог хаягдлын цэгт хяналт тавих хуваарь (2024 он)

Сар	I		II		III		IV		V		VI		VII		VIII		IX		X		XI		XII	
Байгууллага	I	II	I	II	I	II	I	II	I	II	I	II	I	II	I	II	I	II	I	II	I	II	I	II
Ти Эн Түншлэл																								
Овоот толгой ресурс ХХК																								
КАРС ХХК																								
Үндэсний оператор түншлэл																								
Үндэсний уурхайчин түншлэл																								
Рэд рок катеринг ХХК																								
Үндэсний манлайлал түншлэл																								

Тайлбар: 14 хоног тутамд гэрээт компаниудын аюултай хог хаягдлын цэгт хяналт тавих, зөрчлийг шуурхай, арилгуулах арга хэмжээ авч ажиллана.

БОЛОВСРУУЛСАН: А.БАТЗАЯА /БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН/

Зураг № 106. Гэрээт байгууллагуудын аюултай хог хаягдлын цэгт хяналт тавих хуваарь

Цанхийн баруун, зүүн уурхайд 3 ширхэг аюултай хог хаягдал цуглуулах байгууламжийг ашиглаж байгаа ба тус байгууламжид аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, гэрээт байгууллагад нийлүүлэх хүртэлх хугацаанд хадгалж байна. Тус байгууламж нь аюултай хог хаягдал хадгалах шаардлагын дагуу тэмдэглэгээтэй, хөрсөнд нэвчихээс сэргийлсэн бетон суурьтай, блокон 6 тасалгаатай байгууламж юм.



Зураг № 107. Аюултай хог хаягдал түр хадгалах байрны зураг

11.2 Ахуйн хог хаягдал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
11.2.1	Уурхайн хог хаягдлын түр цэг тогтоолгож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх	10 цэг	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргаар 2023.10.16-ны өдөр А/370 дугаартай, 2024.03.25-ны өдөр А/85 дугаартай “Хог хаягдлын цэг тогтоох тухай” захирамжийг тус тус гаргуулсан. Хог хаягдал ангилан ялгах зориулалт бүхий 10 ш сав нийлүүлэх гэрээг “Замилаа богд” ХХК-тай байгуулсан ба гэрээний дагуу хогийн савны худалдан авалтыг хийж, зохих цэгүүдэд байршуулсан.	100%
11.2.2	Хоол хүнсний хаягдал зайлуулж буй цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх	Улиралд 1 удаа	Уурхай болон ажлын байран дах хог хаягдлын цэгүүд болон ариутгах татуургын цооногуудад, ариутгал халдваргүйжүүлэлтийг сар бүрийн 15-ны өдөр катерингийн компанийн үйлчилгээний ажилтнууд, Хүслэн хийморь ХХК, Өмнөговь аймгийн Зооноз өвчин судлалын төвтэй хамтран хийж гүйцэтгэдэг.	100%
11.2.3	Дахивар хаягдлыг ангилан ялгаж, хүлээн авах байгууллагад нийлүүлэх	>5 тн	Тайлант онд 5.1 тн хуванцар хог хаягдлыг Цэмцгэр Өмнөговь ОНӨААТҮГазар болон “Дүүрэн Цэций” ХХК-д нийлүүлсэн.	100%
11.2.4	Хог хаягдлыг урсгалыг хянах бүртгэлжүүлэх	Нэгж тайлан	Хог хаягдлын журмын дагуу өдөр тутмын үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлыг бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн.	100%

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
11.2.5	Шаардлагатай байршлуудад хог хаядлын ангилан ялгах савыг шинээр байршуулах, шинэчлэх	>100ш	Салбарын гадаад, дотоод орчны хог хаягдлыг цуглуулах савыг сайжруулах зорилгоор 32-40 л багтаамжтай 200 ш, 100 л багтаамжтай 100 ш хогийн савыг худалдан авч шаардлагатай газруудад байршуулсан.	100%
Байгаль орчны нийцлийг хэрэгжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөөгөөр оноо авахгүй бөгөөд харин бэлэн байдалд хийгдсэн шалгалтаар сануулга хүргүүлэх ба сарын төлөвлөгөөг хянан дүгнэх хугацаанд үл нийцлийг арилгах үүрэг хүлээнэ. Тухайн сануулгаар үл нийцлийг арилгаагүй бол зөрчилд тооцож оноог хасах зарчим баримтласан.



Зураг № 152. Гэрээт байгууллагын сарын гүйцэтгэлийн үнэлгээг баталгаажуулах хуудас

Мөн туслан гүйцэтгэгч компанийн удирдлагуудад байгаль орчинтой холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, байгаль орчныг хамгаалах чиглэлээр зайлшгүй хийгдэх

шаардлагатай ажил, сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг явуулах нь чухал ач холбогдолтой гэдгийг ойлгуулсан давуу талтай ажил болсон.

13.3 Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр сумын төвийн зорилтот 30 айл өрхөд эко жорлон байрлуулах

Сууршлийн бүсийн хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын зорилтот бүлгийн 30 өрхөд Био ариун цэврийн байгуулах ажлыг Цогтцэций сумын ЗДТГ-аас санал авч хийж гүйцэтгэсэн.


ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЦОГТЦЭЦИЙ СУМ ДАХЬ САЛБАР

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Г.БАЦМАА ТАНАА

Уурхайн 2024 оны "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө"-д тусгагдсаны дагуу "Цогтцэций сумын төвд хөрсний бохирдлоос хамгаалсан ариун цэврийн байгууламжийг ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй айл өрхөд суурилуулахаар төлөвлөсөн.

Иймд Био жорлон суурилуулах шаардлагатай зорилтот 30 өрхийн мэдээлэл, судалгааг ирүүлнэ үү.

САЛБАРЫН ЗАХИРАЛ Л.ДОРЖСҮРЭН

1124090147

Зураг № 153. Цогтцэций сумын ЗДТГ-аас 30 өрхийн мэдээлэл ирүүлэх тухай албан бичиг

"Эрдэнэс Тавантолгой" ХК-ны Өмнөговь аймаг дахь Салбарын захирлын 2024 оны 05-р сарын 09-ны өдрийн 03/143 дугаартай албан бичгийн хариуд Цогтцэций сумын Засаг даргаас 30 өрхийн мэдээллийг ирүүлсэн бөгөөд "Эрдэнэс Тавантолгой" ХК нь гэрээт туслан гүйцэтгэгч нарынхаа хамтаар уг ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт № 62 Цогтцэций сумаас ирүүлсэн био ариун цэврийн байгууламж хийлгэх өрхийн мэдээлэл болон хариуцан гүйцэтгэсэн компанийн мэдээлэл

№	Овог	Нэр	Баг	Гэрийн хаяг	Утасны дугаар	Хариуцсан компани
1	Сэржмядаг	Сэрээ	Билгэх	Зүүн суу 5-517	89994307	ТН Түншлэл
2	Цэдэнхүү	Цэндсүрэн	Билгэх	Зүүн суу 421	88010482	
3	Цэрэндорж	Алтантунгалаг	Билгэх			
4	Мөнхчулуу	Шоовдор	Билгэх	Зүүн суу 829	89422008 88038790	
5	Санжид	Маам		Шинэ хотхон	80225665	
6	Цогзол	Нэргүй	Билгэх		86159007	
7	Мөнхнасан	Цэдэн-Иш	Билгэх	Зүүн суу 1-3	88515560	
8	Сэржмядаг	Амармаа	Цагаан-Овоо	Цагаан овоо 316	89196828	
9	Лут	Өвгөнхүү	Билгэх	Шинэ хотхон 5-503	80017572	
10	Цээнзэн	Хүүхэн	Сийрст		88935029	
11	Шар	Ленин	Сийрст	Цэций уул 300	89760015	ЭТТ
12	Жалцав	Мядагмаа	Цагаан-Овоо	Цагаан-Овоо 307	88952669	
13	Бор	Банди	Цагаан-Овоо	Бумба-Овоо 3-406	89670729	
14	Бямбадорж	Батчулуу	Цагаан-Овоо	Бумба-Овоо 4-21	88709759	
15	Валя	Мягмаржав	Өгөөмөр	Бумба-Овоо	89000303	

16	Дорж	Мягмаржав	Цагаан-Овоо	Цэций уул 427	88536900	Овоот толгой ресурс
17	Далантай	Буянбат	Цагаан-Овоо	Зүүн суу 237	88535583	Үндэсний оператор түншлэл
18	Найдан	Цэндоо	Цагаан-Овоо	Ямаан хүрэн 5-1	88319627	
19	Цэвэл	Энхтүвшин	Билгэх	Шинэ хотхон 4-614 тоот	88355007 89701412	
20	Түвэп	Цэнджаргал	Билгэх	Хөдөө	88609953 86704555	
21	Пүрэв	Янжмаа	Билгэх	Ямаан хүрэн 114	89296746	Үндэсний уурхайчин түншлэл
22	Баттогтох	Мөнхгэрэл	Цагаан-Овоо	Цэций уул 5-15 тоот	80074742 89124483	
23	Довчинцэрэн	Чимэд-Очир	Сийрст	Уурхайчин 6-192		
24	Батсуурь	Уламбаяр	Сийрст	Ямаан хүрэн 5-11	88305398	
25	Данзан	Нарандулам	Цагаан-Овоо	Өгөөрөм 11-22	88207292	
26	Халтар	Бат-Эрдэнэ	Сийрст	Цэций уул 7-735	89908822	КА майнинг ХХК
27	Жамъянхорол	Хунчулуун			88205504	
28	Содном	Баттогтох	Цагаан-Овоо	Баруун суу 103а	88403477	
29	Жигмэд	Цолмон	Билгэх	Өгөөрөм хороолол	88707781	
30	Эрдэнэ	Чанцал	Сийрст	Ямаан хүрэн 1/2	89761212	



Зураг № 154. Ариун цэврийн байгууламжийн нүхийг бэлтгэж буй байдал



Зураг № 155. Бэлдсэн нүхэнд битүүмжтэй кольцо суулгаж буй байдал



Зураг № 156. Кольцог битүүмжилж буй байдал



Зураг № 157. Ариун цэврийн байгууламж байгуулахын өмнөх болон дараах зураг

13.4 Сумын төвийн 2-с доошгүй худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг хашаажуулах

Цогтцэций сумын төвийн Өгөөмөр багийн нутаг дэвсгэрт байрлах 7-р худаг болон Шинэ худагт хамгаалалтын хашааг хийж гүйцэтгэсэн.



Зураг № 158. Худгуудад хамгаааалтын хашаа барихын өмнөх байдал




Зураг № 159. Хамгаалалтын хашаа барьж буй байдал




Зураг № 160. Худгийн хамгаалалтын хашааг барьж дуусгасан байдал

13.5 Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр малчдыг туршлага судлуулах

Эрчимжсэн мал аж ахуй болон хоршооллын үйл ажиллагааны туршлага судлах зорилгоор Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн 3 хоршоологч, Билгэх багийн 1 хоршоологч, Сийрэст багийн 2 хоршоологчийг Булган аймгийн Сэлэнгэ суманд орших жишиг хоршооллын үйл ажиллагаатай танилцуулж туршлага судлуулах аялалыг 2024 оны 10-р сарын 25-30-ны өдрийн хооронд зохион байгуулсан.







Зураг № 161. Туршлага судлах аялалд хамрагдаж буй байдал


13.6 Цагаан-Овоо багийн малчдын хоршооллыг дэмжиж ажиллах

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 13 дугаар бүлгийн 13.6-д тусгагдсан малчдын хоршооллыг дэмжин ажиллаж, санамж бичиг байгуулах ажлын хүрээнд 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Салбарын захирал Л.Доржсүрэн болон “Билэгт Малчид” хоршооны дарга Ц.Лхагвадаш нар санамж бичиг байгуулсан.



Зураг № 162. Санамж бичиг байгуулж буй байдал

Уг санамж бичгийн дагуу хоршооллын үйл ажиллагаа, эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх чиглэлээр туршлага судлах, говийн бүсийн мод үржүүлэг хийх чиглэлээр сургалтад хамруулах, хоршооллын үйл ажиллагаанд ашиглаж болохуйц эд материалын дэмжлэг үзүүлэх, чиглэлээр талууд харилцан ойлголцож, хамтран ажиллах юм.



ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2024 оны 09 сарын 27-ны өдөр № Цогтцэций сум

Энэхүү Хамтран ажиллах санамж бичгийг

Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжидсүрэн-8, Финанс тов хаягт байрлах, 5435528 регистрийн дугаартай "Эрдэнэс Тавантолгой" ХК (цаашид "ЭТТ" ХК гэх), түүнийг төлөөлж Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь Салбарын захирал Л.Доржсүрэн,

Нөгөө талаас Монгол Улс, Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-Овоо баг байрлах 3851584 регистрийн дугаартай Билэгт малчид хоршоо (цаашид "Хоршоо" гэх), түүнийг төлөөлж Хоршоолын дарга Ц.Лхагвадаш, (цаашид хамтад нь "Талууд" гэх) нар нь дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО

1.1 "ЭТТ" ХК-ийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 13 дугаар бүлгийн 13.6-д тусгагдсан Цагаан-Овоо багийн малчдын хоршоолныг дэмжин ажиллах, Санамж бичиг байгуулах ажлын хүрээнд Хоршоолын үйл ажиллагаа, эрчимжсэн мал аж ахуй хөжүүлэх чиглэлээр туршлага судлах, гэмийн бүсийн мод уремуулэг хийх чиглэлээр суралцагч хамруулах, хоршоолын үйл ажиллагаанд ашиглах болохуйц эд материалын дэмжлэг үзүүлэх, чиглэлээр Талууд харилцан ойлголцон, хамтран ажиллах зорилгоор энэхүү Санамж бичгийг байгуулав.

1.2 Санамж бичиг бүхэлдээ талуудын дагаж мөрдөх бүй хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн бөгөөд Санамж бичиг байгуулах болсон үндэслэл, шаардлагатай нөхцөлийн талаар бүрэн ойлголцсон болно.

1.3 Хамтын ажиллагаа нь хууль болон бусад эрх зүйн актаар хориглоогүй асуудалд ял тод, нээлттэй байх бөгөөд хамтын ажиллагааны үр дүнг хэлэлцэх зарчмыг баримтлан Монгол Улсын хуулийн хүрээнд хэрэгжинэ.

1.4 Санамж бичиг нь талуудын цаашдын хамтын ажиллагаанд дагаж мөрдөгдөх зохих баримт бичиг мөн бөгөөд талууд хоорондоо Санамж бичигт дурдагдаагүй санаачлагийн болон бусад үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНД МӨРДӨХ ХУГАЦАА

2.1 Энэхүү Санамж бичиг нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн 1 /нэг/ жилийн хугацаанд хүчинтэй байна.

2.2 Аль нэг тал нь энэхүү Санамж бичгийг дуусгавар болгохыг хүсвэл нөгөө талдаа 3 сарын өмнө зөвлөл бичгээр мэдэгдэнэ.

ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Талууд хамтын ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нээлттэй, шударга байх зарчмыг баримтлах бөгөөд талуудын эрх ашиг, нэр хүндийг хүндэтгэх үүрэгтэй.

3.1 Санамж бичгийн хүрээнд хийгдэх ажлыг харилцан тохиролцож, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх бөгөөд ингэхдээ энэхүү Санамж бичгийн 1.3-д заасан зарчмыг баримтална.

3.2 Санамж бичгийн хүрээнд талууд аливаа үйл ажиллагаа явуулахдаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны болгоно, холбогдох дүрэм журмыг чанд мөрдөнө.

5.5 Талууд энэхүү Санамж бичгийг хэрэгжүүлэх явцад хүлээж болох мэдэж авсан негөө талынхаа бүхий л бизнесийн мэдээлэл, бичиг баримт, албан бичгийн нууцыг чандлан хадгална.

5.6 Талууд энэхүү Санамж бичгийг хэрэгжүүлэх явцад олсон бусад талуудын аливаа хэлбэрийн худалдааны мэдээлэл, технологийн мэдээлэл, бичиг баримтын эзэмшлийн нууцыг чанд хамгаална.

5.7 Хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд талууд бичгээр зөвшөөрөөгүй бол талууд тус бүр Санамж бичиг болон түүнийг хэрэгжүүлэх хугацаанд хүргүүлсэн аливаа баримт бичиг, мэдээллийг гуравдагч этгээдэд өөрсдөө болохгүй.

5.8 Энэхүү нууц хадгалах заалт нь Санамж бичгийн хүчинтэй хугацаанд болон Санамж бичиг дуусгавар болсны дараа 2 жилийн дотор хүчинтэй байна.

ЗУРГАА. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт төрийн байгууллагын шийдвэр, хил хорио, нийтийн эмх замбараагүй байдал, байгалийн гамшиг (ой хээрийн түймэр, газар хөдлөлт, хүчтэй салхи, шуурга, их хэмжээний үер г.м)-ийг хамаарууллж ойлгоно.

6.2 Санамж бичгийн дагуу гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдалд үүссэн тохиолдолд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үргэлжлэх хугацаанд нөлөөнд өртөөн тал үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөнө.

ДОЛОО. БУСАД

7.1 Талууд нь энэхүү Санамж бичгийг /3/ эх хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр дээр гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд хувууд нь нэгэн адил хүчинтэй байна.

7.2 Хамтын үйл ажиллагааны удирдлагыг талууд Санамж бичиг байгуулсан үеэс эхлэн хамтран хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжүүлэхдээ тогц зөрчилгүй ажиллана.

7.3 Талууд хамтын ажиллагааны явцад олж мэдсэн тер, байгууллага, хувь хүний нууцыг хөлбогдох хуулийн дагуу хадгалах үүрэгтэй.

7.4 Талууд нь хамтын ажиллагаатай холбоотой асуудлаар албан бичгээр харилцана.

7.5 Талууд нь харилцан тохиролцсоны дагуу энэхүү Санамж бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд Санамж бичигт оруулах аливаа өөрчлөлт болон нэмэлт нь эвэхэн бичгээр үйлдэгдэж, талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН ӨМНӨГӨВ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМ ДАХЬ САЛБАРЫН ЗАХИРАЛ

Л.ДОРЖСҮРЭН

Хаяг: Өмнөговь, Цогтцэций, 2 баг, Цагаан-Овоо
Утас: 79065555

"БИЛЭГТ МАЛЧИД" ХОРШООНЫ ДАРГА

Ц.ЛХАГВАДАШ

Хаяг: Өмнөговь аймаг, Цогтцэций 3-р баг, Цагаан-Овоо Якаши хүрээ 1, 130 тоот
Утас: 91113084

3

Зураг № 163. Санамж бичиг байгуулсан байдал

13.7 Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах

Дэлхийн усны өдөр: Нэгдсэн үндэстний байгууллагаас 2024 оны Дэлхийн Усны Өдрийг “Усны асуудлыг шийдэж Энхтайванд хүрцгээе” (Leveraging Water for Peace) уриан доор тэмдэглэн өнгөрүүлж байна. Байгаль орчин, усны бодлогын хэлтэс болон туслан гүйцэтгэгч гэрээт компаниуд Цогтцэций сумын иргэдтэй уулзалт, хэлэлцүүлэг, Цогтцэций сумын ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд эссэ бичих, гар зураг зурах уралдаан зохион байгуулж, ус ба энхтайван сэдэвт дэвжээ тэмцээнд зохион байгуулалтад хамтран оролцож, дэмжлэг үзүүлэв.


Өмнөговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цогтцэций сумын ЗДТГ-тай хамтран “Дэлхийн усны өдөр”-ыг тохиолдуулан 2024 оны 03-р сарын 22-ны өдөр Цогтцэций сумын Соёлын төвд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Уулзалт хэлэлцүүлэгийг Цогтцэций сумын ИТХ-ын дарга Ц.Доржсүрэн нээж, зочин илтгэгчээр Монгол улсын зөвлөх инженер, “Престиж инженеринг” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Ганзориг уригдаж Говийн бүсийн ус хангамжийн талаарх мэдээллийг иргэдэд танилцуулсан. Мөн Байгаль орчны ахлах мэргэжилтэн Б.Оргил “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ус ашиглалт, хэтийн төлөв, “Энержи ресурс” ХХК-ийн Ус хангамжийн менежер Б.Баттулга, “Тавантолгой” ХК-ийн ус ашиглалтын мэргэжилтэн нар ус ашиглалт дэвшилтэд технологи сэдвээр илтгэл тавьсан.



Зураг № 164. "Дэлхийн усны өдөр"-ийн хэлэлцүүлэгт оролцож буй байдал

Говийн усны нөөцийг хамгаалах, хэмнэлттэй, зүй зохистой ашиглах хандлагыг сурагчдаар дамжуулан иргэдэд хүргэх, тэднийг оролцоог нэмэгдүүлэх, суртчилан таниулах зорилгоор Цогтцэций сумын ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд “Эссэ бичих” уралдаан, дунд болон бага ангийн сурагчдын дунд “Гар зураг”-ийн уралдаан зохион байгуулан шилдэг бүтээлүүдийг тодруулсан ба соёлын төвд нийт ирүүлсэн гар зургуудаар үзэсгэлэн гаргасан.



Зураг № 165. Эссэ бичлэгийн уралдаанд түрүүлсэн бүтээлүүд



Зураг № 166. Гар зургийн уралдаанд түрүүлсэн бүтээлүүд

Дэлхийн ойн өдөр: Энэ жилийн хувьд Олон улсын ойн өдрийг "Ой мод ба инноваци: Илүү сайн ертөнцийг бий болгох шинэ шийдэл" уриа доор тэмдэглэн өнгөрүүлж байна. Энэхүү өдрийн хүрээнд манай компанийн 2030 он хүртэл хэрэгжүүлэх "Сая тонн-Сая мод" хөтөлбөрийн танилцуулга, Бид мазаалайг хамгаалж чадна хандивын аяны тухай мэдээлэл мөн ажилчдын дунд асуулт хариулт зохион байгуулж Эрсдэл, стандарт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн А.Гантулга, ОТР-ийн БО-ны мэргэжилтэн Эрдэнэчимэг, Хүний нөөцийн мэргэжилтэн Д.Нямбаяр нар идэвхтэй оролцож гарын бэлэг авлаа.

Мөн оролцсон бүх ажилчдадаа Сибирь гүйлс / монгол сакура /-ний үр болон мод тарих гарын авлагын хамт бэлэглэсэн.



Зураг № 167. Дэлхийн ойн өдрийг тэмдэглэн өнгөрүүлж буй байдал


Эх орон-миний говь аялал: 2024 оны 09 сарын 20-ны өдөр Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны Нутгийн Хишиг хөтөлбөрийн “Ирээдүй-боловсрол, Инновацийн хөгжлийн бодлого”-ын 75 дахь “Хэл соёл, түүх уламжлал, зан заншил, байгаль экологийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалтын агуулгыг баяжуулж танин мэдэхүйн мэдлэг олгох бодлого хэрэгжүүлнэ” заалтыг хэрэгжүүлэх хүрээнд “Эх орон-миний говь” аялалд оролцуулахаар Цогтцэций сумын 1 болон 2-р сургуулийн 12 дугаар ангийн төгсөх ангийн сурагчдад 45 хүний суудалтай автобусыг гарган дэмжин ажилласан. Мөн 2024 оны 10 сарын 21-ний өдөр Баян-овоо суманд Экологийн боловсролыг олгох сургалт, аялалд Цогтцэций сумын иргэдийг оролцуулахаар 45 хүний суудалтай автобусыг гарган тус тус дэмжин ажилласан

13.8 БОМТ-ний төлөвлөлтийг сайжруулах, тайлангийн бичилтийг сайжруулж тоо баримт, үндэслэл, баримт нотолгоог хавсралтаар бүрэн оруулах

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох төрийн захиргааны байгууллагаар хянуулан батлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

13.9 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Өмнөговь аймгаас хуваарилсан 3.5 сая модны төлөвлөгөө боловсруулж, батлуулах

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Өмнөговь аймгаас “Эрдэнэс Тавантолгой” ХК-д 3.5 сая мод тарих үүргийг өгсөн. Уг үүргийн дагуу компанийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Сая тонн-Сая мод” хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан тус сумдын нутагт Агро-Ойжуулалтын чиглэрээр 10 га газрын хэмжээтэй агро-ойн аж ахуй байгуулахаар төлөвлөгөө боловсруулан компанийн Засгийн газрын бүрэн эрхэт төлөөлөгч болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраар батлуулсан.



Зураг № 168. Агро-Ойн аж ахуй байгуулах сумдын жагсаалтанд Өмнөговь аймгийн Цогт-Овоо болон Манлай сум хамрагдсан байдал

13.10 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Өмнөговь аймгийн Баян-Овоо, Номгон суманд 20га-с багагүй талбайд загаар ойжуулалт хийх

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт 50 га талбайд 40.000 ширхэг заг модыг тарьж усалгаа арчилгааг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.



Зураг № 169. Мод тарих талбайн хашаа барьж буй байдал




Зураг № 170. Загийн тарьцийг үржүүлж тарилтанд гаргахад бэлтгэсэн байдал




Зураг № 171. Тарилт хийж буй байдал

13.11 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Цогтцэций, Цогт-Овоо, Манлай суманд байгуулах ойн зурвасын ажлыг эхлүүлэх

Цогт-Овоо сум: Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутагт орших сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайн хойд талд байрлах 10 га талбайд 8000 ширхэг Заг модыг 2024 оны 10-р сард тарьсан. Уг ажлыг Хил хамгаалах Ерөнхий газартай байгуулсан гэрээний хүрээнд хийж гүйцэтгэсэн.




Зураг № 172. Мод тарих талбайг бэлтгэж буй байдал



Зураг № 173. Заг модыг тарьж буй байдал

Манлай сум: Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт орших Шар цавд байрлах 10 га талбайд 8000 ширхэг Заг модыг 2024 оны 10-р сард тарьсан. Уг ажлыг Хил хамгаалах Ерөнхий газартай байгуулсан гэрээний хүрээнд хийж гүйцэтгэсэн.



Зураг № 174. Заг тарих талбайг бэлтгэж буй байдал



Зураг № 175. Манлай суманд Загаар ойжуулах ажил хийж буй байдал

13.12 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн Модлог ургамлын тарьц, суулгац үржүүлэх

2024 онд өвлийн хүлэмжинд үрээр үржүүлсэн 16000 ширхэг тарьцнаас хаврын тооллогоор 13600 ширхэг нь ургасан нь амьдралтын хувь 85 хувьтай байсан. Үүнээс намрын тооллогоор 12000 ш байгаа бөгөөд амьдралтын хувь 88 хувьтай ургаж байна.

Ил талбайд үрээр тарьсан моднуудыг намар тооцохдоо 1000 үрийн жингийн стандарт нормыг үндэслэн 143000 ширхэг гэсэн тоог гаргасан бөгөөд дээрх тоонд тооцогдоогүй болно.

Хүснэгт № 63. 2024 онд "Эрдэнэс" агропаркад үр болон мөчрөөр үржүүлж буй модны тоо

№	Модны төрөл	2024 он		Одоо ургаж буй тоо, ш
		Үрээр тарьсан тоо, ш/кг	Мөчрөөр тарьсан тоо, ш	
1	Жигд	16000 ш	-	12000 ш (намрын тооллого)
2	Бүйлс	13 кг	-	11700 ш (намрын тооллого)
3	Гүйлс	25 кг	-	12600 ш (намрын тооллого)
4	Шар хуайс	2.7 кг	-	4145 ш (намрын тооллого)
5	Сухай	-	13000	12150 ш (намрын тооллого)
6	Улиас	-	3000	55 ш (намрын тооллого)
Бүгд				**49965 ш**
Хайлаас		40 кг	-	Ил талбайд үрээр тариалсан бөгөөд 1000 үрийн жингээр тооцоход 143000 ш болно
Харгана		8.4 кг	-	
Шар хуайс		5.0 кг	-	

Өвлийн хүлэмж: Өмнөх оны 11 сард үрээр тарьсан жигдний тарьцийг тайлант оны 2-3 сард нийлэг хальсан бортогонд шилжүүлэх ажлыг хийсэн бөгөөд 4-5 сард ил талбайд 6000 ширхэгийг гаргаж, усалгааны систем угсрах ажлыг зохион байгуулсан. 2024 онд өвлийн хүлэмжинд 2 дахь удаагийн тариалалтыг хийж Жигдийн 5 кг үрийг 2-р сард тариалж 6-7 саруудад бортогонд шилжүүлэн суулган ил талбайд нийт 7000 ширхэгийг гаргасан. Нийтдээ 13000 ширхэг орчим бортоготой Жигдийн тарьц гаргаж, эгнээ үүсгэж усалгааг сайтар хийж, жилийн өсөлт 30-40 см хүртэл үзүүлсэн. 3 дахь удаагийн тариалалтыг тус оны 7-р сард 2,7 кг Шар хуайс тус тус тариалсан. Нийт амьдралтын хувь -86,5 % байна.




Зураг № 176. Өвлийн хүлэмжинд мод үржүүлэн гадаа талбайд бойжуулж буй байдал

Зуны хүлэмж /50х6/: 06 сарын 14-15-ний өдрүүдэд Бүйлс-13 кг, Гүйлс-25 кг тус тус тарьж, усалгааг бороожуулагч системээр өдөр бүр хийж, нар бууруулагч татсан. Нийт 2 хүлэмжид 26,000 ширхэг бортогонд тарилт хийснээс амьдралтын хувь 85%-тай, 22,100ш бортоготой тарьц гаргахаар тооцсон.





Зураг № 177. Зуны хүлэмжинд үрээр бортогонд тарилт хийж буй байдал

13.13 Галба-Өөш Долоодын говийн сав газрын зөвлөлийн хурлыг зохион байгуулах


Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны талуудын оролцооны зөвлөлийн хуралдаан 11-р сарын 21, 22-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Сайншанд хотноо зохион байгуулагдсан. Тус хуралдаанаар 2025 оны эхний ээлжит хуралдааныг 2025 оны 1-р улиралд ЭТТ ХК хариуцан зохион байгуулах чиглэл өгсөн.

14. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тайлагнах хэлбэр	Хэрэгжилт	Биелэлт %
1	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон 2024 оны Байгаль орчны менежементийн төлөвлөгөөг байгууллагын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулах	Компанийн албан ёсны вэб хуудас	Компанийн www.ett.mn веб хуудсанд 2023 оны БОМТ-ийн биелэлтийн тайлан болон 2024 оны БОМТ-г байршуулсан.	100%
2	Цогтцэций сумын Цагаан-Овоо, Билгэх, Сийрст багийн иргэд	Олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг малчид болон багийн иргэд нийтэд танилцуулах үйл ажиллагааг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Грийн центр”-т зохион байгуулсан.	100%

14.1 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон 2024 оны Байгаль орчны менежементийн төлөвлөгөөг байгууллагын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулах

Компанийн www.ett.mn веб хуудсанд 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй байдлаар байршуулсан.



Зураг № 178. Компанийн цахим хуудсанд БОМТ болон биелэлтийн тайланг байршуулсан байдал

14.2 Багийн иргэдэд БОМТ-ийн хэрэгжилтийг танилцуулах хурал

2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг малчид болон багийн иргэд нийтэд танилцуулах үйл ажиллагааг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Грийн центр”-т зохион байгуулсан.



Зураг № 179. Танилцуулах уулзалтанд хүрэлцэн ирсэн хүмүүс

Энэхүү арга хэмжээний үеэр уурхайн үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлууд, 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг малчид, иргэдэд холбогдох хариуцсан мэргэжилтнүүд танилцуулж, уурхай, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг зочдодоо газар дээр нь танилцуулсан. Мөн Салбарын захирал Л.Доржсүрэн иргэд, малчдын асуултад хариулж, санал солилцов.



Зураг № 180. Малчдыг мод үржүүлэг болон уурхайн үйл ажиллагаатай танилцуулж буй байдал

Мөн Цагаан-овоо хөдөлгөөн ТББ-ын зохион байгуулсан “Монголын говио хайрлая” говийн бүсийн иргэний нийгмийн байгууллагуудын чуулга уулзалт 2024 оны 11 сарын 15-ны өдөр Цогтцэций суманд зохион байгуулагдсан. Тус хэлэлцүүлэг ЭТТ ХК “Таван толгойн бүлэг ордын байгаль орчин, нийгэмд үзүүлж буй хуримтлагдах нөлөөлөл, уул уурхайн нөлөөллөөс үүссэн байгаль орчин агаарын бохирдлыг бууруулах, бэлчээрийн доройтлыг арилгах ажлын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр” сэдвээр илтгэл, 2024 оны 11 сарын 16-ны өдөр Цогтцэций суманд “Хариуцлагатай уул уурхай говийн бүсийн чуулга уулзалт” зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд говийн бүсэд хамаарагдах Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь аймгуудад хайгуул олборлолтын үйл ажиллагаа явуулж буй ААН болон тухай бүсийн төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, орон нутгийн иргэдийн төлөөлөл нийлсэн 350 гаруй хүн оролцсон бөгөөд ЭТТ ХК “Эрдэс баялгийн салбар дахь хариуцлагатай үйл ажиллагаа” сэдвээр илтгэл тавьж нээлттэй ажлын байр зарлан хамтран оролцсон.

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

№	Үйл ажиллагааны чиглэл	Төлөвлөсөн төсөв	Зарцуулсан хөрөнгө /мян. ₮/
1	Нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа	132,700.00	406,824.00
2	Зохион байгуулалтын төлөвлөгөө	167,449.00	140,500.00
3	ОХШХөтөлбөр	240,416.33	137,416.33
4	Хог хаягдлын менежмент	159,558.81	128,300.00
5	Соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-	-
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	233,165.83	93,700.00
7	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	365,000.00	363,649.00
8	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17,377.36	17,377.36
Нийт		**1,315,667.33**	**1,287,766.69**

15. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУРЫН ДҮН

Бүлэг	Бүлгийн нэр	Төлөвлөсөн ажил	Шалгуур	Хэрэгжилт	Эзлэх жин	Хувь
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө						
5.1.1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Тоос бууруулах бодисыг технологийн замд ашиглана.	Цанхийн уурхайнуудын технологийн замын 30 км замд бодисыг ашигласан байна.	Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогч “ТН түншлэл” 2024 онд 8 км замд тоос бууруулах ажил хийхээр төлөвлөснөөс 5 км замд ашигласан. Цанхийн баруун уурхайн гэрээт “КА майнинг” ХХК 8 км замд ашиглахаар “Эй Эм И Си Ти” ХХК-тай гэрээ байгуулсан. Бодисын захиалга хийгдсэн хүлээгдэж байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК 10 км замд тоос бууруулах ажилд 5.8 тэрбум төгрөг төсөвт суулгаж, захиалга хийгдээд байна.	0.2	50%
5.1.2		Уурхайн ашиглалтын замыг сайжруулах: материал, дэвсэлт хийх	Цанхийн уурхайнуудын технологийн замын 10-аас багагүй км замд сайжруулах дэвсэлт хийж сайжруулсан байна.	Тоосжилтыг бууруулах зориулалтаар уурхайн худгуудын усыг зам, талбайг чийглэх уламжлалт аргыг хэрэглэж байгаа ба уурхай болон хөрсний овоолгын ачаалал ихтэй, тоосжилт ихээр үүсгэж буй зам талбай, уулзвар эргэлтийг тодорхойлж улаан шаварлаг материал болон хайрга, дайрга дэвсэх ажлыг өдөр бүр төлөвлөж гэрээт байгууллагуудаар хийж гүйцэтгүүлдэг.	0.4	100%
5.1.3		Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн талбайд усалгааны машиныг тогтмол ажиллуулах	Уурхайн хэмжээнд 5-аас доошгүй усалгааны машиныг жилийн турш тогтмол усалгаанд ашигласан байна.	Уурхайн технологийн автозамаас үүсч буй тоосжилтийг бууруулах зорилгоор өдөр тутам 10-аас багагүй тооны усны машин ажиллаж усалгаа хийгддэг ба энэ оны эхний 10-н сарын дараах байдлаар нийт 476,277 $м^3$ усыг зам усалгаанд ашигласан байна. Үүнээс 242,137 $м^3$ хур бороонд хуримтлагдсан ус, 77,872 $м^3$ уурхайн шүүрлийн ус, 12,647 $м^3$ цэвэршүүлсэн саарал ус, 143,621 $м^3$ гүний усыг авч ашигласан тооцоо байна.	0.4	100%
5.1.4		Уурхайн дотоод зам талбайд шороон зам дээгүүр зорчиж буй хөнгөн тэрэг болон уулын машин механизмуудад хурдны хязгаар	Сар бүр уурхайн хөдөлгөөнт техникүүдэд хяналт шалгалтыг тогтмол хийсэн байна.	Уурхайн замын хөдөлгөөнд оролцож буй техникүүдийн хурд хэмжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч байгууллага болгон Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн нар тогтмол 7 хоног бүр гэнэтийн хэмжилтийг хийдэг бөгөөд оны эхний 10 сарын дараах байдлаар Цанхийн	0.4	100%

		тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийж хяналт тавих		зүүн уурхайд 246 удаа, Цанхийн баруун уурхайд 1149 удаа, нийтдээ 1395 удаа хэмжилтийг хийсэн байна.		
5.1.5		Кемп хоорондын зам болон ачаа тээврийн сайжруулсан шороон замын засвар үйлчилгээ, арчилгааны хуваарь гарган батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах	Сайжруулсан шороон замын засвар үйлчилгээний хуваарийг бүх гэрээт компаниудыг оролцуулан боловсруулж батлуулан хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан байна.	Цогтцэций-Даланзадгад чиглэлийн замаас Баруун нарангийн автозам хүртэлх 7.4 км автозамын арчилгааг гэрээт байгуулагуудын сар бүрийн төлөвлөгөөнд тусган тухай бүрт хийлгүүлэн ажилласан. 13.5 км автозамаас шинэ сууршлийн бүстэй холбох 2.2 км автозамын ажил хийгддэж байгаа бөгөөд энэ зам ашиглалтад орохоор бүх тээврийг тухайн замаар зорчуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	0.4	100%
5.1.6		Нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Нүүрс ачуулан гарч буй бүх техникт хучлагыг бүрэн хийлгэсний дараагаар ачилтаас гаргах үйл ажиллагаанд байнгын хяналт хийсэн байна.	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нүүрс ачилтын хэлтэст 4-н ээлжинд нийт 32 хучигч ээлжээр ажилладаг ба нүүрс тээврийн ачаатай машиныг хучих ажлыг хариуцан гүйцэтгэдэг тул хучилт хийлгээгүй машин уурхайн бүсээс гарах боломжгүй байдаг.	0.4	100%
5.1.7		Нүүрс ачилтын талбайд усалгаа хийх	Нүүрс ачилтын талбайд 2-оос доошгүй усны машин ажиллуулж, усалгааг тогтмол хийнэ.	Нүүрс ачилтын зам талбайд батлагдсан хуваарийн дагуу усалгааг өдөр бүр хийж байна. 2024 оны 10-р сарын байдлаар “КА майнинг” ХХК-ны бохир цэвэрлэх байгууламжид цэвэршүүлсэн саарал ус, “Энержи Ресурс” ХХК-ийн цэвэршүүлэх байгууламжаас цэвэршүүлсэн саарал ус, худаг №7 болон гадаргын усыг усалгаанд ашигласан. 2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 33655 м3 усыг ашигласан байна.	0.4	100%
5.1.8		Ашиглаж буй техник хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах	Үйлдвэрлэл техникийн газрын Засвар механикийн хэлтэстэй хамтран уурхайн ажилд ашиглагдаж буй автомашинуудыг тээврийн хэрэгслийг жилд нэг удаа тогтсон	Уурхайн хөдөлгөөнт техникүүд болох экскаватор, өөрөө буулгагч, дугуйт ачигч, грейдэр, бульдозерууд болон хөнгөн тэргийг тус тус тээврийн хэрэгслийн техникийн үзлэг, оношилгоонд хамруулсан.	0.4	100%

			хугацаанд үзлэгт хамруулах ажиллана.			
5.1.9		Нам даралтын зуухны яндангаар ялгарах хорт хийн хэмжилт хийх, хяналт тавих	Цанхи хотхон болон Грийн центрийн уурын зуухнаас ялгарах утааны шинжилгээний хэмжилтийг итгэмжилсэн лабораторид шинжлүүлж стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллана.	Тайлант онд “Ногоон титэм” ХХК-тай гэрээ байгуулан “Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ”-г Уурын зуухын яндангаас ялгарах хийн /NO2, CO2, SO2, CO, H2S/ үзүүлэлтүүдийн хэмжилтийг хийлгэсэн. Мөн өөрсдийн гар багаж болох Multi Gas Detector багажыг ашиглаж CH4, O2, CO, H2S зэрэг үзүүлэлтийг хэмжсэн.	0.4	100%
5.1.10		Агаарын чанарын суурин станцны худалдан авалтыг хийж, БОАЖГ-т дүн мэдээг онлайнаар өгч байх	Уурхай орчимд	2024 оны төсөвт Агаарын чанарын суурин станцыг 228,525,413 төгрөгийг суулгасан. Уг төсвийн дагуу №230 дугаартай худалдан авалтын захиалгыг 2024 оны 04 сарын 11-нд худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулсан боловч оролцогч оролцоогүй шалтгаанаар амжилтгүй болсон. 07.24-нд захиалгыг дахин шинэчлэхээр үнийн санал авахад инфляцаас шалтгаалан төсөвт суулгасан үнийн дүнгээс 20%-аар өссөн байсан. Иймд үнийн дүнд таарсан техникийн тодорхойлолтыг шинэчлэн 2024.10.10-нд ХААГ-т хүргүүлж 2024.10.18-нд тендер зарлаж 2024 оны 11-р сарын 11-нд тендер нээхээр ажиллаж байна.	0.2	50%
5.2.1	Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Худагт бохирдол алдагдахаас сэргийлэх, холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавина.	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ын уурхайн эзэмшлийн 18 худагт сар бүр тогтмол үзлэг шалгалтыг хийнэ.	Унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй худгуудын усны чанар,түвшингийн өөрчлөлт, ундарга зэргийг тогтмол хянах зорилгоор түвшингийн хэмжилтийг 7 хоногт 2 удаа, ундаргын тооцооллыг сард 1 удаа, усны шинжилгээг улиралд 1 удаа тус тус хийж гүйцэтгэн ажиллаж байна. Мөн хэмжилтийн үр дүнг боловсруулж, хагас жил болон жилийн эцсийн байдлаарх ус ашиглалтын тайланг боловсруулж, Өмнөговь аймгийн БОАЖГазарт, ГӨДСГазарт, Усны газарт тогтмол тайлагнан ажиллаж байна	0.5	100%
5.2.2		Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж,	Ус ашиглах дүгнэлтийг гаргуулж	Цанхийн зүүн уурхайн 2024 оны ус ашиглах дүгнэлтийг 2024 оны 04-р сарын 02-ны өдрийн 01/373 дугаартай	0.5	100%

		зөвшөөрөл авах, ус ашиглах гэрээ байгуулна.	дүгнэлтэнд заагдсаны дагуу холбогдох гэрээг байгуулж төлбөрийг сар бүрийн тоолуурын заалтыг сумын байгаль хамгаалагчаар баталгаажуулж төлбөрийг тогтмол хугацаанд нь төлсөн байна.	албан бичгээр, Цанхийн баруун уурхайн 2024 оны ус ашиглах дүгнэлтийг 2024 оны 04-р сарын 02-ны өдрийн 01/372 дугаартай албан бичгээр тус тус гаргуулж авсан. “Галба Өөш Долоодын Говийн Сав газрын захиргаатай 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 2024/06, ЕТТ-2024/1120 дугаартай Ус ашиглах гэрээ байгуулсан		
5.2.3		Усны нөөц ашигласны төлбөр төлөх, ус ашиглуулах дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ашиглах		Худгаас ашигласан усны ашиглалт тус бүрээр үзвэл унд ахуйн усны хэрэглээ 14.5%, мод усалгаанд ашиглаж буй усны хэрэглээ 5.4%, зам усалгаанд ашиглаж буй усны хэрэглээ 80% байна. Нийт ашигласан усанд эзлэх гүний усны хэрэглээ 35.5%, шүүрлийн усны хэрэглээ 12.48%, гадаргын усны хэрэглээ 48.64%, дахин ашигласан буюу саарал усны хэрэглээ 3.38%-ийн гүйцэтгэлтэй байна.	0.5	100%
5.2.4		Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулан төлбөр төлөх	Сав газрын захиргаанаас хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авч, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулан улирал бүрийн дүгнэлтийг үндэслэн зохих төлбөрийг улирал бүр төлнө.	Хаягдал ус зайлуулах зөвшөөрлийг үндэслэн “Хаягдал усыг байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй байгуулах ус бохирдуулсны төлбөрийн гэрээ”-г 2024 оны 03-р сарын 26-ны өдөр Галба-Өөш, Долоодын Говийн сав газрын захиргаатай байгуулсан. Гэрээний дагуу улирал тутам цэвэрлэх байгууламжуудын оролт, гаралтын бохир уснаас дээж авч лабораторид шинжлүүлэн Усны газраар төлбөрийн тооцоог гаргуулан төлбөрийг тогтмол төлж байна.	0.5	100%
5.2.5		Замын тоосжилт бууруулахад ашиглах гадаргын болон гүний усны харьцааг 0.32-аас бага түвшинд байлгах.	Гадаргын усыг зам талбайн тоосжилт бууруулах усалгаанд ашиглах, зорилтод түвшинд байлгана.	2023 оны байдлаар хур бороонy ус 146,859 м3, газрын доорх ус 392,141 м3 ашигласан бол 2024 оны эхний 10-н сарын дараах байдлаар хур бороонy ус 243,768 м3 буюу өмнөх онтой харьцуулахад 1.7 дахин их, газрын доорх ус 204,952 м3 буюу 0.5 дахин бага хэмжээний ус ашиглаж усны зохистой хэрэглээг хангах талаар анхаарч ажиллалаа. 2023 онд гадаргын болон газрын гүний усны харьцаа нь 0.37 байсан бол 2024 оны эхний 10 сарын дараах байдлаар 1.01 болж өссөн сайн үзүүлэлттэй байна.	0.5	100%
5.2.6		Хаягдал усыг зориулалтын зөвшөөрөлтэй газарт	Гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын хаягдал	2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 16,932 м3 саарал усыг дахин ашигласан бөгөөд эдгээр усыг “Энержи ресурс” ХХК-ны цэвэрлэх байгууламж болон	0.5	100%

		нийлүүлэх, стандарт шаардлагад нийцсэн цэвэршүүлсэн бохир усаар зам талбайн тоосжилт дарах, мод услахад ашиглах	усыг зориулалтын зөвшөөрөлтэй газарт нийлүүлэх түүнд хяналт тавих, стандарт шаардлагад шаардлагад нийцсэн цэвэршүүлсэн бохир усаар зам талбайн тоосжилт дарах, мод услахад ашиглана	“КА майнинг” ХХК-ны цэвэрлэх байгууламжаас авч нүүрс ачилтын талбайн тоосжилт дарах усалгаанд ашигласан байна.		
5.2.7		Уурхайн газар доорхи усны нөөц, чанарт байнгын хяналт тавих	Уурхайн газар доорхи усны мониторингийн цооногуудад түвшний хэмжилт хийх, усны чанарыг лабораторид шинжлүүлнэ.	Унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй худгуудын усны чанар,түвшингийн өөрчлөлт, ундарга зэргийг тогтмол хянах зорилгоор түвшингийн хэмжилтийг 7 хоногт 2 удаа, ундаргын тооцооллыг сард 1 удаа, усны шинжилгээг улиралд 1 удаа тус тус хийж гүйцэтгэн ажиллаж байна. Мөн хэмжилтийн үр дүнг боловсруулж, хагас жил болон жилийн эцсийн байдлаарх ус ашиглалтын тайланг боловсруулж, Өмнөговь аймгийн БОАЖГазарт, ГӨДГСГазарт, Усны газарт тогтмол тайлагнан ажиллаж байна.	0.5	100%
5.2.8		Булгийн эхийг сэргээх, хашиж хамгаалах /Мухар гашуу булаг/	Цогтцэций сумын нутагт байрлах Мухар гашуу булгийн эхийг сэргээх, хашиж, хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, орон нутагт хүлээлгэн өгнө.	Булгийн эхийг 32мм-ийн труба, 30 мм-ийн полоса төмөр ашиглан дунджаар 1.5 м өндөртэй, 140 м урттай хашаагаар хүн мал орохооргүй байдлаар байгальд ээлтэй аргаар бүхэлд нь хашсан. Хашааг зөвхөн гагнаж хийсэн бөгөөд газрын гүнд суулгах, бетондох ажил хийгдээгүй. Хашааны урд хэсэгт хүн гарч орох хаалгыг хийсэн.	0.5	100%
5.3.1	Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимын мөрдөлтийг хангуулах, хяналт тавиж ажиллах	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимыг хангуулж байгаль орчны чиглэлийн дотоодын журам, горимуудыг мөрдөнө.	Цанхийн уурхайд нийтдээ 26 ш шимт хөрсний овоолго үүссэн байна. Шимт хөрсний овоолгууд дээр нийт 5247.8 мян.м3 шимт хөрс хадгалагдаж байна.	0.5	100%

5.3.2		Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст өвслөг ургамал тарих	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимын мөрдөлтийг хангуулах, хяналт тавиж ажиллах.	Цанхийн баруун уурхайн шимт хөрсний TSP-4.1.4-4.1.5 болон TSP-4.2.4-4.2.6 гэсэн овоолгуудад нутгийн ургамал болох таана, хөмүүл, олон наст хялганы үрээр биологийн нөхөн сэргээлт хийсэн.	1	100%
5.3.3		Тусгай зөвшөөрлийн талбай дээрх ААН-ийн судалгаа хийх, Сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай хамтран зөрчил арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх	Тусгай зөвшөөрлийн талбай хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ААН-д тавих хяналтыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн томилогдсон ажлын хэсэг болон орон нутагтай хамтран хэрэгжүүлнэ.	Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа иргэн, аж ахуйн нэгж, объектын тооллогыг 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс 4 дүгээр сарын 4-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Нийт 446 иргэн, аж ахуйн нэгж, бусад обьектуудыг бүртгэлжүүлсэн.	0.5	100%
5.3.4		Ахилтад өртөх талбайн шимт хөрсийг >0.3 метр зузаантай хуулж, стандартын дагуу шимт хөрсийг хадгалах	Уурхайн дотоод зам талбайн ашиглалтын байдалд сар бүр тогтмол хуналтыг хийж мөрдүүлнэ.	Цанхийн зүүн уурхайд нийт 39 зөвшөөрөл олгогдож 398,710 м2 газар хөндөгдсөн, Цанхийн баруун уурхайд нийт 20 зөвшөөрөл олгогдож 84,870 м2 газар хөндөгдсөн байна. Шимт хөрс хуулсан даруйд зохих овоолго руу зөөн байршуулдаг.	0.5	100%
5.3.5		Дүүрсэн шимт хөрсний овоолгуудыг стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг харгалзан үзэж акт үйлдэн хаах	Шимт хөрс байрлуулсан талбай дүүрсэн тохиолдолд Маркшейдэр инженерийн хэмжилтийн дүн болон /ЭТТ-СА-Ж41-БО-Ж09-Х03/ “Өнгөн хөрстэй ажиллах журам”-ыг баримтлан акт үйлдэн хаана	Цанхийн зүүн уурхайд 19.1.8 дугаартай шимт хөрсний овоолго дүүрч тухайн овоолгыг хэлбэржүүлэн, акт үйлдэн хаах ажил хийгдсэн. Уг овоолгод нийт 33263.97 м3 шимт хөрс хадгалагдаж байна.	1	100%
5.3.6		Уурхайн хэмжээнд шимт хөрсний судалгаа хийж зөөгдөөгүй үлдсэн	Өнгөн хөрстэй ажиллах журам /ЭТТ-СА-Ж41-БО-Ж09-Х03/, Газар хөндөх	Шимт хөрс хуулах зөвшөөрлийн дагуу хуулагдсан талбайд байнгын хяналт тавьж, шимт хөрсийг гүйцэт хуулан, зохих овоолгод байршуулан хадгалдаг.	0.5	100%

		шимт хөрсийг зохих овоолгод байршуулах	журам /ЭТТ-СА-Ж11-БО-Ж07-Х03/-ын батлагдсан маягтын дагуу олгож, олгосон зөвшөөрлийн дагуу бүртгэлийг хийж, хяналт тавьж ажиллана.			
5.4.1	Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Зөвшөөрөлгүй газар хөндөхөөс сэргийлж, аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл олгох, хөндөгдсөн газрын бүртгэлийг мэдээллийн санд оруулах.	Газар хөндөх зөвшөөрлийг баталсан журам, зохион байгуулалтын дагуу хэрэгжүүлэн, газар хөндөх зөвшөөрлийн үйл явцад сайжруулалт хийж газрын хэмжээг GIS систем болон нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.	Салбарын захирлын 2021.12.11-ний өдөр А/145 дугаар тушаалаар батласан “Газар хөндөх журам”-ын дагуу газар хөндөх зөвшөөрөл олгосны үндсэн дээр газар шорооны ажлыг хийж гүйцэтгэдэг. Зөвшөөрлийг бүртгэлжүүлж мэдээллийн сан үүсгэдэг.	1	100%
5.4.2		Тусгай зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал, ус, ургамал ашиглахгүй байх, хяналт хийх.	Холбогдох зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахгүй байлгах үүднээс Уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн хяналт хийх журам /ЭТТ-СА-Ж05-БО-Ж01-Х01/-ын дагуу тогтмол хяналт хийнэ.	2024.03.14-ний өдөр А/300 дугаартай Өмнөговь аймгийн Засаг даргын захирамжаар НБҮ-ийн авто замын бүтээн байгуулалтад ашиглах ТТАМ ашиглах түр зөвшөөрөл авсан. Үүний дагуу 2024.05.03-ны өдөр Цогтцэций сумын Засаг даргатай ЭТТ-2024/1104 дугаартай ТТАМ ашиглуулах гэрээг байгуулан ажиллаж байна.	1	100%
5.5.1	Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Уурхайн ахилтанд өртөж болзошгүй ховор болон, нэн ховор ургамлын байршлыг тогтоож, мэдээллийн санд оруулах, өртөх	Уурхайн ахилтад өртөх талбайд ховор, нэн ховор ургамлын тархалтын судалгааг хийж тухайн талбайд бүртгэгдсэн ургамлыг Байгалийн ургамлыг хамгаалах, удмын	Шимт хөрс хуулах болон газар хөндөх зөвшөөрөл авах үед хөндөгдөх талбайд ховор ургамалын судалгааг хийж, бүртгэлжүүлж, шилжүүлэн суулгах арга хэмжээг төлөвлөгөж ажилладаг ба энэ онд хөндөгдөх талбайд ховор ургамал тохиолдоогүй болно.	1	100%

		тохиолдолд шилжүүлэн суулгах	санг нэмэгдүүлэх зорилгоор мод үржүүлгийн талбайд шилжүүлэн суулгана.			
5.5.2		Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйлийн талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах	Байгалийн ургамлын тухай хууль, Зөрчлийн тухай хуульд ховор, нэн ховор ургамлыг зөвшөөрөлгүй түүж бэлтгэсэн тохиолдолд хүлээх хариуцлагын тухай сургалтын материал боловсруулж сургалт орно.	Байгалийн ургамлын тухай хууль болон, тус оны БОМТ-ний дагуу уурхайн ахилт, тэлэлтэд өртөж болзошгүй ховор болон, нэн ховор ургамлын төрөл зүйлийн талаар мэдлэг олгох сургалтыг 500-аас доошгүй ажилтанд зохион байгуулахаар тусгасан бөгөөд, тус сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж ажилласан. Мөн гэрээт байгууллагын БОМ нар сургалтыг орж нийт 1185 хүн хамрагдсан.	1	100%
5.6.1	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Өвөлжилт хүрдэрсэн үеп биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх.	Биотехникийн арга хэмжээг орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан албан хаагч нартай хамтран авч хэрэгжүүлнэ.	Цанхийн уурхайн гэрээт туслан гүйцэтгэгч байгууллагуудыг хамруулан төлөвлөгөө гаргаж батлуулах хамтран хэрэгүүлсэн. Цогтцэций сумын Сийрст багийн “Хангинах”-ын хад, Билгэх багийн “Унаган Хайрхан”-нд тус тус нийтдээ 8 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан. Нийт 750 боодол өвс байрлуулсан.	1	100%
5.6.2		Шувууны өртөлтийг багасгах зорилгоор өндөр хүчдэлийн шугамаар хяналт хийх, шаардлагатай тохиолдолд нэмж шувуу үргээгч байршуулах	Цахилгааны шугам дагуу шувууны өртөлтийн судалгааг хийж, гарсан үр дүнд үндэслэн шаардлагатай газруудад стандарт шаардлагад нийцсэн шувуу үргээгч байрлуулна.	Цанхийн баруун уурхайн гэрээт “КА майнинг” ХХК 49.3 км агаарын шугамд, “Үндэсний оператор түншлэл” 6 км, “Овоот толгой ресурс” ХХК 15.3 км, “Спейшл майнинг сервис” ХХК 6.2 км, Цанхийн зүүн уурхайн олборлогч “ТН Түншлэл” 12.3 км агаарын шугамд шувуу өртөлтийн судалгааг хийж гүйцэтгэсэн.	1	100%
5.6.3		“Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудад хулгайн ангаас сэргийлэх	Төслийн хэмжээнд гэрээт болон туслан гүйцэтгэгч компаниудын байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран хууль бус	Хулгайн антай тэмцэх сургалтыг гэрээт компанийн Байгаль орчны мэргэжилтэнүүдтэй хамтран бүх ээлжинд зохион байгуулсан.	1	100%

		хууль эрхзүйн сургалтыг орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах	хулгайн антай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон хориотой ан амьтны талаарх сургалтыг зохион байгуулна.			
5.6.4		Хулгайн ан, байгаль орчны гэмт хэргийг бууруулахад орон нутгийн байгаль хамгаалагч нартай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх	Цогтцэций сумын байгаль хамгаалагчтай хамтран хулгайн ан, байгаль орчны гэмт хэргийг бууруулах ажилд оролцоно.	Орон нутгийн байгаль хамгаалагч нартай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Байгаль хамгаалагч нарын эргүүл хийх түлш шатахуун болон бусад зүйлсд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг гэрээт байгууллагуудтай хамтран шийдвэрлэж ажилласан.	1	100%
Бүлгийн нийт дүн					**19.6**	**97.0%**
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөө						
6.1.1	Техникийн нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.	Цанхийн зүүн болон, баруун уурхайн талбайн хэмжээнд үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж ашиглагдахгүй болсон газрын судалгааг, гэрээт туслан гүйцэтгэгч компаниудтай хамтран гаргана. 3-аас багагүй га талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ.	Тайлант онд уурхайгаас Цогтцэций сум орох 13.5 км автозамаас Шар тээг-Цогтцэций чиглэлийн замыг холбосон 2.2 км хатуу хучилттай автозамыг “Эрдэнэс Тавантолгой” ХК нь өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн хийлгэж байгаа ба гэрээний хүрээнд 2024 оны 10-р сарын 31-нд хийж дуусгах төлөвлөгөөтэй байна. Уг замыг ашиглалтынд орсоны дараа тухай бүсэд зорчиж байсан шороон замуудад техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж сум орон нутагт хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй ажиллаж байна.	6	80%
6.2.1	Биологийн нөхөн сэргээлт	Үрийн нөөц бүрдүүлэх	Говийн бүсэд ургадаг модлог ургамал болон нутгийн унаган ургамлын үрийг 10 кг-аас багагүйг түүж нөөц бүрдүүлнэ.	Говийн бүсэд дасан зохицох модлог ургамлын үр, олон наст зүлэг, цэцгийн мандалын үр түүж бэлтгэх, худалдан авах ажлыг авч хэрэгжүүлсэн.	7.5	100%
6.2.2		Модлог ургамлын мөчир бэлтгэх,	Сэжмээр ургах боломж бүхий модлог	Гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу үрийн нөөц бүрдүүлэх,	7.5	100%

			ургамлын мөчир бэлтгэх ажлын хүрээнд 5000-10000 ширхэг мөчир бэлтгэж хадгална.	үр түүх ажлыг дүйцүүлэх байдлаар нийт 6000 ш улиас, сухайны бэлтгэсэн модлог мөчрийг мэргэжлийн байгууллагаас нийлүүлэх ажлыг хаврын тарилтын үед авсан.		
6.2.3		Хоолны хаягдлаар компост бордоо бэлтгэх, бордоог нөхөн сэргээлтэд ашиглах	Цэцэрлэгжүүлэлтийн үлдэгдэлд / хугарсан мөчир, хатсан навч, холтос/, хог ургамал гэх мэтийг ашиглан 1 тн-оос багагүй био компост бордоог гарган авч мод үржүүлэгт ашиглана.	Хоол хүнсний хаягдалд өндөгний хальс, өндөгний савлагааны цаасан сав буюу сетка, Төрөл бүрийн агшаасан будааны үлдэгдэл, Төрөл бүрийн жимс болон ногооны хальс, Төрөл бүрийн түүхий будаа болон гоймон, гурилны хатсан үлдэгдэл, үйрмэг зэрэг бүтээгдэхүүний хаягдлыг жижиглэн хэрчиж холиод, хар шороо, бууц, үртэс зэргийг үечлэн давхарлан хийж, услан чийглэж бэлтгэн ялзруулан исгэх аргаар боловсруулсан. Бордоог 1 тн-ын хэмжээтэй 2 ш саванд бэлтгэсэн бөгөөд мод үржүүлгийн 10 г талбайн хамгаалалтын зурвасаар тарьсан модыг бордсон.	7.5	100%
Бүлгийн нийт дүн					**28.5**	**95%**
7. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө						
7.1.1	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дунд болон урт хугацааны төлөвлөгөө гаргах	Дүйцүүлэн хамгаалан талбайд цаашид хэрэгжүүлж ажиллах дунд болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулж мөрдлөг болгон ажиллана.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах зөвлөх үйлчилгээний гэрээг “Эх Монголын Байгаль” ХХК-тай 2023 оы 11-р сарын 28-ны өдөр байгуулан ажиллаж байна. Энэ гэрээний ажлын даалгаврын 14-р зүйлд “Биологийн олон янз байдлыг хамгаалах урт хугацааны төлөвлөгөө, шаардагдах эдийн засгийн тооцооллын тайлан хийж захиалагч талд ирүүлэхээр тусгасан. Үүний дагуу 2024 оны 11-р сарын 18-ны өдөр Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дунд болон урт хугацааны төлөвлөгөө, эдийн засгийн тооцооллыг ирүүлсэн.	1	100%
7.2.1		2023 онд хийгдсэн дүйцүүлэн хамгаалах ажлын тайланг малчдад танилцуулах	Дүйцүүлэн хамгаалах талбайн байршилд өмнө жил хийгдсэн ажлын талаар тухайн газрын ойр орчимд суурьшсан малчдад тайлагнах ажлыг зохион байгуулна.	2023-2024 онд Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалллын чиглэлээр хийгдсэн ажлыг 2024 оны 11-р сарын 27-ны өдөр Цогтцэций сумын засаг даргийн тамгын газрын мэргэжилтнүүд болон малчин иргэдэд танилцуулсан. гүйцэтгэгчийн мэргэжилтнүүд зохион байгуулав.	1	100%
7.3.1		Хулгайн ангийн мэдээллийг хүлээж	Зэрлэг ан амьтдыг хамгаалах ажлын	Байгаль орчны гомдол санал авах шуурхай дугаарыг 2023 оноос эхлэн ажиллуулж эхэлсэн бөгөөд одоогийн	2	100%

		авах 24 цагийн утсыг ажиллуулах, экологийн цагдаад мэдээллэх	хүрээнд сум орон нутгийн экологийн цагдаагийн албатай хамтран ажиллана. Амьтдыг хамгаалах зорилгоор 24 цагийн мэдээллийн утасыг ажиллуулж экологийн цагдаад мэдээллэнэ.	байдлаар хулгайн антай холбоотой дуудлага мэдээлэл ирүүлээгүй байна. Байгаль орчны мэдээллийн утас нь компанийн мэдээллийн дугаар болох 7505-5555 дугаараар холбогдож 104 дугаарт холбосноор шууд Салбарын Байгаль орчин, усны бодлогын хэлтэстэй холбогдох болно. Мөн Салбарын Онцгой байдлын нэгжийн шуурхай утсыг давхар ашигладаг бөгөөд Онцгой байдлын нэгж нь 24/7 тогтмол утсаар мэдээллийг авч ажилладаг		
7.4.1		Бэлчээр усжуулах худаг гаргах	Уст цэгийг нэмэгдүүлэх, бэлчээр усжуулах зорилгоор 1ш худаг гаргаж ашиглалтанд оруулахаар төлөвлөсөн.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд бэлчээр усжуулалтын зориулалттай худгийн байршлыг сонгохдоо Цогтцэций сумын болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн байгаль орчны мэргэжилтнүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр сонгосон. Сонгосон талбай нь Цогтцэций сумын төвөөс зүүн хойд зүгт 29.0 км зайд Билгэх багийн нутаг дэвсгэр Төгрөгийн худаг орчим байрлана.	2	100%
7.4.2		Бэлчээр хашиж, ургамлын нөмрөгийг сайжруулах	Дүйцүүлэн хамгаалах талбайд ургамлан нөмрөгийг сайжруулах зорилгоор 2 га газрыг хашиж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ.	“Эрдэнэс Тавантолгой” ХК нь биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах ажлын Бэлчээрийн нөхцөлийг сайжруулах багц ажлын хүрээнд уурхайн нөхөн сэргээлтийн зориулалтаар тарих олон наст ургамлын үрийн нөөц бэлтгэх үр үржүүлгийн ажил эхлүүлэх туршилт, бэлчээрийг шар ба хөх бууцтай олон наст ургамлын үрээр хачирлан тарьж сайжруулах, говийн нөхцөлд малын тэжээл бэлтгэх зориулалтаар нэг наст ургамлуудыг тарьж турших ажлуудыг төлөвлөн гүйцэтгэж байна.	2	100%
Бүлгийн нийт дүн					**8**	**100%**
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө						
8.1	Цагаан овоо багийн иргэдтэй гэрээ байгуулах, нөхөн олговор олгох		Цагаан-Овоо багийн иргэдийг нүүлгэн шилжүүлэхэд хамтран ажиллаж, 40 иргэнд нөхөн олговор олгосон байна.	Нийт 267 айл өрх, хувь хүн хөрөнгийн үнэлгээнд хамрагдсанаас 249 хүн гэрээ байгуулсан. Гэрээ хийгээгүй 18 хүн байна. Эдгээр хүмүүсээс 12 иргэн хөрөнгийн үнэлгээг хүлээн зөвшөөрөөгүй тул шүүх дээр маргаан үүсгэсэн шүүхийн ажиллагаа явагдаж байна. Үлдсэн хүмүүс бичиг баримтын бүрдэл дутуу тул гэрээ байгуулаагүй байна. Гэрээ байгуулсан боловч нүүж гэрээний үлдэгдэлээ аваагүй 25 иргэн байна.	5	100%

Бүлгийн нийт дүн					**5**	**100%**
9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө						
9.1	Газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл мэдээлэх.		Соёлын дурсгалт зүйл олдсон тохиолдолд олборлох ажлаа зогсоож энэ тухай, аймгийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.	Одоогийн байдлаар түүх, соёлын өвийн холбогдолтой элдэв зүйлс тохиолдоогүй байна.	2.5	100%
9.2	Цогтцэций суманд Монголын шагайн харвааны холбооны Салбар зөвлөлийг байгуулах		Гэрчилгээ гаргуулсан байна.	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн салбарын захирлын 2024 оны 08 дугаар сарын 12-ний өдрийн Дугаар 03/233 тоот “Монголын Шагайн Харвааны” холбоонд хүргүүлсэн гишүүнээр элсэх тухай утга бүхий албан тоотын дагуу, холбооны гишүүнээр элсэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.	2.5	100%
Бүлгийн нийт дүн					**5**	**100%**
10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө						
10.1.1	Нүүрс устөрөгч, Химийн бодис хяналтгүйгээгээр асгарах	ХАЛМ-ийг химийн бодис ашигладаг ажлын байруудад байрлуулах, сургалт зохион байгуулах.	>500 хүнд сургалт зохион байгуулна.	“Химийн хортой, аюултай бодисын хэрэглээ”, “Хаягдал зай хураагуур” гэсэн сэдвээр 2 удаагийн сургалт хийж, давхардсан тоогоор нийт 852 ажилтан сургалтад хамруулсан. Мөн Химийн хортой, аюултай нүүрс-устөрөгчийн бодис материал ашиглагдах буюу ХАЛМ-г бүрэн буюу 100% бүрдүүлж зохих байршлуудад байршуулсан.	1	100%
